

# СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН



Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги

Улаанбаатар хот  
2023

## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ .....	2
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ .....	5
ЗОРИЛТ 1: Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал болон хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байгаа хууль, эрх зүйн зохицуулалтуудыг шинэчлэх санал боловсруулах зорилтын хэрэгжилт .....	10
ЗОРИЛТ 2: Төрийн аудитын тогтолцоонд арга зүй, стандартын шинэчлэлийг хийж, олон улсын чиг хандлагад нийцсэн дэвшилтэт технологи бүхий орчин үеийн төрийн аудитын тогтолцоог төлөвшүүлэх зорилтын хэрэгжилт .....	18
ЗОРИЛТ 3: Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх төрийн аудитын байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих зорилтын хэрэгжилт .....	30
ЗОРИЛТ 4: Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжиж, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх зорилтын хэрэгжилт .....	41
ЗОРИЛТ 5: Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх зорилтын хэрэгжилт .....	62
ЗОРИЛТ 6: Төрийн аудитын байгууллагын дотоод засаглал, дэмжих үйлчилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоог төгөлдөржүүлэх зорилтын хэрэгжилт .....	82
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ .....	90

## ӨМНӨХ ҮГ

Үндэсний аудитын газар нь Монгол Улсын аудитын дээд байгууллагын хувьд Улсын Их Хуралд дэмжлэг үзүүлж, эх орон ард түмний эрх ашгийн төлөө Засгийн газрын хүлээх хариуцлага, үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд туслах, олгогдсон бүрэн эрхийн хүрээнд улс, нийтийн хөрөнгийн захиран зарцуулалтад хяналт тавих үүргээ хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх, төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартад нийцүүлэн ажиллаж, үр дүнг жил бүр илт, нээлттэй тайлагнаж ирлээ.

Төрийн аудитын байгууллагын нийт бие бүрэлдэхүүн стратеги төлөвлөгөөнөөс үүдэлтэй тодорхойлсон зорилго, зорилт, төсөл арга хэмжээг жил бүр ахиц гарган хэрэгжүүлэхийн хэрээр алсын хараа болох “Монгол Улсын хөгжлийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн өндөр үр нөлөөтэй төрийн аудитыг гүйцэтгэж, арга зүй, технологи, үйл ажиллагаагаар бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх аудитын дээд байгууллага болно” гэсэн үр дүндээ хүрэхэд улам ойртсоор байна.

Гүйцэтгэлийн арга хэмжээг зохион байгуулалтын нэгжүүд, тэдгээрийн албан хаагчид хянаж, тайлагнасаар ирсэн бөгөөд тус стратегийн төлөвлөгөө нь олон онцгойлсон арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлсэн манай хамт олны хувьд хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй энэ нийгэмд төрийн аудитын үйл ажиллагааг тогтвортой, төлөвшсөн, мэргэжлийн байгууллагыг бий болгох зорилготой шийдвэрүүдийг батлан хэрэгжүүлж эерэг, тогтвортой өсөлтийг дэмжиж, бүх албан хаагчдынхаа алсын хараатай шинэ санаа санаачилгуудыг бодитойгоор дэмжин төлөвшүүлж ажиллалаа.

Төрийн аудитыг нэгтгэн удирдах тогтолцоог төлөвшүүлж цахимжуулах, улс орнуудын аудитын дээд байгууллагуудын нэгэн адил улс, нийтэд учирч болзошгүй эрсдэлд суурилсан, аливаа хямралын эсрэг аудитыг зорилтот сэдвийн хүрээнд буюу олон нийтийн анхааралд байгаа нийтийн ашиг сонирхлыг хөндсөн бодит цаг хугацааны стратегийн аудитуудыг үр нөлөөтэй гүйцэтгэжээ.

Төрийн аудитын байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, дунд хугацааны стратегийн зорилтуудаа дэмжиж тууштай, бодит ажлыг хэрэгжүүлэх зорилгоор:

- 2019 оныг “Аудитыг баримтжуулах бодлого, арга зүйг боловсронгуй болгож, төлөвшүүлэх”
- 2020 оныг “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил”
- 2021 оныг “Аудитыг цахимжуулж, нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх”
- 2022 оныг “Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах”
- 2023 оныг “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах” жил болгосон нь тухайн цаг үетэйгээ нийцэж хараат бус байдлаа хангах, аудитын үйл ажиллагаанд стандартын шинэчлэл хийх, чанарын хяналтын тогтолцоог төлөвшүүлэх, дотоод үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн шийдлийг нэвтрүүлэн цахим орчинд ажиллах горим, соёлыг хэвшүүлэх зэргээр хуулиар олгогдсон чиг үүргээ гүйцэтгэхэд нөлөөлөхүйц чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүд болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн богино хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэл, хэрэгжилтийн явц, үр дүнгийн байдалд хийх бүх төрлийн аудит болон бүхий л шатны төсөв захирагчдын төсвийн хариуцлага, сахилга бат, үр ашиг, үр нөлөө, төрийн байгууллагуудын дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөт байдал нь бидний хуулиар хүлээсэн хяналтын чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаатай салшгүй холбоотой, байнгын харилцан хамааралтай байдлыг онцгойлон анхаарч ажиллав.

Бид эдгээр жилүүдэд хянан удирдах түвшний албан хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах, аудитын чанарын хяналтын хариуцлагыг дээшлүүлж, орон нутаг дахь Төрийн аудитын газрууд нэгдсэн удирдамжаар аудитыг стандарт, журамд нийцүүлэн гүйцэтгэж зохих үр дүнд хүрсэн, улмаар улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжсэн, илүү үнэ цэнтэй, үр өгөөж өгөхүйц аудитыг гүйцэтгэхэд суурь үндэс болсон чанарын хяналтын үр нөлөөтэй тогтолцоог үе шаттай хөгжүүлэх суурь арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн.

Стратеги зорилтот үйл ажиллагааны хүрээнд системийн хэрэглэгчийн болон хүний нөөцийн, шалгагдагч этгээдийн бүртгэлийн, санхүүгийн тайлангийн аудитын, шилэн дансны аудитын, статистик тоон мэдээллийн, сонгуулийн зардлын тайланд хяналт тавих, гүйцэтгэлийн аудитын систем зэрэг аудитад ашиглах дэд систем, программ хангамжийг шинээр болон шинэчлэн хөгжүүлж, технологийн дэвшлийг ашиглан илүү бүтээмжтэй ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлж чадлаа.

Энэхүү бүрдүүлсэн боломж, хөгжил дэвшил нь ирээдүйд зориулан барих бат бөх суурийг бий болгоход тусалдаг ч бид улам бүр үнэ цэнтэй болж буй төрийн аудитын талаарх тодорхойлсон үр нөлөө, үр дүндээ хүрэхийн тулд илүү ихийг хийх шаардлага гарсаар байна.

Төрийн аудитын байгууллага дэлхийн улс, орнуудын аудитын дээд байгууллагын хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүн болохын хувьд олон улсын төрийн аудитын шилдэг туршлагыг нутагшуулж, улмаар дэлхийн нэр хүнд бүхий хамтын нийгэмлэг, олон болон хоёр талт хамтын ажиллагаа төрийн аудитын хөгжилд хувь нэмрээ оруулан ажилласаар байна.

Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага төрийн аудитын салбарт тулгарч буй гол асуудлууд, тэдгээрийн боломжит шийдлүүдийг хэлэлцэж, дэлхийн хэмжээнд засгийн газруудын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор туршлага солилцох, тулгамдсан асуудлуудыг хэлэлцэх, шийдвэр, зөвлөмж гарган үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, түүнчлэн олон нийтийн гамшгийн эсрэг үйл ажиллагаанд аудитын дээд байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, ИНТОСАИ-н дэлхий нийтэд хүргэх дуу хоолой, үр дүнг хэлэлцэж тодорхой шийдлүүд гаргаж байгаа бөгөөд Монгол Улсын Төрийн аудитын байгууллага олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд олон улсын төрийн аудитын салбарын хөгжлийн чиг хандлагатай үйл ажиллагаагаа уялдуулан стратегийн хүрээнд тодорхойлсон бүс нутагтаа тэргүүлэх аудитын дээд байгууллага болох алсын зорилгодоо хүрэх алхмаа урагшлуулсаар байна.

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Төрийн аудитын дээд байгууллага буюу нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай, төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой **хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага** юм.

### АЛСЫН ХАРАА

*Монгол Улсын хөгжлийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн өндөр үр нөлөөтэй төрийн аудитыг гүйцэтгэж, арга зүй, технологи, үйл ажиллагаагаар бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх аудитын дээд байгууллага болно.*

### ЭРХЭМЛЭХ ҮНДСЭН ЗАРЧМУУД

Хууль дээдлэх;  
Шударга ёсыг хангах;  
Илт тод, бодитой байх;  
Хараат бус бие даасан байх;  
Мэргэшсэн байх;  
Мэдээллээр бүрэн хангагдах;  
Төрийн аудитын нийтээр хүлээсэн зарчим стандартад нийцсэн байх;

### ЭРХЭМ ЗОРИЛГО

*Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлж, харилцагч талуудын хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэдийн амьдралыг сайжруулна.*

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө нь ирэх жилүүдэд аудитын дээд байгууллагын эн тэргүүнд тавих зорилгыг тодорхой болгож, сайжруулалтыг тодорхойлох гол баримт бичиг бөгөөд түүнд тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх нь байгууллагын үндсэн чиг үүрэг юм. Стратегийн 6 гол үндсэн зорилго, санаачилга, болон гүйцэтгэлийн хэмжүүр, арга хэмжээ нь Аудитын дээд байгууллагын зорилго, үйл ажиллагааг ил тод байлгах, нөөцийн хүчин чармайлтыг төвлөрүүлэх, аудитын үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх, сайжруулахад чухал үр дүнтэй баримт бичиг юм.

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны 6 жилийн стратеги төлөвлөгөө алсын хараа, зорилтуудыг үйл ажиллагааны төсөл арга хэмжээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр дамжуулан байгууллагын бодлого, чиглэл, үндсэн үйл ажиллагаа, нөөцийн уялдаа холбоог удирдан чиглүүлдэг.


Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратегийн хэрэгжилтийн тайланг танилцуулж байна. Энэ тайланд 2019-2023 оны гүйцэтгэлийн тайлан, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хамруулан энэхүү стратегийг 5 жилийн хугацаанд эрчимтэй хэрэгжүүлэн хамтран ажилласан зохион байгуулалтын нэгжүүдийн албан хаагч, тэдний жил бүр ахиц дэвшил гаргах зорилго тавин үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан үр дүнг тооцон боловсруулжээ.

Төрийн аудитын байгууллагын стратегийн төлөвлөгөөний зорилго, зорилтуудыг гүйцэтгэлийн хэмжүүрийн 6 хүрээ болон өмнөх боловсруулсан баримт бичгүүдтэй харьцуулалт шинжилгээ хийж, ТАБ-ын 2019-2024 оны стратеги болон хэрэгжүүлэх матриц төлөвлөгөөг МУЕА-ын 2019 оны А/76-1 тушаалаар баталсан байна.

Тус төлөвлөгөөнд хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд урт, дунд хугацааны стратегийн 6 зорилт, түүний хэрэгжүүлэхэд чиглэсэн 37 арга хэмжээг тусгасан бөгөөд тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг тодорхойлсон байна.

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө дараах бүрдэл хэсэгтэй байна. Үүнд:

- ❖ Алсын хараа;
- ❖ Эрхэм зорилго;
- ❖ Стратегийн зорилт;
- ❖ Хэрэгжүүлэх үйл арга хэмжээ;
- ❖ Стратеги төлөвлөгөө.





## СТРАТЕГИЙН ЗОРИЛГО:

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар явуулах эрх зүйн болоод арга зүй, технологийн таатай орчныг бүрдүүлнэ.

Төрийн аудитын тухай хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд урт, дунд хугацааны стратегийн дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах 6 зорилтыг оновчтой, хэмжиж болохуйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг тооцож тодорхойлсон:

**ЗОРИЛТ 1:** Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал болон хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байгаа хууль, эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх санал боловсруулах

**ЗОРИЛТ 2:** Төрийн аудитын тогтолцоонд арга зүй, стандартын шинэчлэлийг хийж, олон улсын чиг хандлагад нийцсэн дэвшилтэт технологи бүхий орчин үеийн төрийн аудитын тогтолцоог төлөвшүүлэх

**ЗОРИЛТ 3:** Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх төрийн аудитын байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих

**ЗОРИЛТ 4:** Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжиж, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх

**ЗОРИЛТ 5:** Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх

**ЗОРИЛТ 6:** Төрийн аудитын байгууллагын дотоод засаглал, дэмжих үйлчилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоог төгөлдөржүүлэх

Тус стратеги төлөвлөгөөнд хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд урт, дунд хугацааны стратегийн 6 зорилт, түүний хэрэгжүүлэхэд чиглэсэн 37 арга хэмжээг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа хэмжиж болохуйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүр болон хүрэх үр дүнг тодорхойлж баталгаажуулсан байна.

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратегийн  
хүрэх үр дүн, үр нөлөө (Гүйцэтгэлийн хэмжүүр)


<p><b>1</b> Монгол Улсын Үндсэн хуульд Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлын талаар тусгагдсан байна.</p>	<p><b>2</b> Төрийн аудитын тухай хуулийг шинэчлэн сайжруулж, бусад холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналыг хүргүүлсэн байна.</p>	<p><b>3</b> Аудитын дээд байгууллагын олон улсын стандартыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлж, нутагшуулан холбогдох шинэчлэлийг хийх тогтолцоо бүрдсэн байна.</p>
<p><b>4</b> Санхүүгийн аудитын үйл ажиллагаанд Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартыг бүрэн нэвтрүүлж, түүнд нийцүүлсэн журам, зааврыг бүрэн боловсруулсан байна</p>	<p><b>5</b> Гүйцэтгэлийн аудитын журмыг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандартад нийцүүлэн шинэчилж, гарын авлагыг дахин боловсруулсан байна.</p>	<p><b>6</b> Нийцлийн аудитын журмыг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, гарын авлагыг гаргасан байна.</p>
<p><b>7</b> Цахим аудитын тогтолцоог бий болгож, гүйцэтгэл, нийцлийн аудитад цахим программ хангамжийг нэвтрүүлсэн байна.</p>	<p><b>8</b> Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хянах, мониторинг, эрсдэлийн удирдлагын үнэлгээ хийх тогтолцоог бий болгож төлөвшүүлсэн байна.</p>	<p><b>9</b> Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, бусад бодлогын баримт бичигт хийх аудитыг тогтмолжуулж, бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зөвлөмжийг нэмэгдүүлсэн байна.</p>
<p><b>10</b> Ажилтнуудын программ хангамж ашиглан дүн шинжилгээ хийх, түүнийг тайлбарлах ур чадварыг нэмэгдүүлсэн байна.</p>	<p><b>11</b> Монгол Улсын хөгжлийн урт хугацааны зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, байгаль орчны аудитыг 2-оос доошгүйг хийн Төрийн аудитын байгууллагын оролцоог нэмэгдүүлсэн байна.</p>	<p><b>12</b> Аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг дээшлүүлж жилд 2-оос доошгүй давтан аудитыг хийж, зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагааны нэгдсэн тайлан гаргадаг болсон байна.</p>
<p><b>13</b> Төрийн байгууллагын үйл ажиллагааны чанар, үр дүн дээшилж, төрийн байгууллагуудын хариуцлагатай, ил тод, шударга байдлыг бэхжүүлэн сайн засаглалыг дэмжсэн байна.</p>	<p><b>14</b> Харилцагч талуудын эргэх холбоо бүхий, үр дүнтэй харилцаа бий болж, иргэд, аудитын үйл ажиллагаанд оролцдог болсон байна.</p>	<p><b>15</b> Төрийн аудитын мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрдэж, олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн төрийн аудитын шинэчлэлийг хийснээр аудитын чанар сайжирсан байна.</p>



Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратегийг товчлон харуулбал:

Стратегийн зорилт	Арга хэмжээ	2019	2020	2021	2022	2023	2024	Төсөв	
Зорилт 1: Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал болон хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байгаа хууль, эрх зүйн зохицуулалтуудыг шинэчлэх санал боловсруулах	2	2	2	2	1	1		105.0	
Зорилт 2: Төрийн аудитын тогтолцоонд арга зүй, стандартын шинэчлэлийг хийж, олон улсын чиг хандлагад нийцсэн дэвшилтэт технологи бүхий орчин үеийн төрийн аудитын тогтолцоог төлөвшүүлэх	6	6	6	6	6	6	5	5	1,496.0
Зорилт 3: Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"-ыг хэрэгжүүлэх төрийн аудитын байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих	5	5	4	5	5	4	2		406.0
Зорилт 4: Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжиж, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх	9	11	11	11	11	11	9	8	107,921.6
Зорилт 5: Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх	7	7	5	7	7	6	4	1	2,215.0
Зорилт 6: Төрийн аудитын байгууллагын дотоод засаглал, дэмжих үйлчилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх	6	6	3	5	6	5	2	2	420.0
	35	37	31	36	36	33	22	16	112,563.6

Төрийн аудитын байгууллагын стратегийн хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, стратегийн хэрэгжилтийг Үндэсний аудитын газар удирдан зохион байгуулах ба стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэхээр тусгажээ.



**ЗОРИЛТ 1:** Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал болон хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байгаа хууль, эрх зүйн зохицуулалтуудыг шинэчлэх санал боловсруулах зорилтын хэрэгжилт

№	Зорилт	Гүйцэтгэлийн хэмжүүр	2019	2020	2023
1.1.1	Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2011 оны 66 дугаар тогтоолын 4 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Аудитын суурь зарчмын талаарх Лимагийн тунхаглал болон хараат бус байдлын талаарх Мексикийн тунхаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх	Төрийн аудитын хараат бус байдлын тухай Мексикийн тунхаглалын зарчмуудыг хэрэгжүүлсэн байх	4		
1.1.2	Олон Улсын аудитын дээд байгууллагуудын хөгжлийн чиг хандлага, бодлогод нийцсэн Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах, үүнтэй уялдуулан төрийн аудитын үйл ажиллагаатай холбогдох бусад хуулийн заалтуудыг боловсронгуй болгох	Шинэчлэн найруулсан Төрийн аудитын тухай хууль болон төрийн аудитын үйл ажиллагаатай холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байх	7	5	2
			11	5	2

**ЗОРИЛТ 1.1.1:** Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2011 оны 66 дугаар тогтоолын 4 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Аудитын суурь зарчмын талаарх Лимагийн тунхаглал болон хараат бус байдлын талаарх Мексикийн тунхаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** БНМАУ-ын Бага Хурлын 1990 оны 10 дугаар 4-ний өдрийн 16 дугаар тогтоолоор Ардын хянан шалгах байгууллагыг татан буулгасан бөгөөд шинэ Үндсэн хууль батлагдаж байх үед буюу 1992 онд Монгол Улсын төрийн хяналтын байгууллага байхгүй байсан. 1995 оны Төрийн хараат бус хяналт байгууллага буюу Төрийн хянан шалгах хороог байгууллагаа үйл ажиллагаа явуулж эхэлсэн ч Монгол Улсын Үндсэн хуульд ямар байдлаар тусгагдаагүй байна.

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** АДБ бодитоор хараат бус байхын тулд Үндсэн хуулиар байгуулагдаж, АДБ-ын бие даасан байдлаа Үндсэн хуулиар баталгаажуулсан байдал

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ❖ *Монгол Улсын Үндсэн хуульд төрийн аудитын талаар оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ дахь ажлын хэсэгт хүргүүлэх;*
  - *Судалгаа хийх,*
  - *Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд төрийн аудитын талаар тусгах хэрэгцээ, шаардлагын судалгаа*
  - *Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд оруулах томъёоллын хэлбэр, саналуудыг тодорхойлох,*
  - *Олон улсын аудитын дээд байгууллагуудын туршлага, судалгаа гэх мэт*
- ❖ *Монгол Улсын Үндсэн хуульд төрийн аудитын талаар оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх УИХ дахь ажлын хэсэг, УИХ-байнгын хороодын хуралдаан болон нэгдсэн чуулганд оролцох;*
- ❖ *Монгол Улсын Үндсэн хуульд төрийн аудитын талаар оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар УИХ дахь ажлын хэсэг, УИХ-д мэдээлэл хийх;*
- ❖ *Монгол Улсын Үндсэн хуульд төрийн аудитын талаар оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-аар батлуулах.*



Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд төрийн аудитын талаар тусгах санал боловсруулах ажлын хэсгийг МУЕА-ын тушаалаар байгуулан ажиллуулсан.

Төрийн аудитын үйл ажиллагаа нь үндсэн хуульд тусгагдах нь хараат бус төрийн хяналтыг хэрэгжүүлэх гол чухал хандлага хэмээн зүй ёсоор үздэг энэхүү тунхаглалын үзэл баримтлалд нийцэж ажиллах нь Төрийн аудитын байгууллагын байнгын зорилт юм.



**3** парламент дамжин хэлэлцэгдсэн



**4** төсөл өргөн барьсан



**600** төрийн болон ТББ, улс төрийн намууд, эрдэмтэн судлаачдаас



**306,000** иргэдээс ирүүлсэн санал ирсэн



Төрийн ордонд олон өдөр үргэлжилсэн хэлэлцүүлгээс ард түмэн засаглах эрхийг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж тогтвортой байдлыг хангах, нөгөө талдаа хяналтаа сайжруулж хариуцлагыг дээшлүүлэх замаар **төрийн эрх мэдлийн хяналт тэнцвэрийг оновчтой болгох** асуудал хамгийн их жин дарсан.

Ажлын хэсгээс Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд төрийн аудитын талаар тусгах хэрэгцээ, шаардлагын судалгаа хийж, үндэслэлийг боловсруулан Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд 3 заалт бүхий нэмэлт оруулах санал боловсруулав. УИХ-ын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг, УИХ дахь Монгол ардын нам, Ардчилсан намын бүлэг, бие даагч гишүүдэд тус тус хүргүүлэн хэлэлцүүлэв.



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
  - хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
  - төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
  - хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
  - эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.
- Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.


**25.1.7 “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”**

... МЭДЭГТҮН, САХИГТУН!

Үндсэн хууль бол төр, ард түмний оюун санааны хамтын бүтээл.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хууль”-д оруулсан нэмэлт өөрчлөлтийн холбогдох заалтад төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хуульчилсан нь Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлын зарчим, түүний хөгжлийн баталгааг бий болгох Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллагын уриалга, Лимагийн болон Мексикийн тунхаглалын чухал шаардлагад нийцсэн, төрийн аудитын байгууллагын хууль ёсны эрх зүйн үзэл баримтлал, тогтолцоог үндсэн хуулиар баталгаажуулсан болно.

### ИНТОСАИ, МЕХИКОГИЙН ТУНХАГЛАЛ



1	Тохиромжтой бөгөөд үр нөлөөтэй Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх	Үндсэн хууль
2	АДБ-ын тэргүүний хараат бус байдал, халдашгүй эрх	МУЕА бүрэн эрх
3	АДБ ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай бүрэн эрх, эрх чөлөө	ТАБ бүрэн эрх
4	Мэдээлэлд хязгаарлалтгүй нэвтрэх	Мэдээлэл авах боломж, мэдээллийн технологитой холбоотой зохицуулалт
5	Ажлаа тайлагнах эрх ба үүрэг	УИХ-ТБ хороо, open audit г.м
6	Аудитын агуулга, хугацааг шийдэх хэвлэх тараах эрх	Сэдэв сонгох МУЕА зөвшилцөх эрх үүрэг
7	АДБ-ын зөвлөмжийг дагаж мөрдөх үр дүнтэй механизм	Иргэний оролцооны стратеги
8	Санхүү, удирдлага, хүний нөөц, материал	Бүтэц зохион байгуулалт, хүний нөөц, санхүү төсөв

10

### ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Төрийн аудитын хараат бус байдлын тухай Мексикийн тунхаглалын зарчмуудыг хэрэгжүүлсэн байх



Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7-д “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж баталсан.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь төрийн аудитын байгууллагын төсвийн орлого, зарлагад ХЯНАЛТ ТАВИХ, төрийн санхүү, төсвийн хяналт (аудит)-ыг ХАРААТ БУСААР ХЭРЭГЖҮҮЛЭХ, түүний ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ, ТӨРИЙН БОДЛОГО ХЯНАЛТТАЙ, БОДИТОЙ хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх үндэслэл шаардлага хуульчлан баталгаажсан.



**ЗОРИЛТ 1.1.2:** Олон Улсын аудитын дээд байгууллагуудын хөгжлийн чиг хандлага, бодлогод нийцсэн Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах, үүнтэй уялдуулан төрийн аудитын үйл ажиллагаатай холбогдох бусад хуулийн заалтуудыг боловсронгуй болгох

## СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** Төрийн аудитын тухай хууль 2003 онд батлагдсан. Монгол Улсын Төрийн аудитын тухай хуульд 2013 онд нэмэлт өөрчлөлт оруулж, Аудитын дээд байгууллага болох Монгол Улсын Үндэсний аудитын газар босоо тогтолцоонд шилжиж, орон нутгийн аудитын газрууд Монгол Улсын Ерөнхий аудиторт үйл ажиллагаагаа тайлагнадаг болсон бөгөөд Төрийн аудитын байгууллага төрийн санхүү, төсвийн бүхий л үйл ажиллагаа, түүний үр дүнд санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудит гүйцэтгэдэг бүрэн эрхтэй хууль эрх зүйн орчинтой байна.

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох шаардлага

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн аудитын тухай хуулийг шинэчлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг МУЕА-ын 2019 оны А/77 дугаар тушаалаар байгуулж, хэрэгжиж буй Төрийн аудитын тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, хууль хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох судалгааны ажлуудыг эхлүүлж, хууль эрх зүйн боловсруулалтын чиглэлээр 3 үе шаттай хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хуулийн төслийг боловсруулахад дараах баримт бичгүүдийг боловсруулсан байна. Үүнд:

- ❖ Төрийн аудитын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгаа
- ❖ Төрийн аудитын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ
- ❖ Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан
- ❖ Канад, Их Британи, Гүрж, Финланд, Эстони, Чех, Солонгос улсын аудитын дээд байгууллагын хуулийн судалгаа, туршлага
- ❖ Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан гэх мэт.

Төрийн аудитын байгууллага 2020 оныг “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил” болгосны дагуу Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.

УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бүхэлд нь дэмжих санал хураалтаар гишүүдийн 78 хувь нь дэмжиж баталснаар “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Үндэсний аудитын газар Үндсэн хуулийн буюу хараат бус төрийн аудитын байгууллага болох хууль эрх зүйн шинэ орчин бий болсон.

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Нэгд, Төрийн аудитын үйл ажиллагаа хөндлөнгийн зүй бус нөлөөллөөс ангид байх баталгаа хангагдаж, хараат бус, бие даасан байдлаар төрийн санхүү, төсвийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа бодитоор хэрэгжих боломжтой болж байна. Хоёрт, Төрийн аудитын олон улсын стандартыг баримтлах, албан тушаалтны учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үүргийн хэрэгжилтийг мэдээлэх боломжтой болж төрийн аудитын шийдвэр бүрэн хангагдах нөхцөл бүрдсэн байна.

## ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ	ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗӨРМӨГ	ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬ
<p>“Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.”</p>	<p>Төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохиостой төлөвлөх, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, тогтоолоор, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оролно.</p>	<p>6 бүлэг, 43 зүйл, 225 заалт</p>
<p><b>Хараат бус байдал</b> Төрийн аудитын байгууллагын бие даасан, үйл ажиллагааны хараат бус байдлыг сайжруулах, эрх зэмсэгт нэмэгдүүлэх, зохион байгуулалт, үйл ажиллагаа тодорхой болсон.</p>	<p><b>Аудитын сэдэв сонголт</b> Аудитын төлөвлөлт болжсэрсонгүй болж, төлөвлөгөөт бус аудит хийж эрх зүйн орчин бүрдсэн.</p>	<p><b>Гамт хэргийн шалтгай үйлдэл</b> Аудит хийх явцад гамт хэргийн шалтгай үйлдэл илэрсэн тохиолдолд өолбогдох байгууллагад мэдэгдэж, эрүүгийн хэрг үүсгүүлэн шалгуулах боломжтой болсон.</p>
<p><b>Эрх зүйн орчин</b> Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх, нийтийн өмчийг зохиостойгоор төлөвлөх, тайлагнах, ашиглах, зарцуулах үйл ажиллагаанд тавих хяналтын эрх зүйн орчин бүрдсэн.</p>	<p><b>Мэдээллийн технологийн</b> Төрийн аудитын байгууллага үр дүнтэй, үр ашгтай аудитыг нийтийн түрд шийжлэх ухааны ололт, орчин үеийн мэдээллийн технологийн арга, ажилбарыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломж эрсэүйн үндэс бий болсон.</p>	<p><b>Нөлөөллийн мэдүүлэг</b> Төрийн аудитор бүрэн эрсээ хэрэгжүүлээд нь саад учруулсан аливаа дарамт, шахалт, хууль бус нөлөөллийн талаар нөлөөллийн мэдүүлэг илгэвнэ.</p>
<p><b>Эдийн засгийн баталгаа</b> Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлээд хэрэгцээтэй эдийн засгийн баталгаа хангагдсан.</p>	<p><b>Төрд үчирсэн хохирлыг нөхөн төлүүлэх</b> Төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн хэрэгжилтийг мэдээлэх боломж бүрдсэн.</p>	<p><b>Харууллага тооцүүлэх</b> Нийтийн өмч, төсвийг ашиглах, зарцуулахдаа сахилга бат алдсан албан хаагчид харууллага тооцоо мөхөөсөм тодорхой болсон.</p>
<p><b>Төрийн аудитын стандарт</b> Аудитын үйл ажиллагаа Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандартад хийгдсэн төрийн аудитын үндэсний стандартыг бий болгоно.</p>	<p><b>Акт, албан шаардлага, зөвлөмж</b> Аудитын албан шаардлага, төлбарийн акт заавал биелэгдэх эрх зүйн орчин тодорхой болсон.</p>	<p><b>Мэдээлэл авах эрх</b> Төрийн аудитын байгууллагын албан хаагч аудит хийх үедээ мэдээллээр бүрэн хангагдах боломжтой болсон.</p>

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хамт дагалдан Банкны, Газрын тосны, Төсвийн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, Аудитын, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 5 хуульд нэмэлт орсон.

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар 5 цуврал нийт 96 минутын подкаст, мөн цахим ном, танилцуулга /инфографик/ мэдээлэл бэлтгэн, хуулийн шинэчилсэн найруулгын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд 36 телевизийн мэдээллийн хөтөлбөр, 22 өдөр тутмын сонин, 8 видео, 59 мэдээний вэбсайт, 27 бусад цахим хуудсаар мэдээлсэн.

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотой тус хуулийн 39 дүгээр зүйлд заасан “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам”-ын төслийг боловсруулан баталж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

Эрх зүйн дэмжих үйлчилгээний хүрээнд ТАБ-ын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж болон эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар судалгаа хийн тэдгээрийг боловсронгуй болгож, шинэчлэн сайжруулах ажлыг эн тэргүүнд гол чиглэлээ болгосноор аудитыг дэмжсэн эрх зүйн шинэчлэлд тодорхой ахиц гарсан байна.

Хуулийн шинэчлэл, аудитын эрх зүйн орчныг сайжруулах стратегийн зорилтын хүрээнд Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдаж, мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан шинээр болон шинэчлэн батлах дүрэм журам, баримт бичгийг боловсруулах 15 дэд ажлыг гүйцэтгэхээр баталж, үе шатны ажлыг хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Үндэсний аудитын газрын хараат бус байдал ба хууль эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх стратегийн зорилтын хүрээнд 2019 онд 8 дүрэм, журам, зааврыг шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулсан.

ТАБ-ын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж болон эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар судалгаа хийх боловсронгуй болгож, шинэчлэх зорилтын хүрээнд байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа дүрэм, журмуудыг хуулийн шинэчлэлд нийцүүлэх, цаг үеийн шаардлагатай эрх зүйн актыг цаг алдалгүй боловсруулан баталж мөрдүүлэх, төлбөрийн актын хэрэгжилтэд төлөв байдлын судалгааг хийж ажилласны дүнд 2020 онд 23 дүрэм 2021 онд 17, 2022 онд 15 дүрэм, журам, заавар, аргачлалыг шинэчлэн боловсруулж баталсан байна.




**ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ**

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Шинэчлэн найруулсан Төрийн аудитын тухай хууль болон төрийн аудитын үйл ажиллагаатай холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байх

Монгол Улсын Их Хурлаас баталсан Үндсэн хуулийн өөрчлөлтөд нийцүүлж, УИХ-ын Нэгдсэн чуулганы 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, хуулиар тодорхойлсон “Төрийн санхүү, төсвийн хяналт” нь илүү өргөн утга агуулгатай болж төсөв болон төсвийн чиг үүрэг, хариуцлагатай холбоотой аливаа хуулийн этгээдийн санхүү, бүртгэл, нийтийн өмчтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг хамруулан аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэх эрх зүйн орчин бүрдлээ.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд нийт албан хаагчдыг хууль тогтоомж, дүрэм, журам, заавар зэрэг эрх зүйн баримт бичгийн мэдээлэлтэй түргэн шуурхай танилцах, судлах боломжоор хангахын тулд дотоод мэдээллийн сангийн “Хууль тогтоомж, дүрэм, журам” цэсэд тогтмол баяжуулалт, шинэчлэл хийж, нийт албан хаагчдын албан хэрэгцээнд зориулж зохих хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн багтаасан эмхэтгэлийг боловсруулан гаргаж, нийт албан хаагчид ашиглаж байна.

Шинэчлэн найруулсан Төрийн аудитын тухай хууль болон төрийн аудитын үйл ажиллагаатай холбогдох бусад 7 хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 75 дүрэм, журам, заавар, аргачлалыг шинээр болон шинэчлэн боловсруулж батлан мөрдөж байна.



**ЗОРИЛТ 2:** Төрийн аудитын тогтолцоонд арга зүй, стандартын шинэчлэлийг хийж, олон улсын чиг хандлагад нийцсэн дэвшилтэт технологи бүхий орчин үеийн төрийн аудитын тогтолцоог төлөвшүүлэх зорилтын хэрэгжилт

№	Зорилт	Гүйцэтгэлийн хэмжүүр	2019	2020	2021	2022	2023	2024*
1.2.1	Төрөлжсөн аудитын үе шат тус бүрд дэвшилтэт технологи нэвтрүүлж, цахим программд суурилсан аудитын арга зүй, аргачлалыг хөгжүүлэх	Мэдээллийн технологийн бодлоготой болсон байх, цахим аудитын тогтолцоо бий болж гүйцэтгэл, нийцлийн аудитад цахим программ хангамжийг нэвтрүүлсэн байна.	28	8	6	10	5	6
1.2.2	Төрийн аудитын үйл ажиллагаа чанартай, үр нөлөөтэй хэрэгжихэд шаардагдах стандарт, гарын авлага, арга зүй, арга хэрэгслийг зохих ёсоор бүрдүүлж, чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлэх	Төрийн аудитын үйл ажиллагаа чанартай, үр нөлөөтэй хэрэгжихэд шаардагдах стандарт, гарын авлага, арга зүй, арга хэрэгслийг бүрдүүлсэн байна.	12	2	8	2	1	2
1.2.3	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандартыг Төрийн аудитын байгууллагад нутагшуулах	Хуульд заасан эрх бүхий байгууллагаар стандартыг баталгаажуулж, шинэчлэх, нэвтрүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.	5	2	2	3	5	1
1.2.4	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартад нийцсэн санхүүгийн аудитын арга зүйг шинэчлэн боловсруулах	Санхүүгийн аудитын гарын авлага, төлөвлөлтийн үе шатны заавар, аргачлал бүрэн боловсруулагдаж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	8	2	1	3	1	2
1.2.5	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандартад нийцсэн гүйцэтгэлийн аудитын журам, гарын авлагыг шинэчлэн боловсруулах	Журам, гарын авлага бүрэн боловсруулагдаж, аудитын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байх	8		1		1	1
1.2.6	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандартад нийцсэн нийцлийн аудитын журам, гарын авлагыг шинээр боловсруулах	Журам, гарын авлага бүрэн боловсруулагдаж, аудитын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	4		1		1	1
			65	14	19	18	14	13

**ЗОРИЛТ 1.2.1:** Төрөлжсөн аудитын үе шат тус бүрд дэвшилтэт технологи нэвтрүүлж, цахим программд суурилсан аудитын арга зүй, аргачлалыг хөгжүүлэх

## СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** Санхүүгийн тайлангийн аудитын хувьд СТАУС программ нэвтрүүлсэн

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Бодлогын баримт бичиг боловсруулах шаардлага, Төрийн аудитад үйл ажиллагаанд хэрэгжүүлж буй стандарт заавар аргачлалыг бүрэн агуулсан программ хангамжийн ажлын даалгавар

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мэдээллийн технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд аудитын үйл ажиллагааг тухай бүр бүртгэх, аудитыг гүйцэтгэхэд мэдээллээр бүрэн хангагдсан байх нөхцөлийг бүрдүүлж, нэгдсэн удирдлагаар хангах, үйл ажиллагааны үр дүн, статистикийн мэдээллийн боловсруулалтыг сайжруулах, явцыг тухай бүр харах, хянах боломжтой байх, үйл ажиллагааг харилцагч талуудад нээлттэй ил тод болгох зорилгоор цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд шинэчлэл хийхээр зорьж, үйл ажиллагаагаа явууллаа.

ТАБ-ын үндсэн үйл ажиллагаа болон удирдлага, зохион байгуулалт, бүтцийн үйл ажиллагааг мэдээлэл бүртгэлийн нэгдсэн системд бүрэн тусгаж, аудитад шаардлагатай мэдээлэл, түүний эх үүсвэрийг тодорхойлж, харилцагч талуудын мэдээллийн системтэй холбогдох мэдээллийн дэд бүтэц, эрсдэлийн удирдлагын модулийг хөгжүүлэх ажлыг эхлүүлээ.

Төрийн аудитыг гүйцэтгэхэд шалгагдагч хуулийн этгээд, хүний хүчин зүйлсээс хамааралгүйгээр оновчтой сонголт хийх боломжийг бий болгож, аудитын үр нөлөө, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг дээшлүүлэх, урьдчилсан судалгаа, их өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ хийх ухаалаг тайлангийн дэд системийг хөгжүүлэх ажлуудыг хэрэгжүүллээ.

Төрийн аудитын байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтцийг бүрдүүлэх, сайжруулах, хэвийн, тасралтгүй үйл ажиллагаагаар хангах чиглэлд зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, харилцагч байгууллагуудтай нягт, үр дүнтэй хамтран ажиллалаа. Мэдээллийн технологийн дэд бүтэц нь техник хангамж, сүлжээ хангамж, өгөгдлийн сан, программ хангамжийн 4 технологи, дээрх технологиудыг нийлүүлэгч, тасралтгүй үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий мэдээллийн технологийн нэгж, байгууллагын үйл ажиллагааны процесс, түүнийг зохицуулах дүрэм журам, мэдээллийн технологийн бодлогын баримт гэсэн үндсэн бүрдэл цогц үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.




Техник хангамж: Серверийн On–Premise шийдлийг ашиглан программ хангамжийн ажиллагаа, өгөгдлийн сан, нөөцлүүрт тохируулан виртуал хэлбэрээр зохион байгуулан, хэвийн ажиллагааг ханган ажиллалаа. Программ хангамжийн хөгжүүлэлт, төрийн аудитын байгууллагын мэдээллийн технологийн ашиглалтын өсөлт дээр суурилан техник хангамжийн шинэчлэл, өргөтгөх ажлуудыг төлөвлөн, шаардлагатай техникийн тодорхойлолтуудыг боловсруулаа.

Программ хангамж: Мэдээллийн систем нь байгууллагын үйл ажиллагааны процесс, удирдлагын зан төлөвийг өөрчлөх замаар үнэ цэнийг бий болгодог бөгөөд төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны түвшинд ашиглагдаж буй программ хангамжуудын хувилбарыг ахиулан, систем хэрэглэгчдийн сайжруулалтын саналууд дээр тулгуурлан нэмэлт хөгжүүлэлтүүдийг хийж гүйцэтгэлээ. Санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт буюу акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгагдагч этгээдээс хүлээн авах модулийг нэвтрүүлсэн байна.

Сүлжээний дэд бүтэц: Аймаг нийслэлийн төрийн аудитын байгууллагад ашиглаж байгаа сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах чиглэлд өдөр тутмын хяналтыг гүйцэтгэв. Техник хангамжийн шинэчлэл, түүнийг өргөтгөх ажлын хүрээнд сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, зөвшөөрөлтэй техник хангамжийг сүлжээнд холбох зэрэг мэдээллийн аюулгүй байдлын нарийвчилсан тохиргоогоор дээрх ажлын төлөвлөлтүүдийг гаргалаа.

Өгөгдлийн сан: Мэдээллийн эх сурвалж, боловсруулалтын чанар, найдвартай байдал, төлөөллийг хангахуйц үйл ажиллагааны өгөгдлүүд бүхий өгөгдлийн сангуудыг үүсгэлээ.




АНТАГ болон ҮАГ-ын дотоод бүтцийн нэгжүүдээс аудитын талаарх мэдээллийг data.audit.mn системээр дамжуулан цуглуулж, аудитын явц, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тухай бүр нэгтгэн, үр дүнг байнгын тайлан хэлбэрээр 14 хоног тутам мэдээлж, хэвшсэн бөгөөд мэдээлэл нь хяналтын самбар байдлаар 48 цаг тутамд шинэчлэгдэж, системээс удирдлагууд аудитын талаарх ерөнхий мэдээллийг системээр харж, хянах боломжтой болсон

**ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ**


**ХҮРЭХ ҮР ДҮН** : Мэдээллийн технологийн бодлоготой болсон байх, цахим аудитын тогтолцоо бий болж санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитад цахим программ хангамжийг нэвтрүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллагын Дижитал мастер төлөвлөгөөг боловсруулан батлуулсан нь мэдээллийн технологийн дэд бүтцийн цогц үйлчилгээг харилцагч талуудад ил тод хүргэх замаар байгууллагын үр өгөөж, үнэ цэнийг нэмэгдүүлэх чухал алхам болжээ.



Цахим аудитын тогтолцоо бий болж аудитад цахим программ хангамжийг нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд шалгагдагч этгээд, шилэн дансны мэдээллийн санг үүсгэж, тусгайлсан аудит болох сонгуулийн хандивын зардлын хяналт гүйцэтгэх болон сургалт, хөгжлийн зэрэг 10 төрлийн системийг амжилттай хөгжүүлж, илүү үр бүтээлтэй ажиллах боломж нөхцөлийг бүрдүүллээ.

Мэдээллийн технологид нийцүүлэн аудитыг дэмжих, их өгөгдөлд суурилсан аудитын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлагналын тогтолцоог цахим хэлбэрт шилжүүлж, тэдгээр мэдээллийг ашиглан чиглэл зөвлөмж хүргүүлж, аудитыг хугацаанд нь гүйцэтгэж буй эсэх, хугацаа хоцорсон аудит болон үргэлжилж байгаа аудитын явцыг байнгын хянах, хэрэгжилтийн талаарх мэдээллийг нэгтгэх хөгжүүлэлтийг шинэчлэн ажиллалаа.



**ЗОРИЛТ** 1.2.2: Төрийн аудитын үйл ажиллагаа чанартай, үр нөлөөтэй хэрэгжихэд шаардагдах стандарт, гарын авлага, арга зүй, арга хэрэгслийг зохих ёсоор бүрдүүлж, чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлэх

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН** : АДБОУС 10-40, АДБОУС 100-400, АДБОУС 1000, 3000, 4000 орчуулж, хэвлүүлсэн.

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**: АДБОУС-ын нийцэл

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ИНТОСАИ-аас гаргасан “Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт”-ыг ҮАГ болон СХЗГ-тай хамтран Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн Банк, санхүү, даатгалын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлснээр Монгол Улсын “Төрийн аудит”-ын стандарт болгон баталгаажуулж уг /MNS 6817:2020/ стандартыг мөрдсөн.

АДБОУС-ыг Монгол Улсын “Төрийн аудит”-ын стандартаар баталгаажуулсан нь төрийн аудитын байгууллагын бодлого, арга зүйг боловсронгуй болгох, аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хэрэглэгчдийн итгэлийг бэхжүүлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үүрэг хариуцлагыг тодорхой болгоход чухал алхам болж төлөвшүүлэх, дагалдан гарах заавар аргачлалыг боловсруулах ажлыг гүйцэтгэсэн байна.

MNS 6817-1 : 2020  
АДБОУС 100

**ТУЛГУУР ЗАРЧИМ**

6817-2 : 2020  
АДБОУС 130

**ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

6817-3 : 2020  
АДБОУС 140

**ЧАНАРЫН  
ХЯНАЛТ**

6817-4 : 2020  
АДБОУС 200

**САНХҮҮГИЙН  
АУДИТЫН  
ТУЛГУУР ЗАРЧИМ**

6817-5 : 2020  
АДБОУС 300

**ГҮЙЦЭТГЭЛИЙН  
АУДИТЫН  
ТУЛГУУР ЗАРЧИМ**

6817-6 : 2020  
АДБОУС 400

**НИЙЦЛИЙН  
АУДИТЫН ТУЛГУУР  
ЗАРЧИМ**

6817-7 : 2020  
АДБОУС 3000

**ГҮЙЦЭТГЭЛИЙН  
АУДИТЫН  
СТАНДАРТ**

6817-8 : 2020  
АДБОУС 4000

**НИЙЦЛИЙН  
АУДИТЫН  
СТАНДАРТ**



Төрийн аудитын тухай хуулийн дагуу “Төрийн аудитын стандартын хороо”-ны дүрмийг баталснаар Үндсэн хуулиар тодорхойлсон төрийн санхүү, төсвийн хяналтыг өргөн агуулгаар гүйцэтгэхэд нийтээр хүлээн зөвшөөрсөн одоогийн мөрдөж байгаа болон шинээр гарах төрийн аудитын олон улсын стандартыг нэвтрүүлэх, боловсруулах хуульд нийцүүлэн эрх бүхий этгээдээр баталгаажуулж нутагшуулахад зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангахад Төрийн аудитын стандартын хороо мэргэжлийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.



Төрийн аудитын үйл ажиллагаа чанартай, үр нөлөөтэй хэрэгжихэд шаардагдах стандарт, гарын авлага, арга зүй, арга хэрэгслийг зохих ёсоор бүрдүүлж, чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлэхэд чиглэгдсэн дараах баримт бичгүүдийг боловсруулан баталж, аудитын ажиллагаанд мөрдөж байна. Тухайлбал,

- *Аудитын сэдэв сонгох ажиллагааны журам: А/104 дүгээр тушаал*
- *Аудитын үр өгөөжийн журам: А/82 дугаар тушаал*
- *..Сонгуульд нэр дэвшүүлсэн нам, эвсэл сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам: А/68 дугаар тушаал*
- *..Сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийх, дүгнэлт гаргахад мэдээллийг нууцлах, хамгаалах журам: А/51 дүгээр тушаал*
- *Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал: А/69 дүгээр тушаал*
- *Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал: А/70 дугаар тушаал*
- *Нийцлийн аудитын заавар, аргачлал: А/71 дүгээр тушаал*
- *..Сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах аргачлал: А/50 дугаар тушаал*
- *..Сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал: А/17 дугаар тушаал*

- Төрийн аудитын байгууллагын статистик мэдээг боловсруулах, тайлагнах журам:А/101 дугаар тушаал
- Харилцагч талуудад зориулсан аудитын хураангуй тайлан бэлтгэх заавар:А/100 дугаар тушаал
- Аудитын зөвлөлийн ажиллах журам:А/94 дугаар тушаал
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар:А/89 дугаар тушаал
- Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал:А/67 дугаар тушаал гэх мэт.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд аудитын чиг үүргийг хэрэгжүүлэхэд мөрдөж буй хэм хэмжээний актын шинэчлэлийг хууль тогтоомж, бодит төлөв байдал, хэрэгцээ шаардлагатай уялдуулан тасралтгүй сайжруулах, төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээг стратегийн зорилтын түвшинд байлган төрийн аудитыг олон улсын нийтлэг стандартад нийцүүлэн, үр нөлөөг нэмэгдүүлж, тогтвортой гүйцэтгэхэд онцгой анхаарч төрийн аудитын үйл ажиллагаа чанартай, үр нөлөөтэй хэрэгжихэд шаардагдах стандарт, гарын авлага, арга зүй, арга хэрэгслийг зохих ёсоор бүрдүүлж, чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлэн төлөвшүүллээ.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Төрийн аудитын үйл ажиллагаа чанартай, үр нөлөөтэй хэрэгжихэд шаардагдах стандарт, гарын авлага, арга зүй, арга хэрэгслийг бүрдүүлсэн байна.

Монгол улсын “Төрийн аудит” үндэсний стандартыг албан ёсоор мөрдөж эхэлснээр төрийн аудитын байгууллагын бодлого, арга зүйг боловсронгуй болгох, аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хэрэглэгчдийн итгэлийг бэхжүүлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үүрэг хариуцлагыг тодорхой болгоход чухал алхам болсон бөгөөд 2021 онд хуулийн шинэчлэл, стандартыг хэрэгжүүлэх хүрээнд АДБОУБ-аас гаргасан АДБОУС 200, 2000, Удир 3910, Удир 3920 болон төрөлжсөн аудитын заавар, аргачлалыг боловсруулан баталж, мөрдөж байна.

Төрийн аудитын байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, дунд хугацааны стратегийн зорилтуудаа дэмжиж тууштай, үнэн зөв горимоор ажиллахын тулд аудитын үйл ажиллагаанд холбогдох 70 гаруй дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулан баталж мөрдөж, төрийн аудитын бодлого, арга зүйг боловсронгуй болгох, аудитын чанар, үр нөлөөг сайжруулахад шаардагдах стандарт, гарын авлага, арга зүй, арга хэрэгслийг хангалттай бүрдүүлсэн байна.

Хуулийн дагуу болон бодлогоор гүйцэтгэх төрийн аудитыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, тайлагнахаас гадна улс, нийтэд учирч болзошгүй эрсдэлд суурилсан олон нийтийн анхааралд байгаа нийтийн ашиг сонирхлыг хөндсөн бодит цагийн аудитыг гүйцэтгэж хэрэгжүүлсэн нь сайн туршлага, сургамж болсон бөгөөд тооцоолоогүй сорилтыг даван туулж, тэргүүлэх чиглэлээ биелүүлэхэд онцгой хувь нэмэр боллоо.

**ЗОРИЛТ 1.2.3:** Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандартыг Төрийн аудитын байгууллагад нутагшуулах

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** АДБОУС 10-40, АДБОУС 100-400, АДБОУС 1000, 3000, 4000 орчуулж, хэвлүүлсэн, хэрэгжилтийг нь үнэлээгүй.


**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** АДБОУС-ын нийцэл

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

АДБОУБ-аас гаргасан УДИР-3910 “Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж”, УДИР-3920 “Гүйцэтгэлийн аудитын үйл явцын удирдамж”, стандарт, удирдамжуудыг орчуулан аудитын үйл ажиллагаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 “Санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.” заалт, Төрийн аудит MNS:6817 стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудиторуудад дэмжлэг болох санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын заавар, аргачлалыг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталгаажуулан төрийн аудитын үйл ажиллагаанд хэрэгжүүлж байна.

Гүйцэтгэлийн аудит нь төрийн чиг үүрэг, тогтолцоо, төлөвлөгөөний хэрэгжилт, хөтөлбөр, үйл ажиллагаа эсхүл зохион байгуулалт нь арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчмын дагуу явагдаж байгаа эсэх болон сайжруулах боломж байгаа эсэх талаар шалгадаг хараат бус, бодитой ба найдвартай хяналт бөгөөд аудиторуудад гүйцэтгэлийн аудитын үйл явцын турш үндсэн ойлголтуудыг хэрхэн харгалзан үзэх талаар илүү ойлголт, мэдлэг, туршлага, арга зүйг олж авахад энэхүү УДИР 3910 болон УДИР 3920 чухал үүрэгтэй баримт бичиг юм.





АДБОУС 200 “Санхүүгийн аудитын зарчим”, АДБОУС 2000 “Санхүүгийн аудитын стандартын хэрэглээ” стандартуудыг орчуулж, санхүүгийн аудитад ашиглахад бэлэн болов. Тус стандартуудыг орчуулж, хянах, санхүүгийн аудитад ашиглах ажлын хүрээнд эх стандарттай харьцуулж хянаж, Төрийн аудитын стандартын хорооны хуралдаанаар хэлэлцэн, баталсан.

АДБОУС 200-д тусгасан зарчмууд нь санхүүгийн аудитын илүү нарийвчилсан стандартууд болон тэдгээрийг хэрэгжүүлэх удирдамжийн суурь бөгөөд Аудит ба баталгаажуулалтын Олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан Аудитын Олон улсын стандартыг мөрдөх зааварчилгаа бүхий хэрэглээний тайлбарыг тус стандартад багтаасан. Тус стандарт нь санхүүгийн тусдаа эсхүл нэгтгэсэн тайлан, эсхүл тэдгээрийн тухайлсан бүрэлдэхүүн хэсэгт аудит хийхэд баримтлах тулгуур зарчмуудыг заасан баримт бичиг юм.

АДБОУБ-аас УДИР-3910 “Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж”, УДИР-3920 “Гүйцэтгэлийн аудитын үйл явцын удирдамж”, АДБОУС 200 “Санхүүгийн аудитын зарчим”, АДБОУС 2000 “Санхүүгийн аудитын стандартын хэрэглээ” стандартын товхимлуудыг хэвлүүлж, Төрийн аудитын байгууллагын аудиторуд болон хувийн аудитын хуулийн этгээдийн аудиторудад түгээн, нэвтрүүлж байна.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Хуульд заасан эрх бүхий байгууллагаар стандартыг баталгаажуулж, шинэчлэх, нэвтрүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.

АДБОУБ-аас гаргасан УДИР-3910 “Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж”, УДИР-3920 “Гүйцэтгэлийн аудитын үйл явцын удирдамж”, Санхүүгийн аудитын АДБОУС 200, АДБОУС 2000 стандарт, удирдамжуудыг орчуулан аудитын үйл ажиллагаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Төрийн аудитын бодлого, журам, заавар, аргачлалыг стандарт болон холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, төлөвшүүлэх, хөгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах, Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын талаарх мэдээллийг цуглуулж, шинэчлэл, өөрчлөлтийг баталгаажуулан нутагшуулах, стандартын хороог зохион байгуулах ажлуудыг хэрэгжүүлгээ.

АДБОУС-ыг үндэсний стандарт болгон хөрвүүлэн 2020 онд Стандарт, хэмжил зүйн газарт албан ёсоор бүртгүүлж, Төрийн аудит MNS 6817:2020 стандартыг аудитын үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн бөгөөд үндэсний стандартын хүрээнд АДБОУБ-ын шинээр гаргасан стандарт, удирдамжуудыг цаг тухай бүр нь судалж орчуулан боловсруулж аудитын үе шатны ажилд нэвтрүүлж байна

Санхүүгийн аудитын стандарт Удирдамж 2900 , УДИР 5250 “Улсын өрийн аудитын удирдамж”- Мэдээллийн тогтолцоонд аудит хийх 5100 удирдамжийг орчуулга хийгдсэн байна.

**ЗОРИЛТ 1.2.4:** Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартад нийцсэн санхүүгийн аудитын арга зүйг шинэчлэн боловсруулах

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** АОУС, АДБОУС-ын хүрээнд санхүүгийн аудитыг гүйцэтгэх заавар аргачлал баталж мөрдсөн.

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** АДБОУС-д нийцүүлсэн заавар аргачлал

#### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн аудитын стандартуудын хэрэглээ АДБОУС 2000-д зааснаар Ай Ди Ай байгууллагаас Санхүүгийн аудитын стандартуудыг хэрэгжүүлэх гарын авлагыг удирдамж болгон өмнө нь хэрэгжиж байсан санхүүгийн аудитын журам, заавар, аргачлалыг судалж, холбогдох стандартуудын шаардлага, гол өөрчлөлтийг харгалзан боловсруулж, санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлалыг боловсруулж, МУЕА-ын А/70 дугаар тушаалаар баталсан.

Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлалын эмхэтгэлийг бэлтгэн аудиторруудад түгээж, холбогдох сургалтуудыг танхимаар болон цахимаар зохион байгуулж, “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”-ыг санхүүгийн аудитын системтэй уялдуулж шинэчилсэн.



### ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН :** Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартад нийцсэн санхүүгийн аудитын арга зүйг шинэчлэн боловсруулах

Төрийн аудитын тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлд заасныг үндэслэн АДБОУС, АОУС, Төрийн аудитын MNS 6817-4:2020 стандартад нийцүүлэн МУЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг санхүүгийн тайлангийн аудитад хэрэгжүүлэхэд дэмжлэг болох Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”-ыг баталж мөрдүүлэн, улмаар холбогдох сургалтыг зохион байгуулж, тус заавар, аргачлалын дагуу санхүүгийн аудитыг FAS системээр гүйцэтгэж байна.

<sup>1</sup> 14.1 “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ гүйцэтгэхдээ Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын байгууллагаас хүлээн зөвшөөрсөн төрийн аудитын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий этгээдээс баталсан стандартыг баримтална.”

**ЗОРИЛТ 1.2.5:** Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандартад нийцсэн гүйцэтгэлийн аудитын журам, гарын авлагыг шинэчлэн боловсруулах

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** АДБОУС 3000, 3100 болон Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах журам мөрдөгдөж байна

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** АДБОУС-д нийцүүлсэн заавар аргачлал

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гүйцэтгэлийн аудитыг MNS 6817-5:2020, MNS 6817-7:2020 “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэхэд баримтлах үндсэн зарчим, аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, аудитын мөрөөр хяналт тавих ерөнхий арга зүйгээр хангахад энэхүү гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалын зорилго оршино.

Энэхүү гарын авлага нь гүйцэтгэлийн аудитын шалгаж буй асуудалтай холбоотой мэдээллийг судлах, байгууллага, хөтөлбөрийн үйл ажиллагаа, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэргэжлийн оновчтой шийдэл гаргах, цогц асуудлыг логик уялдаа холбоотой, бүрэн нотолгоо баталгаатай үр дүнтэй тайлагнахад чухал үр нөлөөтэй баримт бичиг юм



### ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН :** Журам, гарын авлага бүрэн боловсруулагдаж, аудитын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байх

Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандартад нийцүүлэн “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэлийн аудитыг хэрэгжүүлэхэд баримтлах “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг баталж, гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр аудитыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, үр нөлөөг үнэлэх, бодлогын хэрэгжилт, стандарт, горим арга зүйн төлөвшил, нөөцийг үр ашигтай хянан удирдах, улмаар заавар, аргачлалын дагуу аудитыг цахимаар гүйцэтгэж, зохистой нотлох зүйлээр хангагдсан үр нөлөөтэй дүгнэлт, зөвлөмж боловсруулж, түүний хэрэгжилтийг сайжруулахад үр дүнтэй арга хэмжээ болсон байна.

**ЗОРИЛТ 1.2.6:** Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандартад нийцсэн нийцлийн аудитын журам, гарын авлагыг шинээр боловсруулах

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ


**СУУРЬ ТҮВШИН :** АДБОУС 4000,4100 орчуулж хэвлүүлсэн

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** АДБОУС-д нийцүүлсэн заавар аргачлал

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийцлийн аудитын заавар, аргачлал (МУЕА-ын 2021 оны А/71 дүгээр тушаал) Нийцлийн аудит нь шалгуур үзүүлэлт болгон тодорхойлсон холбогдох хууль тогтоомжид шалгасан зүйл нийцэж байгаа эсэх нотлох зүйлийг бодитойгоор олж авч үнэлэх, гүйцэтгэх системтэй үйл явц бөгөөд нийцлийн аудитын хамаарах стандарт болон нийтлэг журамд заасан ерөнхий зарчмуудыг аудитын үе шат бүрд мөрдөж хэрэгжүүлэхэд энэхүү заавар, аргачлалыг баримтлах юм.

Нийцлийн аудитыг бие даасан байдлаар гүйцэтгэх буюу санхүүгийн тайлангийн эсвэл гүйцэтгэлийн аудиттай хослуулан нэгдмэл байдлаар гүйцэтгэх тохиолдолд тухайн аудитын урьдчилсан судалгааны дүнд сэдэв зорилго, зорилтоос хамааран аудитын төрөл тус бүрд холбогдох аудитын заавар, аргачлалыг баримтлахаар тодорхойлж боловсруулав



### ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН :** Журам, гарын авлага бүрэн боловсруулагдаж, аудитын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.

Төрийн аудитын стандарт болон холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэн “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг боловсруулж батлан нийцлийн аудитын үйл ажиллагаанд нэвтрүүлж, Шилэн дансны, Төрийн хэмнэлтийн, Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитын байнгын хяналтыг хэрэгжүүлж байна.

**ЗОРИЛТ 3: Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх төрийн аудитын байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих зорилтын хэрэгжилт**

№	Зорилт	Гүйцэтгэлийн хэмжүүр	2019	2020	2021	2022	2023	2024*
1.3.1	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын 2.4-т заасан тогтвортой хөгжлийн засаглалын бодлогыг Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх	Тогтвортой хөгжлийн засаглалын зорилтуудыг хэрэгжүүлж, дотоод болон олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцсон байх	2	1	8	7	5	2
1.3.2	Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын 2.3-т заасан Байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилтыг Төрийн аудитын байгууллагаас дэмжиж байгаль орчны аудитыг хөгжүүлэх	Байгаль орчны хамтарсан болон бие даасан аудитыг гүйцэтгэсэн байна.	1	1	1	1	2	
1.3.3	Төрийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, төрийн байгууллагын үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар иргэдийг бодит мэдээллээр хангах	Аудитын тайлан, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд хялбар мэдээлэх утасны цахим программыг бий болгосон байх	3	4	6	5	1	6
1.3.4	Аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг дээшлүүлж, үйл ажиллагааны нэгдсэн тайлан гаргах	Аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг дээшлүүлж, үйл ажиллагааны нэгдсэн тайлан гаргах	4		2		1	5
1.3.5	Төрийн аудитын байгууллага нь авлигатай тэмцэх үйл ажиллагаанд идэвх, санаачилгатай оролцох	Төрийн аудитын байгууллага нь авлигатай тэмцэх үйл ажиллагаанд идэвх, санаачилгатай оролцох	2	2	1	3	2	3
			12	8	18	16	11	16

**ЗОРИЛТ 1.3.1:** Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын 2.4т заасан тогтвортой хөгжлийн засаглалын бодлогыг Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д тусгагдсан засаглалын бодлогыг Төрийн аудитын байгууллагын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах ажлыг ажлыг хэрэгжүүлж эхэлсэн

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Монгол Улсын тогтвортой хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн зорилт, зорилго

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 онд хэрэгжүүлэх стратегийг батлахдаа “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ыг хэрэгжүүлэх төрийн аудитын байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих” зорилтыг дэвшүүлж, тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүллээ.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний хэрэгжилт болон төрийн аудитын байгууллагын чиг үүрэг, хүлээх хариуцлагын хүрээнд хүчин чармайлт гаргаж, байр сууриа илэрхийлэн дэмжиж, аудитын үр нөлөөг тогтвортой хөгжлийн зорилготой нийцүүлэн стратегийн болон жилийн төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжүүлэв.

### ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТУЛГУУР





Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичгийн хүрээнд Төрийн аудитын байгууллагаас тогтвортой хөгжлийн засаглалын бодлогыг хэрэгжүүлэх, төлөвлөгдсөн аливаа томоохон хөтөлбөр, зорилтын хэрэгжилтийг үнэлж, хамгийн сайн үр дүнд хүргэхийн тулд зорилго нэг бүрээр тусад нь, мөн тодорхой хугацааны давтамжтай, аль зорилтыг эхний ээлжид чухалчлан үзэж хөндлөнгийн аудит хийхийг тодорхойлох, эрүүл мэндийн тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтэд аудит хийх, байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн аудитыг хөгжүүлэх, төрийн аудитын чанарыг сайжруулж, тэдгээрийн үр дүнг бодитойгоор болон үнэ зөвөөр олон нийтээд мэдээлэх зэрэг арга хэмжээг төлөвлөн, Төрийн аудитын байгууллага өөрийн бодлого, стратегийн төлөвлөгөө болон УИХ-аас санал болгосон аудитын сэдвийн хүрээнд бие даасан, хараат бус байдлаар зохистой хяналтыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх хүрээнд олон улсын байгууллагаас зохион байгууллагаас үйл ажиллагаанд байнгын идэвхтэй оролцож, салбар хуралдаанд хэлэлцүүлэгт амжилттай оролцсон. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, бусад бодлогын хэрэгжилт, үндсэн чиглэл, жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр тулгуур аудитыг гүйцэтгэж зөвлөмж гарган Монгол Улсын урт хөгжлийн бодлого зорилтын хэрэгжилтэд төрийн аудитын байгууллагын оролцоог тасралтгүй ханган ажиллаж байна. Аудитын зөвлөмжийн хийх үйл ажиллагааг сайжруулах, чанартай гүйцэтгэх, тайлагнах үйл явцыг системтэйгээр төлөвлөн ажиллалаа.

#### НҮБ БА ИНТОСАИ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ



2019 онд ОХУ-ын Москва хотноо болсон АДБОУБ-ын 23 дугаар их хурал (ИНКОСАИ)-д манай төлөөлөгчид амжилттай оролцсон бөгөөд уг хуралдааны үеэр ОХУ-ын Тооцооны танхим, БНХАУ-ын Үндэсний аудитын газар, БНСУ-ын Аудит болон Хяналт шалгалтын зөвлөлийн удирдлагуудтай уулзаж харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд аудитын үйл ажиллагаанд ашиглах, нэвтрүүлэх бололцоотой бүхий л арга зүй, технологийг нэвтрүүлж хөгжүүлэхэд түншлэл, хамтын ажиллагааг идэвхжүүлэх талаар санал солилцож, чиглэлээ тодорхойлов.

Мөн байгууллагын төлөөлөгчид Канад, БНСУ, БНТУ, Кувейт улсын ТАБ-д айлчилж, сайн туршлага нэвтрүүлэх, хамтын ажиллагааг сэргээх чиглэлээр ажиллаж, БНХАУ, БНСУ, БНАЛАУ гэх мэт 10 гаруй улсын Аудитын дээд байгууллагаас зохион байгуулсан аудиторчуудын ур чадварыг хөгжүүлэх сургалтуудад цахим болон биечлэн идэвхтэй оролцлоо.

Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага (ИНТОСАИ) нь Нэгдсэн үндэстний байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагуудад гишүүнчлэл бүхий 196 орны Аудитын дээд байгууллагыг нэгтгэсэн хараат бус, улс төрөөс ангид мэргэжлийн байгууллага бөгөөд тус байгууллага нь стратегийн шийдвэр гаргах зорилгоор байгууллагын олон улсын төрийн аудитын салбарт тулгарч буй гол асуудлууд, тэдгээрийн боломжит шийдлүүдийг хэлэлцэж, дэлхийн хэмжээнд засгийн газруудын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор туршлага солилцох, тулгамдсан асуудлуудыг хэлэлцэх, шийдвэр, зөвлөмж гарган үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

2022 онд ИНТОСАИ-н XXIV Их Хурал Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Рио-Де-Жанейро хотноо зохион байгуулагдсан бөгөөд тус XXIV Их Хуралд 137 орны Аудитын дээд байгууллагын, 30 гаруй олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцож, олон нийтийн гамшгийн эсрэг үйл ажиллагаанд аудитын дээд байгууллагуудын гүйцэтгэх үүрэг роль, ИНТОСАИ-н дэлхий нийтэд хүргэх дуу хоолой, үр дүн гэсэн үндсэн сэдвийн хүрээнд хэлэлцэж тодорхой шийдлүүд гаргаж, түүнийг ажил хэрэг болгон ажиллаж байна.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Тогтвортой хөгжлийн засаглалын зорилтуудыг хэрэгжүүлж, дотоод болон олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцсон байх

Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагын (ИНТОСАИ)-н Их хурал (ИНКОСАИ) гурван жил тутамд болдог бөгөөд 2019 онд Москвад (ОХУ), 2022 онд Бүгд Найрамдах Бразил Улсын Рио-де-Жанейро хотод зохион байгуулагдсан их хуралд Монгол Улсын Ерөнхий аудитор болон төрийн аудитын байгууллагын төлөөлөл амжилттай оролцов.

ИНТОСАИ-аас батлан гаргасан зөвлөмж, шийдвэрийг өөрийн орны аудитын дээд байгууллагад хэрэгжүүлэн ажиллах, бусад орны тэргүүн туршлагаас суралцах, Их хурлаас баталсан тунхаглалыг үйл ажиллагааны зарчим болгон ажиллахаас гадна аудитын үйл ажиллагаанд тэдгээрийг ашигласнаар аудитын чанар, үр нөлөө дээшлэх нөхцөл бүрдэж, түүнийг өөрийн байгууллагад хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан хөгжлийн чиглэл, зорилгоо тодорхойлон ажиллаж байна.

Дэлхийн улс, орнууд төдийгүй дотоодод үүссэн нөхцөл байдлын улмаас Үндэстний аудитын газраас гадаад харилцаа, хамтын ажиллагааны зарим арга хэмжээ хэрэгжихгүйд хүрч байсан ч ИНТОСАИ болон хамтын ажиллагаатай аудитын дээд байгууллагуудын сайн туршлага, харилцаа хамтын ажиллагааг улам хөгжүүлж тодорхой ахиц дэвшлийг гаргаж ажиллалаа.

**ЗОРИЛТ 1.3.2:** Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын 2.3-т заасан Байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилтыг Төрийн аудитын байгууллагаас дэмжиж байгаль орчны аудитыг хөгжүүлэх

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** Төрийн аудитын байгууллагаас санаачлан уул уурхайн, байгаль орчны чиглэлийн аудитыг жилд нэгийг гүйцэтгэдэг

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Байгаль орчны аудитыг гүйцэтгэх стандарт, арга зүйн шаардлага

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн аудитын байгууллагын бодлогоор гүйцэтгэх аудит нь улс орны хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хөгжлийг дэмжсэн байхаар бодлоготой ажиллаж байна.


Төрийн аудитын байгууллагаас сүүлийн жилүүдэд хийсэн аудитын сэдвийг харахад жил бүр 4-11 сэдвийн хүрээнд бодлогоор аудит хийж ирсэн бөгөөд салбараар авч үзвэл 2016 оноос хойш уул уурхай, олборлолт, төсөв, санхүү, даатгалын салбарт тогтмол аудит хийж ирсэн бол байгаль орчин, боловсролын салбарт үе шаттай аудит хийж байна.

ТАБ-ын бодлогоор гүйцэтгэсэн аудитын тоо, салбараар, 2016-2023 он

Санхүү, даатгал, 12	Уул уурхай, олборлолт, 10	Байгаль орчин, 6	Төрийн удирдлага, батлан хамгаалах, 5	Тээвэр, 4
			Эрүүл мэнд, 4	Мэдээ... холбоо, 2
Төсөв, 10	Бусад, 8	Боловсрол, 6	Эрчим хүч, 4	Барилга, 1
				ХАА, 1

Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд Төрийн аудитын байгууллага байгаль орчны асуудлаар нэгдсэн болон дангаар сэдэвчилсэн гүйцэтгэл, нийцлийн аудитыг гүйцэтгэлээ. Тухайлбал:

Монгол Улсын Ерөнхий Аудиторын “Аудитын сэдэв батлах тухай” А/11 дүгээр тушаалыг үндэслэн “ Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт үр нөлөө” сэдвийн түвшинд орон нутаг дахь Төрийн аудитын газрууд дараах сэдвээр байгаль орчны аудитыг гүйцэтгэжээ.



Түүнчлэн, “ЗГ-аас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн нийцэл, үр нөлөө, газар олголт” сэдэвт байгаль орчны чиглэлээрх аудитыг 2021, 2022 онд УИХ-ын Төсвийн байнгын хорооны тогтоолын хүрээнд гүйцэтгэсэн байна.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Байгаль орчны хамтарсан болон бие даасан аудитыг гүйцэтгэсэн байна.

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд заасан Байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилтыг Төрийн аудитын байгууллагаас дэмжиж байгаль орчны асуудал хөндсөн сэдэвчилсэн аудитыг 2019-2024 онд тасралтгүй хэрэгжүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас (төрөлжсөн аудитын газрууд болон орон нутаг дахь Төрийн аудитын газрууд) 2020 онд 3, 2021 онд 1, 2022 онд 5 сэдвийн хүрээнд хамтарсан аудит 1, дангаар 1, 2023 онд нэгдсэн удирдамжтай 1, дангаар 4 байгаль орчны чиглэлээрх асуудалд сэдэвчилсэн аудитыг гүйцэтгэжээ.

**ЗОРИЛТ 1.3.3:** Төрийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, төрийн байгууллагын үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар иргэдийг бодит мэдээллээр хангах

## СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг УИХ-ын Төсвийн байнгын хороонд танилцуулдаг. Аудитаар өгсөн, акт, албан шаардлага, тайланг audit.mn сайтад байршуулдаг.

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Байгууллагын үйл ажиллагаа, аудитын тайлангийн үр дүнг нээлттэй, ил тод танилцуулах, түүний мөрөөр авсан арга хэмжээ

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Төрийн аудитыг хийхийн тулд шинжлэх ухааны ололт, орчин үеийн мэдээлэл технологийн арга хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, түүнийг боловсронгуй болгох арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх, цахим мэдээллийн нэгдсэн системийг үйл ажиллагаандаа ашиглах боломжийг бүрдүүлэх, төрийн аудит нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байхаар тодорхойлсны дагуу аудитад шаардлагатай мэдээллийг цуглуулах, дамжуулах, хадгалах, дүн шинжилгээ хийх зорилгоор мэдээллийн нэгдсэн системийн ашиглалт, хөгжүүлэлтийн дунд болон урт хугацааны бодлогыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд болон ТАБ-ын бодлого гүйцэтгэж байгаа аудитын үр нөлөөг сайжруулах, олон нийт, нийгмийн анхааралд байгаа асуудлыг аудитын үндсэн болон дэд зорилт, асуудлын шинжилгээнд тусган, ил тод байдлын хүрээнд харилцагч талуудаас нээлттэй санал асуулга авч аудитад ашиглаж байна.





Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд болон ТАБ-ын бодлогоор гүйцэтгэж буй аудитын үр дүнг сайжруулах, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд үнэн зөв таниулах зорилгоор мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган мэдээллийн технологийг ашиглан аудитын үр нөлөөг дээшлүүлэх, аудитын үр дүнг ил тод нээлттэй сурталчлах үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр ахиц гарсан байна.



“Нээлттэй аудит” [www.open.audit.mn](http://www.open.audit.mn) цахим сайтын үйл ажиллагааг эхлүүлсэн нь аудитад иргэдийн мэдээллийг ашиглах, мэдээллийн ил тод байдлыг хангах, аудитын үйл ажиллагаанд харилцагч талуудын оролцоог хангах, аудитын сэдэвт санал авах, эргэх холбоо бий болгох, төрийн санхүү, төсвийн арвиг хямгагч байдал, үр дүн, үр ашигтай байгаа эсэхэд тавих хөндлөнгийн хяналтыг идэвхжүүлэх чухал алхам боллоо





Төрийн аудитын байгууллага 2022 онд нийт 52 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, энэ хүрээнд хэвлэлийн мэдээ-41, нийтлэл-4, социал мэдээ-1, ТВ зочин-3, ярилцлага-1, ТВ хэлэлцүүлэг-3, ТВ нэвтрүүлэг-3, Инфографик-3, ТВ мэдээ-21, Подкаст-3 бэлтгэж, олон нийтэд түгээсэн.

Нийгэмд хүлээлттэй байгаа олон нийтийн анхаарал татсан тодорхой сэдвүүдийг сонгон авч мэдээллийг олон талт хэлбэрээр нийтэд түгээснээр Үндэсний аудитын газрын цахим хуудасны хандалтын тоо ([http:// open.audit.mn](http://open.audit.mn)) 33316, (<http://audit.mn>) 35196 хүрч, цахим сүлжээнд нийтлэгдсэн мэдээ, мэдээллийг дунджаар 20-25 удаа түгээжээ. “Аудит” цахим сэтгүүлийн дугаарыг бэлтгэн ТАБ-ын албан хаагчдад байгууллагын дотоод удирдлагын программаар дамжуулан албан хаагчдад хүргэж байна.



## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Аудитын тайлан, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд хялбар мэдээлэх утасны цахим программыг бий болгосон байх

Төрийн аудитын байгууллага нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлж байна

Төрийн аудитын үндсэн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, аудитын дүнг харилцагч талууд, иргэд олон нийтэд байгууллагын албан ёсны цахим хуудас, нээлттэй портал сайтаар дамжуулан аудитын мэдээ, хураангуй тайланг байршуулж, бүрэн эхээр нь хаанаас ч, цахимаар, гар утсаараа ч QR кодыг уншуулж танилцах, ашиглах боломжтой байна.

Нээлттэй портал сайтын зорилго, ач холбогдол, сайтын бүтэц, хэрэглээний талаар танилцуулга видео бэлтгэж, Төрийн аудитын тайлан, үйл ажиллагааг иргэдэд хялбар ойлгомжтой мэдээлж, хэвлэл, мэдээллийн байгууллагуудад мэдээллийг жигд хүртээмжтэй байдлаар түгээж ажиллалаа.

### АУДИТЫН ТАЙЛАН ҮЗЭХ ЗААВАР

Төрийн аудитын байгууллагын албан ёсны цахим хуудас [www.audit.mn](http://www.audit.mn)



QR кодоор  
цахим  
хуудас руу  
зочилно уу.

1. [www.audit.mn](http://www.audit.mn) сайтын баруун дээд өнцөгт байрлах **АУДИТЫН ТАЙЛАН** гэсэн баннер дээр дарж шууд [tailan.audit.mn](http://tailan.audit.mn) хуудсыг гарган хайлт хэсэгт үзэхийг хүссэн тайлангийн нэрийг бичиж болно.
2. [www.audit.mn](http://www.audit.mn) сайтын баруун дээд өнцөгт байрлах **ИЛ ТОД БАЙДАЛ** цэсийн **АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА** гэсэн хэсгийг сонгож **АУДИТЫН ТАЙЛАН**-гаас хүссэн тайлангаа үзэж, татан авах боломжтой.
3. Санал хүсэлт болон асуух зүйлийг [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn) цахим хаягаар илгээнэ үү.

**ЗОРИЛТ 1.3.4:** Аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг дээшлүүлж, үйл ажиллагааны нэгдсэн тайлан гаргах

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ


**СУУРЬ ТҮВШИН :** Аудитын тайлан тус бүрээр зөвлөмжийн хэрэгжилтийг аудитын баг хариуцдаг, нэгдсэн байдал нь статистик мэдээгээр жилд нэг удаа тайлагнадаг. Аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагаанд хяналт сул

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл явцыг сайжруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн аудитын байгууллагаас гаргасан шийдвэр буюу өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт холбогдох шаардлагад нийцэж байгаа эсэхийг судалж, нөхцөл байдлыг тодорхойлж, энэ чиглэлээр баримтлах бодлого, арга зүйг боловсронгуй болгох, хөгжүүлэхэд анхаарал хандуулан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг мэргэжлийн судалгааны байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд харилцагч талуудыг илүү бодлогын түвшний зөвлөмжөөр хангах, аудитын шийдвэрүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч өмнөх жилүүдэд эхлүүлсэн, нэвтрүүлсэн, төлөвшүүлсэн ажлуудынхаа эрчмийг алдахгүйгээр тууштай, бодит ажлыг хэрэгжүүлэх зорилгоор 2023 оныг “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах” жил гэж тодорхойлон зорилтыг хангах ажлын төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна. Аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж хувь дараах байдалтай байна.



Мөн Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн аудитын шийдвэр, аудитын шийдвэрүүд, зөвлөмжийн мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг сайжруулах хүрээнд УИХ-аас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Төрийн аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Тус хуулиар 20 дугаар зүйлийн 20.5-хэсэгт “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан, хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.”, 37 дугаар зүйлийн 37.2 хэсэгт...”аудитын тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг...” нэмэлт өөрчлөлтийг тус тус оруулж баталсан

Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, нэгтгэх, модулийн нэвтрүүлэх ажлын хүрээнд Акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, нэгтгэх, модулийн эцсийн үнэлгээний бодлогын даалгаврыг тодорхойлон, хөгжүүлж, үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, улмаар хэрэгжилтийг шалгагдагч байгууллага тайлагнахад дотоод хяналтын нэгж хянасны дараа аудитын багт хүсэлт илгээх боломжийг хөгжүүлэв. Акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, нэгтгэх, модульд дараах 5 сайжруулалтыг хөгжүүлж, тестлэн, үйл ажиллагаанд нэвтрүүлэв.

1. Акт, албан шаардлага, зөвлөмжийн жагсаалтын цонхонд биелэлт тайлагнасан хувь харуулах
2. Акт, албан шаардлага, зөвлөмж тайлагнах байгууллагын жагсаалтыг сүүлд хайсан утгаар хөлдөөх
3. Шалгагдагчийн нэвтрэх эрхийн мэйлд тайлант хугацааны автомат тохиргоог тохируулах
4. Шалгагдагч байгууллага биелэлтийн нэгдсэн хавсралт оруулаагүй тохиолдолд мэдэгдэл харуулах
5. Мэдэгдлийн функц, процессын тохиргоог биелэлт тайлагнах, хяналт хэрэгжүүлэх хэрэглэгчидтэй уялдуулах сайжруулалтуудыг тус тус гүйцэтгэлээ.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг дээшлүүлж, үйл ажиллагааны нэгдсэн тайлан гаргах

2022 онд 10,235 зөвлөмж өгсөн бөгөөд тэдгээрийн 83.9 хувь нь хэрэгжжээ. Төрийн аудитын байгууллага аудитын мөрөөр гүйцэтгэх үйл ажиллагааг оновчтой төлөвлөж, аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг тооцох бодлого, арга зүйг боловсронгуй болгож төлөвшүүлэх аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагаа, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулахад тодорхой ажлуудыг авч хэрэгжүүлснээр аудитын шийдвэрийн биелэлт тодорхой хувиар ахиц гарч байна.

Аудитын зөвлөмжийн мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг дээшлүүлж, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, нэгтгэх, модулийн нэвтрүүлэлтийн ажлыг хөгжүүлж, системийн дэмжлэг үйлчилгээний хүрээнд аудитын ажилд хамаарах шалгагдагч байгууллагад системийн нэвтрэх эрх олголтын гүйцэтгэл 64.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт 2409 аудитын ажилд хамаарах шалгагдагч биелэлт тайлагнагдсан байна.

### ЗОРИЛТ 4: Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжиж, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх зорилтын хэрэгжилт

№	Зорилт	Гүйцэтгэлийн хэмжүүр	2019	2020	2021	2022	2023	2024*
1.4.1	1.4.1. Аудитын зарим үе шатанд иргэдийг оролцуулах, хяналт тавих, үр нөлөөг дээшлүүлэх, төрийн аудитын байгууллагын дэргэд Аудитын иргэний танхимыг ажиллуулах	Аудитад иргэний оролцоог хангах стратегитай болсон байх, Аудитын иргэний танхимыг бүх аймгийн Төрийн аудитын газруудын дэргэд байгуулсан байх		3	4	5	2	2
1.4.2	1.4.2. Харилцагч талуудтай байнгын, үр дүнтэй харилцах тогтолцоог бүрдүүлэх	Төрийн аудитын байгууллагын Харилцагчийн оролцооны стратегийг хэрэгжүүлсэн байх		8	16	14	12	8
1.4.3.1	1.4.3. Аудитын чанарын хяналтын тогтолцоог төлөвшүүлж, санхүүгийн болон гүйцэтгэлийн,	Төрийн аудитын дотоод хяналтын болон чанарын баталгаажуулалтын олон улсын стандартад нийцсэн эрх зүйн акт, тэдгээрийн гүйцэтгэсэн хяналтын тайлангууд гарсан байна		8	6	7	1	
1.4.3.2	нийцлийн аудитад 4 жил тутамд бусад орны аудитын дээд байгууллагуудаар түншийн үнэлгээ хийлгэж байх	Төрөлжсөн аудит бүрээр хөгжингүй орны аудитын дээд байгууллагуудаар түншийн үнэлгээ хийлгэсэн байна.		1			1	
1.4.4	1.4.4. Эрсдэлд суурилсан төрийн аудитыг хэрэгжүүлж, санхүүгийн болон гүйцэтгэлийн, нийцлийн хамтарсан аудитыг гүйцэтгэх	Жил бүр эрсдэлд суурилсан нэгээс доошгүй хамтарсан аудитыг гүйцэтгэсэн байна.		1	1	4	12	1
1.4.5.1	1.4.5. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайланд	Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдвал зохих нийт байгууллагаас хувийн аудитын компаниар хийлгэх байгууллагын тоо 40 хувьд хүрсэн байна	3	1	3	4	5	2
1.4.5.2	хийх аудитад хөндлөнгийн хараат бус аудитын хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг сайжруулах	Төрийн аудитын байгууллагатай гэрээгээр санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэж байгаа хувийн аудитын хуулийн этгээдүүдийн аудиторудыг оролцуулсан сургалтыг жил бүр гүйцэтгэж, санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг бүрэн нэвтрүүлсэн байна.	1			1	1	2
1.4.6	1.4.6. Хуульд заасан хугацаанд санхүүгийн аудитыг чанартай гүйцэтгэх	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Аудитын олон улсын стандарт, санхүүгийн аудитын журам, гарын авлагад нийцүүлэн гүйцэтгэсэн байна.	13	3	7	6	10	10
1.4.7	1.4.7. Төлөвлөгөөт хугацаанд гүйцэтгэлийн аудитыг чанартай гүйцэтгэх	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, гарын авлагад нийцүүлэн гүйцэтгэсэн байна.	15	3	13	6	14	21
1.4.8	1.4.8. Төлөвлөгөөт хугацаанд нийцлийн аудитыг чанартай гүйцэтгэх	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, нийцлийн аудитын журам, гарын авлагад нийцүүлэн гүйцэтгэсэн байна.	5	1	6	8	7	11
1.4.9	1.4.9. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, бусад бодлогын баримт бичигт хийх аудитыг тогтмолжуулах	Гүйцэтгэлийн аудитын сэдвийг сонгохдоо жил бүр хамгийн багадаа 1-2 сэдэв сонгосон байна.			1	1	2	3
			37	29	57	56	67	60

**ЗОРИЛТ 1.4.1:** Аудитын зарим үе шатанд иргэдийг оролцуулах, хяналт тавих, үр нөлөөг дээшлүүлэх, төрийн аудитын байгууллагын дэргэд Аудитын иргэний танхимыг ажиллуулах

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** Аудитад иргэний оролцоог хангах чиглэлээр сургалт зохион байгуулах, туршлага судлах түвшинд байна.

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Аудитын үйл ажиллагаанд иргэний оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээ

#### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МУЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги 2020-2023”-г баталсан байна.



Уг стратегийг Европын холбооны итгэлцлийн сангийн санхүүжилтээр Дэлхийн банкны хэрэгжүүлж буй Засаглалыг бэхжүүлэх төслийн хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.31, 13 дугаар зүйл, 372 дугаар зүйл заалтыг үндэслэсэн буюу стратегийн төлөвлөгөөний төслийн баримт бичиг, өнөөгийн нөхцөл байдлын талаар судалгаа хийж үндсэн 8 бүлэг, 3 зорилтын хүрээнд 2020-2023 онд 24 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

д/д	Зорилт	Арга хэмжээ	Дэд арга хэмжээ	2020, 2021 явцын ХШҮ
Нэг	Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх	5	8	88.0%
Хоёр	Төрийн аудитын үйл ажиллагаа, аудитын үр дүнг олон нийтэд түгээх арга зүйг хөгжүүлэх	2	3	91.82%
Гурав	Төрийн аудитын үе шатанд иргэдийн оролцоог хангах тогтолцоог бий болгох	5	13	46.36%
	Нийт	12	24	75.39%



Энэхүү баримт бичигт баримтлах зарчим, иргэдийн оролцооны харилцагч талууд, арга зүй, түүнийг хэрэгжүүлэх горимууд, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, стратегийн хүрэх үр дүн, хэрэгжилтийг үнэлэх хяналт-шинжилгээ, үнэлгээ зэргийг тусган баталсан.

Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, суурь ойлголтыг төлөвшүүлэх, гарын авлагын болон цахим сургалтын материал боловсруулах, цахим сургалт зохион байгуулах E-Хичээлийн видео хувилбарыг бэлтгэж, тус хичээлийн сургалтыг нийт болон шинэ албан хаагчдыг (2021 онд 152, 2022 онд 220, 2023 онд 109) хамруулан 4 долоо хоногийн хугацаатай сургалтыг тасралтгүй зохион байгуулсан. Түүнчлэн холбогдох материалыг able дотоод удирдлагын программын олон нийт цэсийн файлын сан болон surgalt.audit.mn сургалтын системд байршуулсан. Мөн аудитын тайланг хураангуйлах, инфографик хэлбэрт хөрвүүлэх зорилгоор аудиторруудад холбогдох сургалтыг зохион байгуулж, тус чиглэлээр 25 аудиторт сертификат олгосон бөгөөд жил бүрийн сургалт хөгжлийн төлөвлөгөөнд тусган системтэйгээр аудиторруудыг бэлтгэж байна.

Нийслэл, Говь-Алтай, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэд 5 гишүүнчлэл бүхий иргэдийн бүлэг ажиллаж, иргэд, олон нийтээс санал асуулга авах, аудитын үр дүнг түгээх чиглэлээр үр нөлөөтэй үйл ажиллагаа бий болж, тус иргэний танхимыг ажиллуулснаар иргэдийн оролцоотой үнэн зөв хариулт хүссэн аудитын сэдвийг стандарт, журамд нийцүүлэн сонгох, санал авах, бүлэг, танхимын гишүүдэд төрийн хяналтын үйл ажиллагааг таниулах, олон нийттэй харилцах харилцааг цахим орчинд идэвхжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх сургалт явуулж ирлээ.

Аудитын тайлан, мэдээллийг иргэдэд зориулсан ойлгомжтой хэлбэрээр боловсруулах хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд ТАБ-аас харилцагч талуудад зориулсан аудитын хураангуй тайлан бэлтгэх аргачилсан зөвлөмжийн төслийг боловсруулах судалгааны судалгааны ажлыг гүйцэтгэж, 10 гаруй улсын аудитын дээд байгууллагын цахим хуудсанд тандалт судалгааны ажлыг гүйцэтгэж, МУЕА-ын тушаалаар “Харилцагч талуудад зориулсан аудитын хураангуй тайлан бэлтгэх аргачилсан зөвлөмж”-ийн баримт бичгийг баталгаажуулан сүүлийн 2 жил гүйцэтгэсэн бүх аудитад хураангуй тайлан бэлтгэж “Нээлттэй аудит” портал сайтад байршуулж хэвшсэн байна.



### ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Аудитад иргэний оролцоог хангах стратегитай болсон байх, Аудитын иргэний танхимыг бүх аймгийн Төрийн аудитын газруудын дэргэд байгуулсан байх.

МУЕА-ын А/94 дүгээр тушаалаар “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги 2020-2023”-г баталсан бөгөөд стратегийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөг батлан гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.



**ЗОРИЛТ** 1.4.2: Харилцагч талуудтай байнгын, үр дүнтэй харилцах тогтолцоог бүрдүүлэх

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН** : Тусгайлсан бодлого байхгүй

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**: Төрийн аудитын байгууллагын гадаад, дотоод харилцагчдын жагсаалт

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд хэрэгжүүлэх Харилцагч талуудын оролцооны стратеги төлөвлөгөөг боловсруулан 2019 онд Монгол Улсын Ерөнхий аудиторын А/10 тоот тушаалаар батлуулсан байна. Тус стратеги төлөвлөгөөний дагуу ажил бүр харилцагч талуудын оролцооны төлөвлөгөө батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Харилцагч талуудын оролцооны стратеги /2019-2023/ төлөвлөгөө”-нд харилцагч талуудыг 7 (Улсын Их Хурал; Шалгагдагч байгууллага; Хэвлэл мэдээллийн хэрэгсэл; Иргэний нийгмийн байгууллага; Хуулийн байгууллага; Мэргэжлийн болон академик байгууллага; Төрийн аудитын байгууллагын газар, нэгж) харилцагч талын хамтын ажиллагааг сайжруулах 19 арга хэмжээг төлөвлөсөн байна.



Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.1<sup>2</sup>, Төрийн аудитын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1<sup>3</sup> заалтыг үндэслэн МУЕА-ын баталсан холбогдох журмын дагуу Төрийн аудитын байгууллагын 2019-2022 оны үйл ажиллагааны тайланг боловсруулан УИХ-ын ТБХ-д хүргүүлж, жил бүр байнгын хорооны тайланг хэлэлцүүлжээ.

<sup>2</sup> 113.1 “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага үйл ажиллагааныхаа тайланг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд дараа оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд ирүүлнэ”

<sup>3</sup> 37.1 “Төрийн аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг өөрийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэй, ил тод байршуулна.”

Аудитын сэдэв сонгох ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, МУЕА-ын тушаалаар батлав. Аудитын сэдэв сонгох үйл ажиллагааг ТАБ-ын хэмжээнд мөрдүүлэн Төрийн аудитын тухай хуульд заасан тухайн сэдвээр урьдчилсан судалгаа, тооцоолол хийгдсэн байх, төсөв, санхүү, хугацаа болон хүний нөөцийн чадавхтай байх, иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал байх гэсэн үндсэн шаардлагуудын дагуу аудитын сэдвийг эрэмбэлэн тухайн жилийн сэдвийг сонгон УИХ-ын ТБХ, МУЕА-ын тушаалыг батлан гүйцэтгэж байна.



Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 , Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2020, 2021, 2022, 2023, 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт гаргаж, дүгнэлтийг УИХ, холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлэв.



Монгол Улсын нэгдсэн төсөв, шат шатны төсвийн захирагчдын батлагдсан төсөв, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн төсөл, холбогдох танилцуулга мэдээлэл, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн судалгаа, мэдээлэл, төсөвтэй холбоотой цахим систем, хөндлөнгийн шинжээч судлаачдын хийсэн судалгаа, шинжилгээний тайлан зэрэгт үндэслэн нөхцөл байдлыг тодорхойлон дүн шинжилгээ хийж, дүгнэлтийг боловсруулж байна.


Тухайлбал; Монгол Улсын төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлтэд төсвийн төслийг төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх, төсвийн тогтвортой байдлын үндсэн зарчмыг бүрэн хангаж, өрийн ачааллыг бууруулах, төсөвлөлтийн шаардлага хангасан арга хэмжээг тусгаж байх зэргийг тусгаж, төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж, төсөлдөө тусгаж байх шаардлагатайг Засгийн газарт зөвлөв.

Төрийн аудитын дүн, дүгнэлт, өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлт, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн шат дараалсан судалгааны ажил хийж, “аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмж, түүний хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг загварчилж, цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн сан үүсгэх” судалгааны ажлын даалгаврыг бэлтгэх зөвлөхтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.

"Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2018, 2019, 2020 оны төлбөрийн акт, албан шаардлагыг цуглуулж мэдээллийн сан бий болгох, цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлох нь" судалгааны ажлын гүйцэтгэчийг мэдээллээр хангах, судалгааны явц, гүйцэтгэлийг хянаж удирдах ажлыг гүйцэтгэсэн. Судалгааны тайланг хүлээн авч үзэхэд төрийн аудитын зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын талаарх мэдээллийн сангийн тогтолцоог боловсронгуй болгох санал зөвлөмжийг урьдчилсан судалгааны үндсэн дээр үйл явцын иж бүрэн зураглал гаргаж, мэдээллийн сан бий болгох үзүүлэлтийг тодорхойлсон нь мэдээллийн нэгдмэл байдал, нэгдсэн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.

ТАБ-ын үйл ажиллагааны талаар бодитой, үнэн зөв тэнцвэртэй мэдээлэл өгөх, байгууллагын үйл ажиллагаа, аудитын дүн, дүгнэлтийг энгийн ойлгомжтой байдлаар олон нийтэд хүргэх, төрийн санхүүгийн удирдлага, төсвийн хяналтад тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд “Мэдлэг хуваалцах цаг” уулзалтыг зохион байгуулан ТАБ-ын үйл ажиллагаатай холбоотой асуудлаарх хэвлэлийн мониторинг жил бүр хийж тайлагнаж байна.

Төрийн аудитын байгууллагын талаар харилцагч талууд болон олон нийтэд зориулсан танилцуулгын эх бэлтгэлийг хийж гүйцэтгэн хэвлүүлж ҮАГ-ын бүтцийн нэгжийн бүх албан хаагчид болон АНТАГ-ууд болон харилцагч талуудад хүргүүлсэн байна.



## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Төрийн аудитын байгууллагын Харилцагчийн оролцооны стратегийг хэрэгжүүлсэн байх

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/10 тоот тушаалаар “Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд хэрэгжүүлэх Харилцагч талуудын оролцооны стратеги төлөвлөгөө”-г боловсруулан батлуулсан байна. Тус стратегийг хэрэгжүүлэх 2020, 2021, 2022, 2023 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, 2020, 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр биелэлтийн үнэлгээ 73.45 хувьтай байна.






Үнэлгээний тайланд тусгагдсан сул тал, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхээр жил бүрийн ТАБ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилт, арга тусган хэрэгжүүллээ. Тухайлбал, аудитад мэдээллийн технологийг түлхүү ашиглах, нэгдсэн удирдлага бодлогыг хэрэгжүүлэх, аудитын чанарын хяналтыг сайжруулах, аудитын шийдвэрийн чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд гол анхаарлаа хандуулсны үр дүнд төрийн аудитын үйл ажиллагааны чанар хүртээмж улам сайжирч байна.

АХБ-ны дэмжлэгтэй “Төрийн аудитын байгууллагын чадавхыг бэхжүүлэх” төслийн бүрэлдэхүүн I-ийн хүрээнд Австралийн Үндэсний Аудитын Газар (АҮАГ), Бүгд Найрамдах Индонез Улсын Аудитын Зөвлөлтэй (ВРК) хамтарсан баг буюу хараат бус 5 шинжээчийн бүрэлдэхүүнтэй байсан нь ноён Кристиан Гэйж (багийн ахлагч), хатагтай Лорэн Дэлл, хатагтай Прима Лиза, ноён Майкл МакГиллион болон ноён Фаузан Вибово нар МҮАГ-т түншийн үнэлгээ 2023 онд хийв.

Тус түншийн үнэлгээний тайлангаар дотоод хяналтын нэгдсэн тогтолцоо ИНТОСАИ-ЗГ 9100: Төрийн секторын дотоод хяналтын стандартын удирдамжтай уялдуулан боловсруулах, түүнчлэн ISO 31000:2018 Эрсдэлийн удирдлагын удирдамжид суурилан эрсдэлийн удирдлагын нэгдсэн удирдамжийг боловсруулах, ингэснээр эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй, үр ашигтай, тууштай хэрэгжүүлэх зэрэг зөвлөмжийг ирүүлсэн.

Мөн ТАБ-д ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлөөс үүдэх эрсдэлийг бууруулахад туслах, ёс зүйн хяналтын системийг бий болгоход эрсдэлийн удирдлагын тогтолцоог ашиглах, улмаар шударга байдлын эрсдэлд шинжилгээ хийх, эрсдэлийг бууруулах, гэмт хэргийн сэжигтэй үйлдлийн талаар мэдээлсэн хүмүүст зориулсан бодлого, хамгаалалтыг боловсруулах, хүний нөөц, сургалт, мэдээллийн технологи, захиргааны ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, мэдээллийн технологийн шинэчлэлийг хийж, чадварлаг боловсон хүчнийг ТАБ-д элсүүлэх, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг төлөвлөх, хөрөнгө оруулалт хийх зэрэг санал, зөвлөмжийг өглөө.



## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН:** 1.Төрийн аудитын дотоод хяналтын болон чанарын баталгаажуулалтын олон улсын стандартад нийцсэн эрх зүйн акт, тэдгээрийн гүйцэтгэсэн хяналтын тайлангууд гарсан байна. Төрөлжсөн аудит бүрээр хөгжингүй орны аудитын дээд байгууллагуудаар түншийн үнэлгээ хийлгэсэн байна.

АДБОУБ-аас дэвшүүлсэн гүйцэтгэлийн хэмжүүрийн үзэл баримтлалын дагуу төрийн аудитын гүйцтгэлд 2020, 2023 онд олон улсын байгууллагын хамтарсан багаар түншийн үнэлгээ хийлгэж, тайланг монгол, англи хэлээр бэлтгэн олон нийтэд нээлттэй мэдээлэв.



**ЗОРИЛТ 1.4.4:** Эрсдэлд суурилсан төрийн аудитыг хэрэгжүүлж, санхүүгийн болон гүйцэтгэлийн, нийцлийн хамтарсан аудитыг гүйцэтгэх

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** Төрийн аудитын байгууллага нь 2018 онд санхүүгийн 3806, гүйцэтгэлийн 201, нийцлийн 97, нийт 4104 аудит хийж гүйцэтгэсэн ч хамтарсан аудит хийгээгүй

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Аудитаар илэрсэн асуудлыг эрсдэлд үндсэн гүйцэтгэсэн аудит тоо, чанар, үр дүнгийн үзүүлэлт

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас бодлогоор гүйцэтгэх аудитын сэдвийг урьдчилан бэлтгэсэн аудитын сэдвийн төсөл, судалгаа, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс авсан санал, өмнөх онуудын хийж гүйцэтгэсэн аудитаас илрүүлсэн анхаарах эрсдэлтэй асуудлын судалгаа болон он дамжсан аудитын судалгаа, интернэт орчин дахь олон нийтийн анхаарлын төвд байгаа асуудлуудын хандалтын судалгаа зэргийг үндэслэн боловсруулж байна.

“Аудитын сэдэв сонгох, төлөвлөх үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулж, МУЕА-ын 2021 оны А/104 дугаар тушаалаар батлуулсан. Төрийн аудитын тухай хууль, тус журмын дагуу тодорхой сэдвийн хүрээнд нэгдсэн удирдамжаар, нийгмийн захиалга, бодлогоор нийгэм, эдийн засгийн салбар, төсвийн хөрөнгийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж шалгагдагч байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг сайжруулах асуудлыг нотлох баримтад түшиглэн тайлагнаж, дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан.

ТАБ-аас уул уурхай, ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон ААНБ, тухайн салбарыг хариуцан ажилладаг төрийн захиргааны төв болон мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үе шаттайгаар аудит хийх бодлогыг хэрэгжүүлэхэд тодорхой сэдвээр аудит хийж, үр нөлөөг тооцсон байна.

Гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг сайжруулахын тулд тухайн сэдвээр аудит хийх урьдчилсан судалгааны ажилд зарцуулах хугацааг зохистой болгон төрийн аудитын стандартын зарчмыг баримтлан улсын хэмжээнд хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулсан



зардлын хязгаарлалттай, сөрөг үр дагавар багатай, хэрэгжихэд дэмжлэг болохуйц аудитыг гүйцэтгэлээ. ТАБ-ын бодлогоор төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байдал, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитаар, төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж, хууль, эрх зүйн орчин, тогтолцоог сайжруулах зөвлөмж хүргүүлэв.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Жил бүр эрсдэлд суурилсан нэгээс доошгүй аудитыг гүйцэтгэсэн байна.



"Эрдэнэс таван толгой" ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголт сэдэвт аудитын тайлан



"Эрдэнэс монгол" ХХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



"Алт олборлох салбарын өнөөгийн байдал, алтны нөөцийн бүрдүүлэлт" сэдэвт аудитын тайлан



ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БАЙГАА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН /2012-2016 ОН/

Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

ГАЗРЫН ТОС, НЕФТИЙН ЗАВСРЫН НЭМЭЛТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**ЗОРИЛТ 1.4.5:** Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайланд хийх аудитад хөндлөнгийн хараат бус аудитын хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг сайжруулах

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** ТАБ-аас 2018 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдвал зохих байгууллагаас хувийн аудитын компаниар хийлгэсэн байгууллагын тоо 20.4 хувь байна.

Төрийн аудитын байгууллагаас хувийн аудитын компаниудад жилд нэг удаа тахимаар сургалт зохион байгуулдаг

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Санхүүгийн тайлангийн аудитад хувийн аудитын компанийн оролцооны хувь

Гэрээгээр санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэж байгаа хувийн аудитын хуулийн этгээдүүдийн аудаторуудын сургалтын үнэлгээ

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаварт хугацаанд төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайланд хийх аудитад хөндлөнгийн хараат бус аудитын хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг сайжруулах үйл ажиллагааг байнгын тасралтгүй хэрэгжүүлж ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан нийт байгууллагаас аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн санхүүгийн аудитын тайлан 2019 онд 1241, 2020 онд 1239, 2021 онд 1289, 2022 онд 1503, 2023 онд 1786-д хүрч, аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад чанарын хяналт, чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүллээ.



Төрийн аудитын байгууллагаас дунд хугацааны стратегийн баримт бичигтээ харилцагч талуудын хамтын ажиллагааг сайжруулж, эргэх холбоо бүхий байнгын үр дүнтэй харилцааг бий болгосноор аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэхэд төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайланд хийх аудитад аудитын хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлж, чадавхыг сайжруулах арга хэмжээ, сургалтуудыг зохион байгууллаа.

Төрийн аудитын байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ аудитын хуулийн этгээдийг төрийн аудитад татан оролцуулж ирсэн бөгөөд хуулийн дагуу гэрээгээр санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэж байгаа 60 орчим аудитын хуулийн этгээдийн аудиторуудыг цахим сургалтын системд бүртгэн, график төлөвлөгөөний дагуу 3 удаагийн 144 цагийн цахим сургалтад давхардсан тоогоор 975 аудиторыг хамруулан, сургалтад хамрагдсан аудиторуудын 43% нь амжилттай суралцаж сертификаттай төгсөв.

Цахим сургалтад хамрагдсан гэрээгээр аудит гүйцэтгэж байгаа аудитын хуулийн этгээдийн аудиторуудаар цахим сургалтын үр дүнг үнэлүүлэхэд цахим сургалтын ач холбогдлыг 86 хувь, сургалтын агуулгын өгөөжтэй байдлыг 86 хувь, сургалтаар олж авсан мэдлэг, чадварын ахицыг 84.16 хувь, сургалт нь суралцагчийн зорилгод нийцсэн байдлыг 86.16 хувь гэж тус тус үнэлсэн бөгөөд бөгөөд сэтгэл ханамжийн түвшин нь 86.16 хувь байсан.

Түүнчлэн санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэж байгаа аудитын хуулийн этгээдүүдийн аудиторуудад төрийн аудитын бодлого, стратеги, аудитын шинэчлэгдэн батлагдсан дүрэм, журам, заавар аргачлал, АХЭ-үүдийн гэрээний биелэлт, цаашид анхаарах асуудлын бодит цагийн онлайн, цахим, танхимын сургалтыг байнгын тасралтгүй төлөвлөгөөтэй зохион байгуулж, аудитын хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тодорхой шалгуураар үнэлэмж, үнэлгээ өгч байх үр нөлөөтэй тогтолцоог нэвтрүүлж, хуульд заасны дагуу сонгон шалгаруулан аудитын чанарын хяналтыг 100 хувьд хэрэгжүүлж байна.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдвал зохих нийт байгууллагаас хувийн аудитын компаниар хийлгэх байгууллагын тоо 40 хувьд хүрсэн байна. Төрийн аудитын байгууллагатай гэрээгээр санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэж байгаа хувийн аудитын хуулийн этгээдүүдийн аудиторуудыг оролцуулсан сургалтыг жил бүр гүйцэтгэж, санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг бүрэн нэвтрүүлсэн байна.

Төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэх аудитын үйл ажиллагаанд хариуцлагатай, чанар стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд санхүүгийн аудитын үйл ажиллагаанд аудитын хуулийн этгээдийн оролцоо 40 хувьд хүрсэн.

Төрийн аудитын үйл ажиллагаанд аудитын хуулийн этгээдийг татан оролцуулахдаа аудитын чанарын шалгуурыг чухалчлан авч үзэж, аудиторуудыг хамруулсан сургалтыг жил бүр төлөвлөн гүйцэтгэж, тэдний үйл ажиллагаанд санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг бүрэн нэвтрүүлсэн байна.

**ЗОРИЛТ 1.4.6:** Хуульд заасан хугацаанд санхүүгийн аудитыг чанартай гүйцэтгэх**СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН** : Төрийн аудитын байгууллага хуулиар тодорхойлсон чиг үүргийнхээ дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн 6536 санхүүгийн тайланд аудит хийхээс 3806 санхүүгийн тайланд бие дааж аудитын дүгнэлт гаргасан бол 369 байгууллагад итгэл үзүүлж, 2312 тайланг түүвэрт хамруулж, 49 байгууллагад аудит хийгээгүй байна.


**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Санхүүгийн аудитын тоо, чанар, үр дүнгийн үзүүлэлт

**ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Төрийн аудитын тухай хуулиар ҮАГ-ыг Монгол улсын АДБ хэмээн тогтоож, ҮАГ болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын байгууллагын аудитын үйл ажиллагааны чиг үүргийг зохицуулж өгсөн. ТАБ нь төрийн санхүү, төсвийн хяналтыг бие даан хэрэгжүүлэх бүрэн эрх бүхий байгууллага юм.


Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудит нь шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулж байна

Төсвийн тухай хуульд заасны дагуу ТАБ нь төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийх үүрэгтэй. Мөн ҮАГ нь Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх бүрэн эрхтэй. ҮАГ жил бүр яам, агентлагуудын хэрэгжүүлж эсвэл удирдаж буй сан, төсөл, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж зэргийг оролцуулсан 7000 гаруй (3900 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 3000-ийг түүвэрлэн, аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн) төрийн байгууллагад санхүүгийн аудит хийж, дүгнэлт, тайлан гаргадаг.





Төрийн аудитын байгууллага хуулиар тодорхойлсон чиг үүргийнхээ 2019 онд дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн 6424 санхүүгийн тайланд аудит хийснээс 3958 санхүүгийн тайланд бие дааж аудитын дүгнэлт гаргаж, 318 байгууллагад итгэл үзүүлж, 2135 тайланг түүвэрт хамруулсан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар 3958 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн санал дүгнэлтийн 3446 буюу 87.1 хувийг зөрчилгүй, 455 буюу 11.5 хувийг хязгаарлалттай, 41 нь сөрөг санал дүгнэлт өгч, 16 тайланд дүгнэлт гаргахаас татгалзсан байна.




2020 онд улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн 6542 санхүүгийн тайланд аудит хийснээс 3825 санхүүгийн тайланд бие дааж аудитын дүгнэлт гаргаж, 387 байгууллагад итгэл үзүүлж, 2311 тайланг түүвэрт хамруулжээ. Санхүүгийн тайлангийн аудитаар 3825 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн санал дүгнэлтийн 3386 буюу 88.5 хувийг зөрчилгүй, 398 буюу 10.4 хувийг хязгаарлалттай, 24 нь сөрөг санал дүгнэлт өгч, 16 тайланд дүгнэлт гаргахаас татгалзсан байна.

2021 онд улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн 6,740 санхүүгийн тайланд аудит хийснээс 3906 санхүүгийн тайланд бие дааж аудитын дүгнэлт гаргаж, 2,771 байгууллагын тайланг түүвэрт хамруулжээ. Санхүүгийн аудитаар 3,906 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн санал дүгнэлтийн 3,348 буюу 85.7 хувь нь “зөрчилгүй”, 509 “хязгаарлалттай”, 38 “сөрөг”, 10 “тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан” байна

2022 онд улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн 6,783 санхүүгийн тайланд аудит хийснээс 4,069 санхүүгийн тайланд бие дааж аудитын дүгнэлт гаргаж, 2,714 байгууллагын тайланг түүвэрт хамруулжээ. Санхүүгийн тайлангийн аудитаар 4,069 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийн 3,430 буюу 84.3 хувь нь өөрчлөлтгүй буюу зөрчилгүй, өөрчлөлттэй нийт 638 санал дүгнэлтийн 582 хязгаарлалттай, 37 сөрөг, 19 тайланд дүгнэлт гаргахаас татгалзсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын тайлан, аудитын гэрчилгээг дээд шатны төсөв захирагчийг байлцуулан гардуулж, байгууллага тус бүрээр аудитын дүн, цаашид анхаарах асуудлын талаар нэгдсэн танилцуулга хийдэг болсноор бүх шатны байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналт сайжирч, хариуцлага дээшилж байна.



## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Аудитын олон улсын стандарт, санхүүгийн аудитын журам, гарын авлагад нийцүүлэн гүйцэтгэсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Аудитын Олон улсын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, заавар аргачлалд нийцүүлэн бүх шатны захирагч, төсөл, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.



**ЗОРИЛТ 1.4.7:** Төлөвлөгөөт хугацаанд гүйцэтгэлийн аудитыг чанартай гүйцэтгэх**СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН** : 2018 онд баталсан аудитын сэдэв, төлөвлөгөөний хүрээнд 184 гүйцэтгэлийн аудитыг төлөвлөж, гүйцэтгэсэн

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**: Гүйцэтгэлийн аудитын тоо, чанар, үр дүнгийн үзүүлэлт

**ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Улсын Их Хурал төсвийг хянан баталж, дунд хугацааны төсвийн хүрээ, дунд хугацааны болон жилийн стратеги төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлан, татварын хуульд өөрчлөлт оруулах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих үүрэгтэй.

Гүйцэтгэлийн аудит нь шалгагдагч этгээдийн бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэхэд аудит хийж, тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргана.

Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн аудит нь шалгагдаж буй байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн нөөцийг хэрхэн арвич хямгач, үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй ашиглаж байгааг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган шалгагдагч байгууллага, холбоотой талуудад хүргүүлэх, аудитын дараах үе шатны ажлын явцад зөвлөмжийн хэрэгжилтийг хянан үзэж, аудитын үр өгөөжийг тооцон гүйцэтгэж байна.

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тодорхой сэдвийн хүрээнд нэгдсэн удирдамжаар, нийгмийн захиалга, бодлогоор нийгэм, эдийн засгийн салбар, төсвийн хөрөнгийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж шалгагдагч байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг сайжруулах асуудлыг нотлох баримтад түшиглэн тайлагнаж, дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна




Төрийн аудитын тухай хууль болон Аудитын сэдэв сонгох ажиллагааны журмыг үндэслэн Төрийн аудитын байгууллагын бодлогоор хийгдэх аудитын сэдвийн саналыг боловсруулахдаа Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т :

11.3.1.тухайн сэдвээр урьдчилсан судалгаа, тооцоолол хийгдсэн байх;

11.3.2.төсөв, санхүү, хугацаа болон хүний нөөцийн чадавхтай байх;

11.3.3.иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал байх гэж заасан шалгуурыг баримтлан жил санал цуглуулж, аудитын сэдвийн сонголтыг тусгайлсан аргачлалаар эрэмбэлэн үнэлж, нэгтгэн тайлагнаж байна.

Төрийн аудитын байгууллагаас бодлогоор хийгдсэн аудитыг төрлөөр харвал гол төлөв гүйцэтгэлийн аудит зонхилж байгаа бөгөөд салбараар авч үзвэл уул уурхай, олборлолт, төсөв, санхүү, даатгалын салбарт тогтмол аудит хийсэн, харин байгаль орчин, боловсролын салбарт үе шаттай аудит хийсэн бөгөөд эрүүл мэнд, тээвэр, эрчим хүчний салбарт аудитыг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын сэдэв, салбараар:



ТАБ-ын бодлогоор уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн өмчит компаниудын үйл ажиллагаа, төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байдал, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитаар, төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж, хууль, эрх зүйн орчин, тогтолцоог сайжруулах зөвлөмж хүргүүлэв

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн


зардлын гүйцэтгэлд аудит хийж, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарч ажиллалаа

Улсын хэмжээнд гүйцэтгэж буй хөрөнгө оруулалтын шинж чанартай томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт болох газрын тос боловсруулах, нисэх буудал, цахилгаан станц, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан арга хэмжээний хүрээнд цахилгааны дэд станц, цэцэрлэг, авто замын төслийн хэрэгжилтэд аудит хийж, гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, төслийг цаг хугацаанд нь үр нөлөөтэй хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагуудад зөвлөмж болголоо

Гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг сайжруулахын тулд тухайн сэдвээр аудит хийх урьдчилсан судалгааны ажилд зарцуулах хугацааг зохистой болгон төрийн аудитын стандартын зарчмыг баримтлан улсын хэмжээнд хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулсан зардлын хязгаарлалттай, сөрөг үр дагавар багатай, хэрэгжихэд дэмжлэг болохуйц бодит хугацааны чанартай аудит гүйцэтгэсэн байна.







## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, гарын авлагад нийцүүлэн гүйцэтгэсэн байна.

УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын сэдэв батлах тухай”, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аудитыг төрийн байгууллага болон төрөөс санхүүжилт авсан хуулийн этгээдийг хамруулан 2019 онд 165, 2020 онд 160, 2021 онд 195, 2022 онд 179, 2023 онд 124 сэдэвт аудитыг төрөлжсөн аудитын газрууд болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас гүйцэтгэсэн төлөвлөгөөт аудитыг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, гарын авлагад нийцүүлэн гүйцэтгэлд чанарын хяналтыг хэрэгжүүлэн хэрэгжүүлсэн байна.

**ЗОРИЛТ 1.4.8:** Төлөвлөгөөт хугацаанд нийцлийн аудитыг чанартай гүйцэтгэх**СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН** : Төрийн аудитын байгууллага 2018 онд баталсан аудитын сэдэв, төлөвлөгөөний хүрээнд 97 нийцлийн аудитыг гүйцэтгэсэн

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**: Нийцлийн аудитын тоо, чанар, үр дүнгийн үзүүлэлт

**ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Төрийн аудитын байгууллагын нийцлийн аудит нь іалгагдагч этгээд үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон төрийн байгууллага үйл ажиллагаандаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа байдлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гаргаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын зөвлөмжид үндэслэн Засгийн газар, Сангийн яамнаас ажлын хэсэг гарч “Шилэн дансны тухай хууль”-ийн шинэчлэл, бусад хууль тогтоомжтой нийцсэн байдал, шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын санал боловсруулах ажил хийгдэж байна.

- Төрийн аудитын байгууллагаас жил бүр давтан хийж буй “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”, “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт” зэрэг аудитын үр дүнд алдаа, зөрчлийн хэмжээ буурсан байна.

- Улсын хэмжээнд газрын бүртгэл хөтлөх, газрын нэгдмэл сангийн тайлан, мэдээ гарах үйл ажиллагаанд аудитаар гарч байгаа зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн, хяналт хариуцлагыг сайжруулах зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

- Орон нутгийн хөгжлийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын зөвлөмж, албан шаардлагын дүнд Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн үйл ажиллагааны журам батлагдсан, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал” шинэчлэн батлагдсан байна

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулагдсантай холбогдуулан намуудын хандивын тайлан, мөрийн хөтөлбөр, сонгуулийн зардлын тайлан баталгаажуулах аудитыг хуулийн хугацаанд гүйцэтгэсэн байна. “Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах"-д 201 бие даан нэр дэвшигч, 15 нам, 4 эвсэл мөрийн хөтөлбөрөө ирүүлсэн бөгөөд 173 бие даан нэр дэвшигч, 15 нам 4 эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гарган хуульд заасан хугацаанд Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлэн ажиллав

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлсэн нам, эвсэл сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”- ыг батлав.

- Сонгуулийн хандивын зардалд хяналт тавих мэдээллийн системийг нэвтрүүлэв.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбоотой аудитын дүгнэлт, тайланг хуулийн хугацаанд олон нийтэд мэдээлэв

Улс, нийтэд учирч болзошгүй эрсдэлд суурилсан олон нийтийн анхааралд байгаа нийтийн ашиг сонирхлыг хөндсөн бодит цагийн /Real time audit/ аудитыг гүйцэтгэв.

- Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн 2021 оны 2 дугаар сарын 11-23-ны өдрүүдэд улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлсэн “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний үр дүн;
- Коронавируст халдварт (ковид-19) цар тахалтай холбоотой хүлээн авсан 2020 оны хандив, тусламжийн орлого, зарцуулалтыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн байдал;
- Ковид-19 цар тахлын халдварын эмчилгээнд хэрэглэж буй вирусийн эсрэг эм, тарилга худалдан авсан үйл ажиллагаа.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Төлөвлөгөөт хугацаанд нийцлийн аудитыг чанартай гүйцэтгэх

Нийцлийн аудитыг Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд шалгагдагч этгээдийн явуулж буй үйл ажиллагаа нь хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын гаргасан шийдвэр, бодлого, дүрэм, журам, төрийн албаны зарчимд нийцэж буй эсэхийг үнэлж дүгнэх, аудитын явцад илэрсэн зөрчлийг арилгах, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг боловсронгуй болгох бөгөөд нийцлийн аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж нь голчлон хууль тогтоомж байх бөгөөд аудитын зорилго нэмэгдэх, аудитын стратегийг хэрэгжүүлэх, төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, аудитын мөрөөр хийх үе шатны ажлын нөхцөл байдалд тохирох тусгайлсан шаардлага, горим, сорилыг боловсруулан мөрдөж болно.

Нийцлийн аудитыг бие даасан аудит болгон хийхдээ хуульд зааснаар Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн дагуу өөрсдийн санаачилгаар төлөвлөж гүйцэтгэсэн бөгөөд 2019-2023 200 гаруй сэдвийн хүрээнд нийцлийн аудитыг төлөвлөгөөт хугацаанд нийцлийн аудитыг чанартай гүйцэтгэсэн болно.

### ЗОРИЛТ 5: Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх зорилтын хэрэгжилт

№	Зорилт	Гүйцэтгэлийн хэмжүүр	2019	2020	2021	2022	2023	2024*
1.5.1	Сургалт хөгжлийн стратегиар тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэх	Сургалт, хөгжлийн стратегиар тодорхойлсон зорилтууд бүрэн хэрэгжсэн байх			2			15
1.5.2	Төрийн аудитын мэргэшсэн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурласан цалин хөлс, урамшуулал болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх	Төрийн аудитын мэргэшсэн ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурласан цалин хөлс, урамшуулал болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх тогтолцоог боловсруулсан баримт бичиг гарч хэрэгжсэн байх	2	2	2	6	1	2
1.5.3	Мэргэшсэн хүний нөөцийг дотоодын сургалтын байгууллагад сургаж дадлагажуулж, чадавхжуулах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх	Дотоодын сургалтын байгууллагаар мэргэжлийн аудитор бэлтгэж, аудитаар тодорхой түвшинд мэргэшсэн хүнийг сонгон шалгаруулалтаар авч ажиллуулдаг тогтолцоо бүрдүүлсэн байна.	20	1	3	3	3	2
1.5.4	Төрийн аудитор бэлтгэх сургалтын тогтолцоо бий болгох	Гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн аудитаар өндөр мэдлэг чадвар бүхий аудиторуудыг бий болгох мэргэжлийн тасралтгүй сургалтыг зохион байгуулж хэвшсэн байна. ТАБ-д сургалтын нэгжийг бий болгон сургагч багш нарын баг бүрдүүлэн ур чадвар, арга зүйг өндөр түвшинд хүргэнэ.		1		4	1	2
1.5.5	Төрийн аудитын байгууллагын сургалтын хэлбэр, арга зүйд шинэчлэлт хийж, сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэх	Аудитын төрөл тус бүрээр заавал судлах хичээлүүдийг онлайн хэлбэрээр эзэмших ажилтны тоог 80 хувьд хүргэх, сургалтад олон улсын арга зүй туршлагыг авч ашиглах	2	6	4	1	2	2
1.5.6	Сургалтын орчныг иж бүрэн бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх	Сургалтын гарын авлага, материалын хангамж хүрэлцээг сайжруулж, төрлийг нэмэгдүүлсэн байна	1	1		1		2
1.5.7	Цахим сургалтын системийг бий болгох	Төрийн аудитын байгууллагын сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж, сургалтын удирдлагын дэд систем бий болсон байна.			3	3	4	5
			25	11	14	18	11	30

**ЗОРИЛТ** 1.5.1: Сургалт хөгжлийн стратегиар тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэх

### **СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН** : Сургалт хөгжлийн стратегийн баримт бичиг байхгүй

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**: Стратегийн баримт бичиг боловсруулах шаардлага

### **ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

*ТАБ-ын 2018-2023 оны сургалт, хөгжлийн стратегийн төлөвлөгөө боловсруулж, батлуулав*

Төрийн аудитын байгууллагын 2018-2022 оны сургалт, хөгжлийн стратегийн хүрээнд 2019 онд аудитыг хөгжүүлэх, ажилтнуудын мэдлэг, мэргэшил, ур чадварыг хөгжүүлэх төвлөрсөн сургалт, хөтөлбөрийн хүрээнд удирдах болон шинэ ажилтны, төрөлжсөн аудитын, чанарын баталгаажуулалтын, АИТ-ын гишүүдэд зориулсан, гадаад сургалтад хамруулах гэсэн чиглэлээр хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүллээ. ТАБ-ын хэмжээнд ҮАГ-аас зохион байгуулсан нийт 166 удаагийн сургалтад 636, гадаад улсад зохион байгуулагдсан 10 сургалтад 19, ажлын байранд хийгдсэн 264 сургалтад 1490, бусад байгууллагаас зохиосон 139 сургалтад 575 хүн, давхардсан тоогоор нийт 2720 хүн хамрагдлаа.

ҮАГ-ын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, тэдний ур чадварыг сайжруулах, арга зүйг хөгжүүлэх, шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, дүрэм, журмын талаар мэдлэг, мэдээллээр хангах 243 цагийн төвлөрсөн сургалтууд зохион байгуулсан нь 92 хувийн гүйцэтгэлтэй буюу нийт ажилтнууд жилд 1.3 удаагийн давтамжтай уг зорилтот арга хэмжээнд хамрагдсан байна. ТАБ-ын нийт ажилтнуудаас сургалтад хамрагдаж кредит/цаг тооцуулсан гэрчилгээтэй ажилтны тоо 254-т хүрсэн нь аудиторуудын мэдлэг чадварыг хөгжүүлэх 2019 онд гол зорилтоо хангажээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/30 дугаар тушаалаар байгууллагын 2020 оны сургалтын чиглэл, ерөнхий болон дэлгэрэнгүй төлөвлөгөө, хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж байна. ТАБ-ын хувьд 2020 он цахим сургалт, хөгжлийн нэгдсэн системийг боловсруулан хөгжүүлэлт хийн бэлтгэл ажлыг хангаснаар сургалтын тогтолцоог шинэ шатанд гаргав. Бусад төрийн байгууллагуудад жишиг болох цахим сургалтын системийг хөгжүүлж, цогц мэдлэгийг системтэй олгох цахим хичээлийг нэвтрүүлснээр сургалтад нийт албан хаагчид хамрагдаж, 94 хувийн амжилттай дүгнэгдсэн байна.

ТАБ-ын 2021 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний сургалтын дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. Дотоод сургалтад нийт 40 сургалт төлөвлөсөн.





Тэдгээр сургалтаас 14 сургалт нь цахим сургалтын үндсэн сургалт хэлбэрээр зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн бөгөөд е-хичээл бэлтгэх ажлын явц харилцан адилгүй байсантай холбоотой зохион байгуулж чадаагүй хичээлийн агуулгыг багцалсан сургалтуудыг зохион байгуулсан.

ТАБ-ын 2022 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд дотоод сургалтын 6 багцын 45, гадаад сургалтын 8 багц сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнээс үндсэн сургалтын хувьд 9 сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, нийт 1246 албан хаагчийг сургасан. ТАБ-тай гэрээгээр санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэж буй 52 Аудитын хуулийн этгээдийн аудаторуудыг чадавхжуулах дараах 3 сургалтад тус бүр 269 хүнийг хамруулан 2022.11.28-ны өдрөөс эхлэн 4 долоо хоногийн хугацаатай зохион байгуулсан. Хөгжлийн сургалтын хувьд 57 сургалтын багцад нийт давхардсан тоогоор 3833 албан хаагч хамрагдсан.

Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан болон бусад үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 35 онлайн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 2888 албан хаагчийг хамруулсан. Танхимын 11 сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 385 албан хаагч хамрагдсан. ТАБ-ын 2022 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, үр дүнг 2022 оны эхний хагас жилээр тайлагнасан бөгөөд жилийн эцсийн үр тайлагнасан.

*ТАБ-ын 2023-2027 оны сургалт, хөгжлийн стратегийн төлөвлөгөө боловсруулж, батлуулав.*

АХБ-ны техникийн туслалцааны хүрээнд “ТАБ-ын чадавхыг бэхжүүлэх” төслийн 3 дахь бүтээгдэхүүн болох сургалтын хөтөлбөр боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлсэн багтай хамтран ТАБ-ын сургалт, хөгжлийн стратегийг шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэв.



Төрийн аудитын байгууллагын 2023-2027 оны сургалт хөгжлийн стратегийг боловсруулах ажлын хүрээнд нэгжийн удирдлага, менежерүүдээс хэрэгжиж дууссан сургалт, хөгжлийн стратегийн хэрэгжилт, түүний үр дүн, алдаа дутагдал, боломж, давуу талыг тодорхойлох, тэдгээрийг хэрхэн засах, сайжруулах талаар зөвлөмж гаргах, албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлон, сургалт, хөгжлийн үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөхөд анхаарах асуудлуудыг тодорхойлох 22 асуулга бүхий судалгааг зохион байгуулж, сургалт, хөгжлийн стратегийг шинэчлэн боловсруулж батлав.



Төрийн аудитын байгууллагын сургалт хөгжлийн 2023-2027 оны стратеги нь 3 зорилт, 19 арга хэмжээг тусган боловсруулж, МУЕА-ын 2023 оны А105 дугаар тушаалаар батлан 2 дахь шатны сургалт, хөгжлийн стратегийг хэрэгжүүлж эхлээд байна.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Сургалт, хөгжлийн стратегиар тодорхойлсон зорилтууд бүрэн хэрэгжсэн байх

Төрийн аудитын байгууллагын сургалт хөгжлийн 2018-2023 оны стратегийг батлан хэрэгжүүллээ. Стратегиар тодорхойлсон зорилтын хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг жил батлан бүрэн хэрэгжүүлж, жил бүрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэв.

Төрийн аудитын байгууллагын сургалт хөгжлийн 2023-2027 оны стратегийг батлан 2 дахь сургалтын стратегийг хэрэгжүүлж байна.

**ЗОРИЛТ** 1.5.2: Төрийн аудитын мэргэшсэн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурласан цалин хөлс, урамшуулал болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх

### **СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН** : МУЕА-ын 2015 оны “Баримт бичиг батлах тухай” А/203 дугаар тушаалаар “Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”, “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, “ Нийгмийн хамгааллын хөтөлбөр” гэх баримт бичгүүд батлагдсан ч хугацаа дууссан байдалтай байна.

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**: Бодлогын баримт бичиг боловсруулах шаардлагууд

### **ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/43 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ тогтоох, Монгол Улсын Их Хуралд өргөн барих, хэлэлцүүлэхэд бэлтгэн батлуулах” чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан. Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 56 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг батлуулснаар төрийн хяналтын байгууллага, нийт албан хаагчдын улс, нийтийн өмнө хүлээсэн чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чухал дэмжлэг болсон.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 56 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн батлуулсан. 2019 онд цалингийн хувь хэмжээг тогтоохдоо Төрийн аудитын байгууллагын онцлог, хараат бусаар ажиллах нөхцөл байдлыг харгалзан тухайн үеийн АА, ТЗ, ТТ-ийн ангилал зэрэглэлийн цалингаас 35-41.6 хувиар илүү хэмжээгээр баталгаажуулж ажилласан байна.

Төрийн аудитын байгууллага нь батлагдсан орон тооны дээд хязгаар болох 394 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулснаас ҮАГ-т 115, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газарт 279 албан хаагч ажилласан бөгөөд ажлын ачаалал их, хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан тайлант онд 41 гэрээт ажилтан авч ажиллуулсан байна. Аймаг дахь Төрийн аудитын газрууд хүний нөөцийн дутагдлаас үүдэн төрөлжсөн аудитын чиглэлээр ажиллах боломжгүй, аудиторуд бүх төрлийн аудитад оролцож байна. Орон нутагт гүйцэтгэл болон нийцлийн аудитын багт нарийн мэргэжлийн мэргэшсэн /инженер, барилга, замын мэргэшсэн төсөвчин гэх мэт/ ажилтныг гэрээгээр авч ажиллуулах асуудал төсөв, санхүүгээс хамааран орхигдсон байна.

Албан хаагчдын 2020 онд илүү цагаар ажилласан бүртгэлээс зөвхөн Үндэсний аудитын газрын албан хаагчдын хувьд авч үзэхэд нийт албан хаагчдын 31 хувь нь илүү цагаар ажиллаж нэг албан хаагч 7 хоногийн ажлын 5 өдөрт 40 цаг ажиллахаас гүйцэтгэлээр 60-70 цаг байгаа нь хүний нөөцийн хувьд дутагдалтай ажилласныг харуулж байна. Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүний нөөц шаардлагатай байгааг үндэслэн УИХ-ын Төсвийн

байнгын хорооны 2020 оны 06 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын орон тооны хязгаарыг өөрчлөн баталсны дагуу зохион байгуулалт, бүтэц, орон тоо, чиг үүргийн өөрчлөлтийг 2021 оноос зохион байгуулж мөрдүүлэхээр зорилт дэвшүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлжээ.

Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрхэлсэн ажилдаа үр бүтээлтэй ажилласан нийт 48 албан хаагчийг холбогдох шагналаар шагнуулж, 153 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулж, 14 албан хаагчид шинээр зэрэг дэв олголоо. Хүний нөөцийн бодлогыг төлөвшүүлэх хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/54 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтын журам”, А/55 дугаар тушаалаар “Тусгай шалгалтын комиссын ажиллах журам”-ыг тус тус батлуулж мөрдүүлэн ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг нэмэгдүүлэн, шинэчлэн тогтоох зайлшгүй шаардлага тулгараад байгааг онцгой анхаарч 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдөр МУИХ-ын төсвийн байнгын хороонд Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалинг шинэчлэн тогтоох УИХ-ын тогтоолын төслийг холбогдох тооцоолол судалгаанд үндэслэн хүргүүлж, үүний үр дүнд МУИХ-ын 2023 оны 7-р сарын 6-ны өдрийн “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 65-р тогтоол батлагдаж цалингийн дундаж өсөлт 64.8 хувьд хүрсэн байна.

Төрийн аудитын байгууллагын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Төрийн албаны тухай хууль болон хөдөлмөрийн дотоод журмын дагуу 2019 онд 10 албан хаагчид 111.8 сая төгрөг, 2020 онд 12 албан хаагчид 235.0 сая төгрөг, 2021 онд 60 албан хаагчид 724.6 сая төгрөг, 2022 онд 37 албан хаагчид 258.8 сая төгрөг, 2023 онд 85 албан хаагчид 1.540,0 төгрөг буюу нийт 204 албан хаагчид 2,870.2 сая төгрөгийг нийгмийн асуудлын хүрээнд шийдвэрлэсэн байна.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Төрийн аудитын мэргэшсэн ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурласан цалин хөлс, урамшуулал болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх тогтолцоог боловсруулсан баримт бичиг гарч хэрэгжсэн байх

Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг 2 удаа нэмэгдүүлэн, МУИХ-ын 2023 оны 7-р сарын 6-ны өдрийн “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 65-р тогтоол батлагдаж цалингийн дундаж өсөлт 64.8 хувьд хүрсэн байна.

Төрийн аудитын байгууллагын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Төрийн албаны тухай хууль болон хөдөлмөрийн дотоод журмын дагуу 2019 онд 10 албан хаагчид 111.8 сая төгрөг, 2020 онд 12 албан хаагчид 235.0 сая төгрөг, 2021 онд 60 албан хаагчид 724.6 сая төгрөг, 2022 онд 37 албан хаагчид 258.8 сая төгрөг, 2023 онд 85 албан хаагчид 1.540,0 төгрөг буюу нийт 204 албан хаагчид 2,870.2 сая төгрөгийг нийгмийн асуудлын хүрээнд шийдвэрлэсэн байна.

**ЗОРИЛТ 1.5.3:** Мэргэшсэн хүний нөөцийг дотоодын сургалтын байгууллагад сургаж дадлагажуулж, чадавхжуулах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх

### **СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН :** Албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрийн мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Сургалт хөгжлийн 2018 оны дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулж батлуулан, тус төлөвлөгөөний хүрээнд давхардсан тоогоор 681 ажилтныг хамруулсан.

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Мэргэшсэн хүний нөөцийг дотоодын нөөц боломжид тулгуурлан сургаж дадлагажуулж, чадавхжуулсан сургалтын тоо, суралцагчдын тоо

#### **ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ТАБ-ын 2018-2022 оны сургалт, хөгжлийн стратегийн хүрээнд дотоод сургалтын 2019 оны чиглэл, төлөвлөгөөг арга зүй, зохион байгуулалтаар дэмжиж хэрэгжилтийг зохион байгууллаа.

Аудитыг хөгжүүлэх, ажилтнуудын мэдлэг, мэргэшил, ур чадварыг хөгжүүлэх төвлөрсөн сургалт, хөтөлбөрийн хүрээнд удирдах болон шинэ ажилтны, төрөлжсөн аудитын, чанарын баталгаажуулалтын, АИТ-ын гишүүдэд зориулсан, гадаад сургалтад хамруулах гэсэн чиглэлээр хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүллээ. ТАБ-ын хэмжээнд ҮАГ-аас зохион байгуулсан нийт 166 удаагийн сургалтад 636, гадаад улсад зохион байгуулагдсан 10 сургалтад 19, ажлын байранд хийгдсэн 264 сургалтад 1490, бусад байгууллагаас зохиосон 139 сургалтад 575 хүн, давхардсан тоогоор нийт 2720 хүн хамрагдлаа.

ҮАГ-ын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, тэдний ур чадварыг сайжруулах, арга зүйг хөгжүүлэх, шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, дүрэм, журмын талаар мэдлэг, мэдээллээр хангах 243 цагийн төвлөрсөн сургалтууд зохион байгуулсан нь 92 хувийн гүйцэтгэлтэй байна. ТАБ-ын нийт ажилтнуудаас сургалтад хамрагдаж кредит/цаг тооцуулсан гэрчилгээтэй ажилтны тоо 254-т хүрсэн байна.

ТАБ-ын ажилтнуудын мэдлэг шалгахад ашиглахаар хууль, тогтоомж, аудитын төрлийн талаарх мэдлэгийг сорих 358 тестийг шинээр боловсруулан, өмнө нь санд байгаа аудитын суурь журам, стандартад орсон өөрчлөлт болон ерөнхий мэдлэг шалгах 677 тестийг дахин хянаж өөрчлөлтийг оруулснаар нэмж тестийн сан 1295 болж баяжилт хийгдсэн байна.

ТАБ-ын сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг системтэйгээр төлөвлөн хэрэгжүүлж, үүний үр дүнд бусад төрийн байгууллагуудад жишиг болох цахим сургалтын системийг хөгжүүлж, цогц



мэдлэгийг системтэй олгох цахим хичээлийг нэвтрүүлснээр сургалтад нийт албан хаагчид хамрагдаж, 94 хувийн амжилттай дүгнэгдсэн байна. Дотоод сургалтын хувьд цахим 10, танхимын 5, онлайн 16, бусад байгууллагуудаас зохион байгуулсан 8, нийт 39 удаагийн сургалтад давхардсан тоогоор 5378 албан хаагчийг хамруулсан.

Удирдлагын академиас зохион байгуулсан Төрийн албаны хүний нөөцийн удирдлага ба сургалтын тогтолцоо, Монгол Улсын хөгжлийн бодлого: Төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа-2050, Төсвийн хөрөнгө оруулалт: Үр ашгийн болон эрсдэлийн шинжилгээ, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас мэдээллийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх цахим болон Худалдан авах ажиллагааны суурь ойлголт АЗ гэрчилгээ олгох сургалтуудад албан хаагчдыг хамруулсан. ТАБ-ын иргэдийн оролцооны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд Power BI сургалт, инфографик сургалтад хамруулсан үр дүнтэй үйл ажиллагааг зохион байгууллаа.

АХБ-ны дэмжлэгтэй сургалтын зөвлөх үйлчилгээгээр Төрийн аудитын байгууллагын аудитуудыг чадавхжуулах шаталсан сургалтын хөтөлбөрийн 20 үндсэн сургагч багшийг 3 аудитын төрөл тус бүрт бэлтгэхээр төлөвлөсөн бөгөөд үүний дагуу Үндэсний аудитын газар болон Нийслэл дэх Төрийн аудитын газрын аудит хийх чиг үүрэг бүхий бүтцийн нэгж болон холбогдох бусад нэгжүүдээс сургагч багш нарыг нэр дэвшүүлсэн 20 сургагч багшийг сонгон, сургалтын арга зүйн сүүлийн үеийн технологи, сургалтыг удирдан зохион байгуулах, практик мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх сургалтад амжилттай суралцаж сургагч багшийн сертификаттай төссөн.

Мөн АНТАГ-ын дотоод сургалт хариуцсан албан хаагчид болон мэдлэг, туршлага хуваалцах сургагч багшаар ажиллах нийт 50 албан хаагчийг МУБИС-ийн Боловсрол судлалын сургууль, Насан туршийн боловсролын тэнхимийн багш, доктор, зөвлөх профессор С.Эрдэнэцэцэгээр бэлтгүүлсэн “Сургагч багш бэлтгэх сургалт” 1 кредит цагийн агуулга бүхий цахим сургалтад 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 4 долоо хоногийн хугацаатай хамрууллаа.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Дотоодын сургалтын байгууллагаар мэргэжлийн аудитор бэлтгэж, аудитаар тодорхой түвшинд мэргэшсэн хүнийг сонгон шалгаруулалтаар авч ажиллуулдаг тогтолцоо бүрдүүлсэн байна.

Мэргэшсэн хүний нөөцийг дотоодын сургалтын байгууллагад сургаж дадлагажуулж, чадавхжуулах ажлын хүрээнд Төрийн аудитын байгууллагын хэмжээнд сургагч багш нарыг жил бүр бэлтгэн сургаж дадлагажуулан ажлын байран дээрх сургалтыг тасралтгүй хэрэгжүүлж хэвшсэн байна.

**ЗОРИЛТ 1.5.4:** Төрийн аудитор бэлтгэх сургалтын тогтолцоо бий болгох

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** Төрийн аудиторыг аудитын төрөл бүрээр дагнасан мэдлэг чадвар олгох сургалт, тогтолцоо байхгүй

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Сургалтын тоо, суралцагчдын тоо, эдгээрийн өсөлтийн хувь

#### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

*Аудиторын чадамжийн хүрээ (үзэл баримтлал)-г тодорхойлж батлуулав.*



АХБ-ны техникийн туслалцааны хүрээнд “ТАБ-ын чадавхыг бэхжүүлэх” төслийн 3 дахь бүтээгдэхүүн болох сургалтын хөтөлбөр боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх бүрэлдэхүүнтэй ТАБ-ын аудит гүйцэтгэх чиг үүрэг бүхий албан хаагчдын “Чадамжийн хүрээ”-г тодорхойлох, баримт бичгийг боловсруулах ажлыг дараах үе шаттай гүйцэтгэв.



Чадамжийн хүрээний төслийг аудит гүйцэтгэх чиг үүрэг бүхий албан тушаалын ялгаатай бүлгүүд болох аудитор, ахлах аудитор, аудитын менежер, тэргүүлэх аудитор гэсэн албан тушаалын шатлал бүрд танхим болон онлайн хэлбэрээр нийт 8 бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналуудыг тусган чадамжийн хүрээний төслийг боловсруулав.

Чадамжийн 16 хүрээний саналуудыг нэгтгэсэн эцэслэсэн хувилбараар чадамжийн өөрийн үнэлгээний судалгаа хийн, үр дүнг нэгтгэсэн үзүүлэлтүүдийг нэгжийн удирдлага, менежерүүдэд танилцуулсан.

Чадамжийн хүрээний төслийн баримт бичгийг сайжруулан танилцуулж, батлуулах ажлын аудитын арга зүй хариуцсан менежерүүд хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд сургалт, хөгжлийн шинэ стратегийн төлөвлөгөөг боловсруулав.



*Аудиторын чадавхын үнэлгээ хийх, аудиторыг чадавхжуулах шаталсан сургалтын модуль хөтөлбөрийг боловсруулах, бэлтгэх тайлагнав.*

АХБ-ны техникийн туслалцааны хүрээнд “ТАБ-ын чадавхыг бэхжүүлэх” төслийн 3 дахь бүтээгдэхүүн болох сургалтын хөтөлбөр боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх бүрэлдэхүүнтэй ТАБ-ын аудит гүйцэтгэх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээний зөрүүний шинжилгээ буюу албан хаагчдын чадавхын өөрийн үнэлгээ хийх судалгааг 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл ТАБ-ын нийт 387 албан хаагчийг хамруулан Qualtrics судалгааны программыг ашиглан авсан.

Судалгаанд нийт оролцогчдын 83.3 хувь буюу 315 албан хаагч оролцсон бөгөөд судалгааны үр дүнг нэгтгэн 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Өөрчлөлтийн удирдлага сэдэвт зөвлөгөөнөөр төслийн зөвлөх нийт удирдлага, менежерүүдэд танилцуулсан. Судалгааны үр дүнг үндэслэн ТАБ-ын аудиторуудыг тасралтгүй сургах шаталсан сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.

АХБ-ны техникийн туслалцааны хүрээнд “ТАБ-ын чадавхыг бэхжүүлэх” төслийн 3 дахь бүтээгдэхүүн болох сургалтын хөтөлбөр боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх бүрэлдэхүүнтэй ТАБ-ын аудит гүйцэтгэх чиг үүрэг бүхий албан хаагчдын тасралтгүй суралцах чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.

Тус хөтөлбөр нь чадамжийн хүрээнд тулгуурлан боловсруулагдсан бөгөөд 6 багц хөтөлбөрөөс бүрдсэн 45 сургалтыг заавал судлах болон сонгон судлах хэлбэрээр танхим, цахим хосолсон багц сургалт байхаар боловсруулсан.

Тэдгээр сургалтын 9 модуль сургалтыг санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын анхан, дунд, ахисан шаттайгаар боловсруулсан бөгөөд CIPFA-аас эх гарын авлагыг боловсруулан, монгол талын зөвлөхүүд орчуулж, эцсийн хувилбарт ХБТГ-ын арга зүй хариуцсан менежерүүд агуулгын хяналт хийх, SCORM стандарт бүхий ARTICULATE программ дээр хийгдэж буй цахим сургалтын модулиудад техникийн хяналт хийн сайжруулах ажлыг аудитын арга зүй хариуцсан 3 менежертэй хамтран гүйцэтгэж байна.

Тус шаталсан сургалтын хөтөлбөр болон 9 модуль цахим сургалтын материалыг “Өөрчлөлтийн удирдлага” сэдэвт зөвлөгөөнөөр нэгжийн удирдлага болон менежерүүдэд танилцуулсан. Тус хичээлүүдийн Articulate программ дээр хийгдсэн хувилбарт техникийн хяналт, сайжруулалт хийх ажлыг гүйцэтгэж байна.



## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн аудитаар өндөр мэдлэг чадвар бүхий аудиторуудыг бий болгох мэргэжлийн тасралтгүй сургалтыг зохион байгуулж хэвшсэн байна.

ТАБ-д сургалтын нэгжийг бий болгон сургагч багш нарын баг бүрдүүлэн ур чадвар, арга зүйг өндөр түвшинд хүргэнэ.

АХБ-ны дэмжлэгтэй төслийн хүрээнд ТАБ-ын шаталсан сургалтын хөтөлбөрийн 20 үндсэн сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг үе шаттай зохион байгуулж, сертификат олгосон. Түүнчлэн 21 аймгийн дотоод сургагч багш нарын баг бүрдүүлэн ур чадвар, арга зүйг сургаж дадлагажуулан бэлтгэж, сертификат олгосон бөгөөд жил бүр сургагч багш нарын бүртгэлийг хөтлөн байнгын тасралтгүй сургалтыг зохион байгуулж хэвшсэн байна.

**ЗОРИЛТ** 1.5.5: Төрийн аудитын байгууллагын сургалтын хэлбэр, арга зүйд шинэчлэлт хийж, сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэх

### **СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН** : Төрийн аудитын байгууллагын бүсчилсэн болон танхимын зарим сургалтыг зохион байгуулдаг

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**: Сургалтын хэлбэр, арга зүйн шинэчлэл, сайжрал

#### **ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2019 онд ТАБ-ын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний 25-30 хувьд цахим сургалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөөн. Нийт 9 е-хичээлийг бэлэн болгож цахим сургалтын системээр сургалтыг явуулахаар төлөвлөсөн. Цахим сургалтын 1 хичээлийг 12 сэдвээр 3 кредит цагийн агуулга бүхий сургалт байхаар төлөвлөсөн бөгөөд нийт 90 гаруй сэдвээр цахим хичээлийг бэлэн болгохоор дотоод болон гэрээт зөвлөх багш нарийн хичээлийн хөтөлбөр, сургалтын багц материалыг боловсруулах ажлыг эхлүүлсэн. Энэ онд 2 е-хичээл буюу 24 сэдэв хичээл бэлэн болсон ба бусад хичээлүүдийг бэлтгэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 03 дугаар сарын А/30 дугаар тушаалаар ТАБ-ын 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг батлуулсан. ТАБ-ын сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд цахим сургалтын төлөвлөгөөг нэгтгэн төлөвлөсөн бөгөөд цар тахалтай холбоотойгоор зарим сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Хуулийн хэрэглээ (төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга) е-хичээлд “Хууль болон төрийн аудитын стандартын нийцэл, хэрэглээ” сэдэвтэй холбоотой 4 цагийн агуулга бүхий хичээлийг бэлтгэн орууллаа.

Цахим сургалтын үндсэн сургалтад давхардсан тоогоор нийт 1714 албан хаагч хамрагдаж Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын хувьд 4 төрлийн е-хичээлийг давхардсан тоогоор нийт 739 албан хаагч цахимаар суралцаж, сургалтад хамрагдсан албан хаагчдын 62% нь амжилттай суралцсан. Гэрээгээр санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэсэн 60 аудитын хуулийн этгээдийн 337 аудиторыг цахим сургалтын системд бүртгэж, график төлөвлөгөөний дагуу 3 удаагийн 144 цагийн сургалтад давхардсан тоогоор 975 аудиторыг хамруулан, сургалтад хамрагдсан аудиторуудын 42.5% нь амжилттай суралцсан байна.

Төрийн аудитын байгууллагын 2022 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө нь дотоод болон гадаад сургалт бүхий үндсэн 2 бүлэгт нийт 53 төрлийн 1163 цагийн сургалтыг давхардсан тоогоор 8314 албан хаагчдыг хамруулан зохион байгуулахаар төлөвлөсөн. Сургалтын хэлбэрийн хувьд нийт сургалтын 58 хувь нь онлайн, 19 хувь нь цахим, 23 хувь нь танхимын хэлбэрээр зохион байгуулсан.

Онлайн хэлбэрийн эзлэх хувь өндөр байгаа нь гадаад сургалтууд онлайннар зохион байгуулагдсантай холбоотой бөгөөд ТАБ-ын зохион байгуулсан 47 дотоод сургалтын хувьд 47 хувь нь онлайн, 30 хувь нь цахим, 23 хувь нь танхимаар тус тус зохион байгуулагдсан.

Сургалт, хөгжлийн системийн Хөгжлийн сургалтын талбарт “Мэдээлэл, судалгаа”, “Гадаад сургалт” гэсэн нэмэлт 2 модулийн хөгжүүлэлтийн ажлыг



гүйцэтгүүлж, мэргэжлийн болон гадны байгууллагын туршлага, мэдээлэл, судалгаа, шинжилгээний тайлангаар цахим сургалтын санг баяжуулах ажлыг гүйцэтгэв. Хөгжлийн сургалт цэс: Нийт 58 багц материалууд байршсан бөгөөд хөгжлийн сургалтын талбарт 3996 албан хаагч хандаж, шаардлагатай мэдээлэл, сургалт, судалгааг үйл ажиллагаандаа ашиглажээ.

*Төрийн аудитын сургалт, хөгжлийн системд цахим сургалтын санг баяжуулах*

Үндсэн сургалтын талбарт:


ТАБ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд дэх сургагч багш нарыг бэлтгэх хөтөлбөрийн цахим сургалтын багц материалыг МУБИС-ын доктор, дэд профессор багшаар бэлтгүүлсэн бөгөөд тус хичээлийг цахим сургалтын системд байршуулах ажлыг гүйцэтгэж байна.

Мөн УАГ-ын үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэхтэй холбоотой нийт албан хаагчдад зориулсан сургалтын 8 сэдэвтэй сургалтын багцыг зөвлөхөөр ажиллаж буй "Монголын менежментүүдийн зөвлөхийн холбоо" ТББ-аар бэлтгүүлэн системд байршуулах ажлыг гүйцэтгэж байна.

Хөгжлийн сургалтын талбарт: 7 багц сургалт шинээр байршуулав. Тухайлбал;

1. "УИХ-ын Хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулах харилцаа" гэсэн сэдвээр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтын багц
2. Хувь хүний хөгжлийн институтээс зохион байгуулсан цуврал сургалтуудын нэг болох "Ажлын байрны ёс зүй" сэдэвт сургалтын видео
3. "Хувь хүний хөгжлийн цаг-II" хэсгийг шинээр үүсгэн "Business.mn podcast" цувралуудаар сургалтын багц үүсгэв: Ажилдаа амжилтыг уургалахуй, Дадал зуршлаа удирдан өөрийгөө хөгжүүлэх, Өглөөний цагийг хэрхэн өөртөө үр бүтээлтэй зарцуулах, Өөрчлөлтийн сэтгэл зүй - Өөрийгөө олсон хүн бусдад олддог сэдвээр дасгалжуулагч багш нарын ярилцлагыг цувралаар байршуулав.

» ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ



"Тушаалын төсөл боловсруулах, баталгаажуулах арга зүйн зөвлөмж" ЗХЭЭГ-ын захиргааны менежер Ч.Сүрэнхорол

2023.10.23

Үзэх




Data School-н танилцуулга болон хичээлүүдийг судлах зааварчилгаа өгөх сургалт

2023.04.27

Үзэх



Макро эдийн засгийн бодлого, тэдгээрийн хэрэглээ (Сангийн болон мөнгөний бодлогыг талаар) Багш: МУИС-ын Бизнесийн сургуулийн санхүүгийн тэнхимийн багш, доктор, профессор Д.Сувдаа



Хувь хүний хөгжлийн цаг-II /Business.mn podcast/

2023.03.29

Үзэх









4. Шинэ ажилтны чиглүүлэх сургалтын багц-1 буюу ТАБ-ын талаар ойлголтыг гүнзгийрүүлэхэд туслах багц хэсэгт шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан байдлаар 6 видео материал болон кодкаст байршуулав.

5.

6. Макро эдийн засгийн бодлого, тэдгээрийн хэрэглээ (Сангийн болон мөнгөний бодлогыг талаар) сургалтын багц /МУИС-ын БС-ийн санхүүгийн тэнхимийн багш, доктор, профессор Д.Сувдаа/
7. Data School-н танилцуулга болон хичээлүүдийг судлах зааварчилгаа өгөх сургалтын багц
8. ОУ-ын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын танилцуулга сургалтын багц гэх мэт

Аудитын 5 минут талбарт 11 багц сургалт шинээр байршуулав. Тухайлбал;

1. "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл, хэрэгжүүлэх заавар" сэдэвт сургалтын багц /
2. "Аудитын чанарын хяналтын журам"-ын танилцуулга сургалтын багцыг
3. "ТАБ-ын статистик мэдээг боловсруулах, тайлагнах журам, бүртгэлийн мэдээний маягт, нөхөр заавар, статистик мэдээний маягт нөхөх заавар"-ын танилцуулга сургалтын багц
4. "Аудитын чанарын баталгаажуулалтын журам"-ын танилцуулга сургалтын багц
5. "Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөөг тооцох бодлого, арга зүй" сэдэвт хэлэлцүүлгийн илтгэгч нарын илтгэлийн материалууд

 <p>"ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ БОДЛОГО, ЧИГЛЭЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР" СЭДЭВТ СУРГАЛТЫН БАГЦ</p> <p>МОНГОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭГ ГЭВНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ ЖУРАМ</p> <p>МУИС-ЫН БС-ИЙН САХИУГИЙН ТЭНХИМИЙН БАГШ, ДОКТОР, ПРОФЕССОР Д. СУВДАА</p>	 <p>ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ҮНЭЛЭХ, НЭГТГЭХ МОДУЛЬ</p> <p>МОНГОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭГ ГЭВНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ ЖУРАМ</p> <p>МУИС-ЫН БС-ИЙН САХИУГИЙН ТЭНХИМИЙН БАГШ, ДОКТОР, ПРОФЕССОР Д. СУВДАА</p>	 <p>ХАРИЛЦАГЧ ТАЛУУДАД ЗОРИУЛСАН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН БЭЛТГЭХ ЗААВАР-ЫГ ТАНИЛЦУУЛАХ СУРГАЛТ</p> <p>МОНГОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭГ ГЭВНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ ЖУРАМ</p> <p>МУИС-ЫН БС-ИЙН САХИУГИЙН ТЭНХИМИЙН БАГШ, ДОКТОР, ПРОФЕССОР Д. СУВДАА</p>	 <p>АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ БОДЛОГО, АРГА ЗҮЙ СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ИЛТГЭГЧ НАРЫН ИЛТГЭЛИЙН МАТЕРИАЛУУД</p> <p>МОНГОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭГ ГЭВНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ ЖУРАМ</p> <p>МУИС-ЫН БС-ИЙН САХИУГИЙН ТЭНХИМИЙН БАГШ, ДОКТОР, ПРОФЕССОР Д. СУВДАА</p>
<p>д аудитын байгууллагын элийн төлөвлөгөө боловсруулах, гах, үнэлэх журам"-ын танилцуулга / ин 2023 оны А/01 тоот тушаалаар эн батлагдсан журам/ ЗХЭЭГ-ын аны менежер Ч.Сүрэнхорол</p> <p>23</p> <p>Үзэх</p>	<p>"Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хүлээн авах, үнэлэх, нэгтгэх модуль" сэдэвт сургалт</p> <p>2023.09.07</p> <p>Үзэх</p>	<p>"Харилцагч талуудад зориулсан аудитын хураангуй тайлан бэлтгэх заавар"-ын танилцуулга ХБТГ-ын аудитын арга зүй хариуцсан менежер П.Цэнгүүн</p> <p>2023.06.07</p> <p>Үзэх</p>	<p>Аудитын шийдвэрийн хэрэгжилт, тү нөлөөг тооцох бодлого, арга зүй сэд хэлэлцүүлэг /2023-05-26/</p> <p>2023.05.30</p> <p>Үзэх</p>
 <p>АУДИТЫН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЖУРАМ</p> <p>МОНГОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭГ ГЭВНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ ЖУРАМ</p> <p>МУИС-ЫН БС-ИЙН САХИУГИЙН ТЭНХИМИЙН БАГШ, ДОКТОР, ПРОФЕССОР Д. СУВДАА</p>	 <p>АУДИТЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ЖУРАМ</p> <p>МОНГОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭГ ГЭВНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ ЖУРАМ</p> <p>МУИС-ЫН БС-ИЙН САХИУГИЙН ТЭНХИМИЙН БАГШ, ДОКТОР, ПРОФЕССОР Д. СУВДАА</p>	 <p>ТАБ-ЫН СТАТИСТИК МЭДЭЭГ БОЛОВСРУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ, БҮРТГЭЛИЙН МЭДЭЭНИЙ МАЯГТ, НӨХӨР ЗААВАР, СТАТИСТИК МЭДЭЭНИЙ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР</p> <p>МОНГОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭГ ГЭВНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ ЖУРАМ</p> <p>МУИС-ЫН БС-ИЙН САХИУГИЙН ТЭНХИМИЙН БАГШ, ДОКТОР, ПРОФЕССОР Д. СУВДАА</p>	 <p>ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ БОДЛОГО, ЧИГЛЭЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР</p> <p>МОНГОЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭГ ГЭВНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ ЖУРАМ</p> <p>МУИС-ЫН БС-ИЙН САХИУГИЙН ТЭНХИМИЙН БАГШ, ДОКТОР, ПРОФЕССОР Д. СУВДАА</p>
<p>ин чанарын баталгаажуулалтын -ын танилцуулга ЧБА-ны ахлах ) Б.Өлзий</p>	<p>"Аудитын чанарын хяналтын журам"-ын танилцуулга ХБТГ-ын аудитын арга зүй хариуцсан менежер П.Цэнгүүн</p>	<p>"ТАБ-ын статистик мэдээг боловсруулах, тайлагнах журам, бүртгэлийн мэдээний маягт, нөхөр заавар, статистик мэдээний</p>	<p>"Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, хэрэгжүүлэх заавар" АНУЗГ-ын ауд</p>

6. "Харилцагч талуудад зориулсан аудитын хураангуй тайлан бэлтгэх заавар"-ын танилцуулга сургалтын багц гэх мэт.

Е-Номын талбарт шинээр 43 ном, гарын авлага, сэтгүүл байршуулав:

1. Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагын 2023-2028 оны стратеги төлөвлөгөө
2. "Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд Аудитын Дээд Байгууллагууд, Авлигатай тэмцэх байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах нь: Практик гарын авлага"

3. Financial audit ISSAI implementation handbook
4. АХС-ын Тогтвортой Хөгжлийн Зорилгын Аудитын Загвар (АТАЗ) - IDI's SDG Audit Model (ISAM)өрийн аудит сэтгүүл /2023.I улирал/
5. ИНТОСАИ-н Ерөнхий нарийн бичгийн даргын тайлан /24 дүгээр их хурал /2022 он 10 сар/
6. Сэдэв I-Үндсэн баримт бичиг "Онцгой байдлын үед Аудитын дээд байгууллагын гүйцэтгэх үүрэг" /2022 он 10 сар/
7. Сэдэв II-Үндсэн баримт бичиг "Дэлхий нийтийн дуу хоолой, дэлхий нийтийн үр дүн, өргөн хүрээг хамарсан үр нөлөө" /2022 он 10 сар/
8. АСОСАИ-н тайлан /2022 он 11 сар Рио де Жанейро хот/
9. Цар тахлын эсрэг засгийн газраас авах хариу арга хэмжээнд Бразилын Тооцооны шүүхээс хийсэн аудит гэх

МООС сургалтын хувьд:

Нийт 40 сургалтын холбоос үүсэв. Мөн өмнө нь үүсгэж байсан “Компьютер дээр 10 хуруугаар бичиж сурах” сургалт, Word, Excel, PowerPoint гэсэн сургалтуудыг баяжуулах ажлыг гүйцэтгэсэн.

ТАБ-ын сургалт, хөгжлийн системд шинээр нэмж байршуулах цахим хичээлүүдийг бэлтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд үндсэн сургалтын 13 сэдэв видео хичээл, хөгжлийн сургалтын 23 видео хичээлийг хариуцсан ЗББН-ийн албан хаагчдаар бичлэгт оруулж, бэлтгэсэн. Нийт үндсэн сургалтад хамрагдсан албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшин 85.5% гэж дүгнэгдсэн.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Аудитын төрөл тус бүрээр заавал судлах хичээлүүдийг онлайн хэлбэрээр эзэмших ажилтны тоог 80 хувьд хүргэх, сургалтад олон улсын арга зүй туршлагыг авч ашиглах

Төрийн аудитын байгууллагын сургалт хөгжлийн системийг аудитын төрөл тус бүрээр заавал судлах, хөгжлийн, өөрийгөө хөгжүүлэх сургалтуудын материалаар баяжуулан шинээр нэмж байршуулах цахим хичээлүүдийг бэлтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд үндсэн сургалтын видео хичээл, хөгжлийн сургалтын видео хичээлийг ЗББН-ийн албан хаагчдаар бэлтгэн хэвшсэн байна. Цахим сургалтын системд Төрийн аудитын байгууллагын 500 гаруй албан хаагч 100 хувьд нэвтрэн системийг бүрэн ашиглан сургалтын үйл ажиллагаанд оролцож байна.

**ЗОРИЛТ 1.5.6:** Сургалтын орчныг иж бүрэн бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх**СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН** : Бие даасан сургалтын орчин бүрдээгүй, сургалтыг гаднын байгууллагын танхимуудыг ашигладаг

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**: Сургалтын орчны нөхцөл байдал, сургалтын материал, хангамжийн үзүүлэлт

**ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ТАБ-ын 2020 оны цахим сургалтын төлөвлөгөөнд төлөвлөгдсөн Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээ болон Хуулийн хэрэглээ (Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга) гэсэн хоёр е-хичээлийн сан бэлэн болгосон. Төрийн аудитын тухай (шинэчилсэн найруулга) хуулийн хүрээнд гэх зэрэг нийт 2000 ширхэг тестийн санг бэлтгэсэн бөгөөд энэхүү тестийн санг цахим системийн туршилтын явцад ашигласан.

Хувь хүний хөгжил хэсэгт шинэ ажилтныг чиглүүлэх сургалтын 5 багц үүсгэн, 59 дүрэм, журам, заавар, 4 бодлогын баримт бичиг, 2 видео танилцуулга, 2 гарын авлага, 1 тайлан, 1 төлөвлөгөө, 2 түншийн үнэлгээний тайлан, 4 аудитын тайлангийн инфографик гээд нийт 75 материал бэлтгэн байршуулсан. МООС хэсэгт төрийн байгууллагуудад хэрэглэгддэг 2 санхүүгийн программын багц хичээлийг бэлтгэн байршуулсан.

Хичээлийг өргөжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Цахим сургалтын системийн е-ном хэсэгт “Аудитын чанарын баталгаажуулалт” “Төрийн аудит стандарт” болон INTOSAI-н 6 ном, гарын авлага гээд нийт 8 номыг PDF хэлбэрээр байршуулсан. Сургалтын болон судалгааны тайлан материалын хангамж хүрэлцээг нэмэгдүүлэх санг бүр дүүлэх зорилгоор Парламентийн судалгааны хүрээлэн, БШУЯ, ШУА, ШУТС, МУИС, ШУТИС, МУБИС, АШУҮИС, СЭЗИС, ХААИС, Мандах их сургууль Төрийн удирдлагын академи, ҮАБЗ-ийн Стратеги, судалгааны хүрээлэн зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, салбар чиглэлийн хамтран ажиллах боломжтой зөвлөх, судлаач шинжээч, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагын судалгааг гаргаж мэдээллийн сан үүсгэсэн байна.

**Үндсэн сургалт:** Цахим сургалтын системийн үндсэн сургалтын талбарт нийт 16 е-хичээлийг багц байршсан.

СЭЗИС-ийн доктор Б.Мөнхзаяа багшаар бэлтгүүлсэн "Эрсдэлийн удирдлага" 3 кредит цагийн 12 сэдэв бүхий сургалтын багц материалын слайд, унших материалыг хянах, сайжруулах ажлыг гүйцэтгэж, видео хичээл бэлтгэгч талтай видео хичээл боловсруулах ажил үргэлжилж байна.

Тайлант онд дараах 2 үндсэн сургалтын е-хичээлийг системд бүрэн байршуулав:

1. ТАБ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд дэх сургалт хариуцсан болон сургагч багш нарыг бэлтгэх цахим сургалтын багц материалыг МУБИС-ын

доктор, дэд профессор С.Эрдэнэцэцэг багшаар бэлтгүүлэн цахим сургалтын системд байршуулав.

2. УАГ Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэхтэй холбоотой нийт албан хаагчдад зориулсан 8 сэдэвтэй сургалтын багцыг "Монголын менежментүүдийн зөвлөхийн холбоо" ТББ-ын зөвлөхүүдтэй хамран бэлтгэж, системд байршуулав.

Үндсэн сургалтын е-хичээл гэрээгээр бэлтгэж буй дараах 2 багштай хийсэн гэрээг сунгах, сургалтын багц материалыг эцэслэн хүлээн авах, гэрээ дүгнэн акт үйлдэх ажлыг гүйцэтгэв.

1. МУИС-ийн Шинжлэх ухаан, технологийн Улаанбаатар паркийн захирал, доктор, профессор О.Мөнхбаттай аудиторуудад зориулсан "Судалгааны арга зүй-1" 3 кредит цагийн 12 сэдэвт цахим сургалтын багц материал бэлтгэх ажлыг хамтран гүйцэтгэж дуусгав.
2. Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, доктор С.Эрдэнэболортой "Хуулийн хэрэглээний нэгдмэл ойлголт-1" 3 кредит цагийн 12 сэдэвт цахим сургалтын багц материал бэлтгэх ажлыг хамтран гүйцэтгэж дуусгав.

**Е-тестийн санд** үндсэн сургалтын 1800 гаруй тест, тусгай шалгалтын 400 гаруй тест, нийт 2200 гаруй тестийн сан үүссэн.

**Хөгжлийн сургалтын** дараах 3 талбарт нийт 76 сургалтын багц үүссэнээс тайлант хугацаанд 18 сургалтын багц шинээр бэлтгэн санг баяжуулав:

1. Хувь хүний хөгжил талбарт 5 багц сургалт
2. Аудитын 5 минут талбарт 11 багц сургалт
3. Сайн туршлагаа хуваалцъя талбарт 2 багц сургалт

**Е-Ном талбарт** нийт 40 ном байршсанаас 11 ном, гарын авлага, сэтгүүлийг тайлант онд шинээр нэмж байршуулав:

**МООС сургалтын** хувьд нийт 40 сургалтын холбоос үүсэв. Мөн өмнө нь үүсгэж байсан "Компьютер дээр 10 хуруугаар бичиж сурах" сургалт, Word, Excel, PowerPoint гэсэн сургалтуудыг баяжуулах ажлыг гүйцэтгэсэн.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Сургалтын гарын авлага, материалын хангамж хүрэлцээг сайжруулж, төрлийг нэмэгдүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллагын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний сургалтын үр дүнг сургалт тус бүрээр үнэлсэн бөгөөд сургалтын үр дүнг үнэлэхдээ сургалтад хамрагдсан албан хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, мэдлэгийн үнэлгээ, сургалтад хамрагдсан байдлыг нарийвчлан үнэлэхээс гадна зохион байгуулалтын нэгжүүдийн ажлын гүйцэтгэл болон бүтээмж хэрхэн өөрчлөгдсөн, аудитын үйл ажиллагаагаар нийгэмд үзүүлж буй нөлөөллийг үнэлэхэд удирдлагуудын оролцоог хангах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх чиглэлүүдийг тодорхойлон ажиллалаа.



**ЗОРИЛТ 1.5.7:** Цахим сургалтын системийг бий болгох**СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ****СУУРЬ ТҮВШИН :** Цахимаар сургалт зохион байгуулж байгаагүй**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Цахим сургалт зохион байгуулах нөхцөл боломжийн бүрдүүлэлт**ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Үндэсний аудитын газар 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр “Нийтийн Нээлттэй Насан Туршийн Боловсролын Олон Улсын Академи” ТББ-тай Онлайн сургалтын мэдээллийн систем хөгжүүлэх, цахим сургалтыг зохион байгуулах /УАГ/БҮА2019-34/ гэрээг 3 жилийн хугацаатай байгуулан хамтран ажилласан.

Тус гэрээний 7.1-д<sup>4</sup> заасны дагуу жил бүр гэрээний хэрэгжилтийн явцыг дүгнэх ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар байгуулан 2020 болон 2021 онуудад гэрээний хэрэгжилтийг дүгнэн ажилласан.

Гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн 2020 болон 2021 оны ажлын хэсэг төрийн аудитын сургалт, хөгжлийн системд хэрэглэгчийн шаардлагын дагуу өгсөн нэмэлт хөгжүүлэлтийн саналууд, түүний биелэлтийг дүгнэн ажиллаж байсан.

Систем хөгжүүлэгч талд хүргүүлсэн санал, түүний биелэлтийг харьцуулан дараах хүснэгтэд харууллаа.

№	Үзүүлэлтүүд	2020 он	2021 он
1	Нэмэлт хөгжүүлэлт хийлгэхээр өгсөн нийт саналын тоо	77	25
2	Бүрэн хөгжүүлэлт хийгдэж дууссан саналын тоо	60	11
3	Системд хөгжүүлэлт хийгдэх боломжгүй саналын тоо	0	2
4	2 тал харилцан ярилцаж шийдвэрлэхээр хойшлуулсан саналын тоо	7	2
5	Тухайн жилд бүрэн хийгдэж дуусгаагүй, хэрэгжүүлэлтийн шатанд байсан саналын тоо	10	10
6	Өгсөн нийт саналын хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээ	98%	90.7%

Гэрээний эхний жилд буюу 2020 онд төрийн аудитын сургалт, хөгжлийн системийн beta хувилбарыг 4 дүгээр сард хүлээн авч туршин, 7 дугаар сард сургалтыг үйл ажиллагаанд үе шаттай нэвтрүүлж, нэмэлт хөгжүүлэлтийн 77 саналыг хүргүүлж ажилласан байна.

<sup>4</sup> 7.1. Гэрээг жил бүр дүгнэж тодотгол оруулна.

**2020**

2019.12.18	2020.03	2020.04.02	2020.06	2020.07
<p><b>Гэрээ байгуулав.</b> Цахим сургалтын мэдээллийн систем хөгжүүлэх, цахим сургалтыг зохион байгуулах гэрээ байгуулагдсан.</p>	<p><b>Цахим сургалтын зураглал, сургалтын төлөвлөгөө боловсруулагдав.</b> Удирдлагын зөвлөлд танилцуулсан.</p>	<p><b>Системийн beta хувилбарыг туршив.</b> Цахим сургалтын системийн beta хувилбарыг хүлээн авч сайжруулалтын ажил эхэлсэн.</p>	<p><b>Е-хичээлийн видео бичлэг эхлэв.</b> Хуулийн хэрэглээ (Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга)</p>	<p><b>Түр журам батлагдав.</b> Цахим сургалт зохион байгуулахад баримтлах түр журам батлагдсан.</p>

2020.07	2020.10	2020.10	2020.12
<p><b>Системийг сургалтад туршив.</b> Системийн туршилт болон III улирлын сургалт эхэлсэн.</p>	<p><b>ТАБ-ын албан хаагчдад системийн эрх нээв.</b> ТАБ-ын бүх албан хаагчийг системд бүртгэн, нэвтрэх эрхийг үүсгэсэн.</p>	<p><b>Системээр сургалт зохион байгуулав.</b> IV улирлын цахим сургалт эхэлсэн.</p>	<p>Цахим сургалтын систем хөгжүүлэгч талтай <b>2020 оны гэрээний биелэлтийг дүгнэсэн.</b></p>



**2021**

2021 онд	2021.05 сард	2021 онд	2021.12
<p><b>Е-хичээлийн сан баяжуулах ажлыг тасралтгүй гүйцэтгэсэн.</b></p>	<p>ТАБ-ын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх <b>тусгай шалгалтыг</b> авч эхэлсэн.</p>	<p>Нийт давхардсан тоогоор 10 цахим сургалтаар 2704 албан хаагчийг сургасан.</p>	<p>Цахим сургалтын систем хөгжүүлэгч талтай <b>2021 оны гэрээний биелэлтийг дүгнэсэн.</b></p>

**2022**

2022 онд	2022 сард	2022.04 сард	2022.05 сард	2022.06 сард
<p><b>Е-хичээлийн сан баяжуулах ажлыг тасралтгүй гүйцэтгэж байна.</b></p>	<p>ТАБ-ын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх <b>тусгай шалгалтууд</b> авч байна.</p>	<p>Гадаад сургалтын санг бэлтгэв. 60 цагийн видео хичээл, 600 хуудас сургалтын унших материал.</p>	<p>Цахим сургалтын систем хөгжүүлэгч талаар <b>2 модуль хөгжүүлэлт</b> хийлгэх нэмэлт ажлыг эхлүүлээд байна.</p>	<p><b>Мэдээлэл, судалгаа болон гадаад сургалтын модулийн хөгжүүлэлтийн ажил дууссан.</b></p>



Гэрээний 3.7-д зааснаар системийг ажлын даалгавар, шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, эх код, системийн гарын авлага, бусад шаардлагатай бичиг баримтын хамт хүлээн авч, ҮАГ-ын бүрэн өмчлөлд шилжүүлэх ажил ТАБ-ын 2022 болон 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжсэн. Тус төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/99 дугаар тушаалаар “Онлайн сургалтын мэдээллийн систем хөгжүүлэх, цахим сургалтыг зохион байгуулах гэрээ” /ҮАГ-БҮА2019-34/ дугаартай гэрээний биелэлтийг дүгнэх, онлайн сургалтын LMS систем ба түүний сургалтын удирдлагын мэдээллийн дэд системийг хүлээн авах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан сургалтын системийг хүлээн авсан.

Систем хөгжүүлэгч талд 2022 онд өгсөн санал, түүний биелэлт, үнэлгээг өмнөх онуудтай харьцуулан дараах хүснэгтэд харууллаа.

№	Үзүүлэлтүүд	2020 он	2021 он	2022 он
1	Нэмэлт хөгжүүлэлт хийлгэхээр өгсөн нийт саналын тоо	77	25	36
2	Бүрэн хөгжүүлэлт хийгдэж дууссан саналын тоо	60	11	33
3	Системд хөгжүүлэлт хийгдэх боломжгүй саналын тоо	0	2	3
4	2 тал харилцан ярилцаж шийдвэрлэхээр хойшлуулсан саналын тоо	7	2	0
5	Тухайн жилд бүрэн хийгдэж дуусгаагүй, хэрэгжүүлэлтийн шатанд байсан саналын тоо	10	10	0
6	Өгсөн нийт саналын хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээ	98%	90.7%	100%

Гэрээний 3 жилийн хугацаанд системд хэрэглэгчийн шаардлага буюу нэмэлт хөгжүүлэлтийн нийт 138 санал өгснөөс 104 санал нь тухайн жилдээ бүрэн хөгжүүлэлт хийгдсэн. Үлдсэн 34 саналаас 9 саналыг 2 тал харилцан ярилцаж шийдвэрлэсэн, 20 санал нь тухайн жилдээ бүрэн хийгдэж дуусгаагүй дараа жилд хийгдэж дуусгасан. Үлдсэн 5 санал нь системд нэмэлт хөгжүүлэлт хийгдэх боломжгүй санал байсан буюу нийг өгсөн 138 саналаас 133 санал нь бүрэн хэрэгжсэн байна.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Цахим сургалтын системийг бий болгох

Цахим сургалтын системийг ажлын даалгавар, шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, эх код, системийн гарын авлага, бусад шаардлагатай бичиг баримтын хамт хүлээн авч, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/99 дугаар тушаалаар “Онлайн сургалтын мэдээллийн систем хөгжүүлэх, цахим сургалтыг зохион байгуулах гэрээ” /ҮАГ-БҮА2019-34/ дугаартай гэрээний биелэлтийг дүгнэх, онлайн сургалтын LMS систем ба түүний сургалтын удирдлагын мэдээллийн дэд системийг хүлээн авах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан сургалтын системийг хүлээн авч, Төрийн аудитын байгууллагын сургалтын үйл ажиллагааг бүрэн цахимжуулсан байна.

## ЗОРИЛТ 6: Төрийн аудитын байгууллагын дотоод засаглал, дэмжих үйлчилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоог төгөлдөржүүлэх зорилтын хэрэгжилт

№	Зорилт	Гүйцэтгэлийн хэмжүүр	2019	2020	2021	2022	2023	2024*
1.6.1	Төрийн аудитын байгууллагын дэмжих үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх	Аудитын үйл ажиллагааг чанартай, үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгө, санхүү, хүний нөөцийг бүрдүүлж, ажиллах нөхцөл бололцоогоор хангасан байна.	42	37	13	14	12	10
1.6.2	Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх	ISO-г үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн байна		2	3	1	1	2
1.6.3	Төрийн аудитын байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийх зааврыг боловсруулах, гарч болох эрсдэлийг үнэлэх тогтолцоо бий болгох	Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ, мониторинг хийх заавар гарсан байна.				1	1	2
1.6.4	Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн үнэлгээ хийх, үнэлгээгээр гарсан эрсдэлийг сааруулах буюу хариу арга хэмжээг төлөвлөх	Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ, мониторинг хийсэн байна.			1	3	3	3
1.6.5	Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын ёс зүйг дээшлүүлэх, шударга байдлын тогтолцоог бий болгож төлөвшүүлэх	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шударга байдлын журам батлагдсан байна.		1	2	3	3	5
1.6.6	Төрийн аудитын байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээний бүтцийг бий болгож, тогтолцоог төлөвшүүлэх	Хяналт-шинжилгээ, үнэлгээний бүтцийг бий болгосон байна.		9	7	18	10	5
			42	49	26	40	30	27

**ЗОРИЛТ 1.6.1:** Төрийн аудитын байгууллагын дэмжих үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

### **СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН :** Төрийн аудитын байгууллагын дэмжих үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Төрийн аудитын байгууллагын дотоод үйлчилгээний талаарх албан хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ

#### **ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Монгол улсын төсвөөс 2019 оны төсвийн жилд Монгол Улсын Ерөнхий аудиторын төсвийн багцад урсгал зардалд 14.0 тэрбум, хөрөнгийн зардалд 1.5 тэрбум, нийт 15.5 тэрбум төгрөгийн батлагдсан төсвийн хүрээнд үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан.

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11 -д заасны дагуу Төрийн аудитын байгууллагын 2020 оны төсөвт урсгал санхүүжилтэд 20.7 тэрбум, хөрөнгийн зардалд 1.0 тэрбум, нийт 21.7 тэрбум төгрөг батлагдсан байна. Төсвийн гүйцэтгэлээр 20.4 тэрбум төгрөг буюу 93.6 хувийг зарцуулж 1.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны төсвийн урсгал зардалд 25.4 тэрбум, хөрөнгийн зардалд 1.5 тэрбум, нийт 26.9 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг хангаж өгсөн.

Монгол улсын төсвөөс 2022 оны төсвийн жилд Монгол Улсын Ерөнхий аудиторын төсвийн багцад урсгал зардалд 23.6 тэрбум, хөрөнгийн зардалд 1.5 тэрбум, нийт 25.1 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөгдсөн бөгөөд Төрийн аудитын байгууллага батлагдсан төсвийн хүрээнд үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллав

Монгол Улсын Ерөнхий аудиторын төсвийн багцад хамаарах 23 төсвийн шууд захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, анхан шатны баримт материал болон холбогдох бусад санхүүгийн баримт бичгийн хамт “Мишээл-Од аудит” ХХК-д хүлээлгэн өгч төсвийн цаглаварт хугацаанд аудитын дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгэж байна

### **ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ**

**ХҮРЭХ ҮР ДҮН :** Аудитын үйл ажиллагааг чанартай, үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгө, санхүү, хүний нөөцийг бүрдүүлж, ажиллах нөхцөл бололцоогоор хангасан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын төсвийн багцад хамаарах 23 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд “Грант Торнтон Аудит” ХХК, “Мишээл-Од аудит” ХХК-д хүлээлгэн өгч төсвийн цаглаварт хугацаанд аудитын ажлыг гүйцэтгэж, “Зөрчилгүй дүгнэлтийг өгсөн болно.



**ЗОРИЛТ 1.6.2:** Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх**СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН** : Төрийн аудитын чанарын хяналтын болон чанарын баталгаажуулалтын тогтолцоо бүрдсэн харин Төрийн аудитын байгууллагын дотоод үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоо байхгүй

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Чанарын удирдлагын тогтолцооны стандартын шаардлага

**ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Үндэсний аудитын газрын дотоод үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг төлөвлөгөөнд тусгаад хэрэгжүүлж байна. Төрийн аудитын байгууллагын Чанарын менежментийн тогтолцооны бодлого батлагдсан. Чанарын хороо, Хэрэгжүүлэлтийн баг, Чанарын менежментийн багууд батлагдаж, багуудын ажиллах журам батлагдсан хэрэгжүүлсэн.

Мөн Төрийн аудитын байгууллагын цахим сургалтын системээр Чанарын менежментийн тогтолцооны стандартын хэрэглээгээр сургалтын материал бэлтгэн олон нийтэд сургалтыг зохион байгуулан, үнэлгээ хийгдэж байна. хүрээнд хийгдэж буй ажлуудыг тухай бүр эйбл олон нийт цэсэд байршуулж мэдээлэл түгээж ажилласан. Нийт 14 удаа стандарттай холбоотой эйбл мэдээг бэлтгэж олон нийтэд түгээсэн байна

Төрийн аудитын үйл ажиллагааг хараат бусаар, олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн эрсдэлд суурилан хэрэгжүүлж, байгууллагын чадамжийг тасралтгүй сайжруулах замаар хэрэглэгчийн хэрэгцээ ба хүлээлтийг хангахыг зорьж ажиллана. Чанарын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр жил бүр дэвшүүлэх зорилтуудын ерөнхий чиглэл:

- 2.1.Хараат бус байдлыг хангах
- 2.2.Стандартын тохирлын байдлыг дээшлүүлэх
- 2.3. Эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх
- 2.4. Хүний нөөцийн чадамжийг сайжруулах
- 2.5. Нөөцийн бэлэн байдлыг хангах
- 2.6. Чанарын хяналтыг сайжруулах
- 2.7. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх

**ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ**

**ХҮРЭХ ҮР ДҮН** : ISO-г үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн байна

Төрийн аудитын байгууллагын Үндэсний аудитын газарт Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001-2015 стандартыг бүрэн нэвтрүүлж, гэрчилгээ дотоод аудит хийж, гэрчилгээ баталгаажуулах ажлыг гүйцэтгүүлээ.

**ЗОРИЛТ 1.6.3:** Төрийн аудитын байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийх зааврыг боловсруулах, гарч болох эрсдэлийг үнэлэх тогтолцоо бий болгох

### **СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН :** Төрийн аудитын байгууллагын дотоод засаглалд эрсдэлийн үнэлгээ хийж байгаагүй

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийсэн тайлан

### **ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Төрийн аудитын байгууллагын дотоод үйл ажиллагаанд эрсдэлийн үйл явцыг удирдах тогтолцоог бий болгох ажлыг 2021-2023 онуудад 3 үе шаттай хэрэгжүүлсэн. Төрийн аудитын байгууллагын эрсдэлийг удирдах үйл явцын эрх зүйн орчныг бий болгох ажлууд хийгдсэн. Үүнд: “Төрийн аудитын байгууллагын эрсдэлийн үнэлэх заавар”-ыг шинээр боловсруулж, үүнтэй уялдуулан “Төрийн аудитын байгууллагын дотоод аудитын журам-ыг шинэчлэн боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/98, А/97 тоот тушаалаар Улсын Ерөнхий аудитор тус тус батлуулсан.

Эрсдэлийн үнэлгээ хийх зааврын онцлог давуу тал нь: Эрсдэлийн удирдлагыг “Эрсдэлийг удирдах үйл явц” ба “Эрсдэлийн удирдлагын хүрээ” гэсэн хоёр хэмжээст нэгдмэл үйл явц гэж тодорхойлсон. Эрсдэлийг үр дүнтэй удирдахад эрсдэлийн орчин хүрээ чухал ач холбогдолтой гэж үзэн удирдлагын манлайлал ба дэмжих чиг үүргийг тусгаж, үр дүнд шинжилгээ хийж үнэлэх заалт тусгасан. Эрсдэлийн удирдлагын ISO 31000:2018 стандартад үндэслэн эрсдэлийг удирдах үйл явцын зураглалыг гаргаж, үйл явцыг (алгоритм) алхам алхмаар тодорхойлсон. Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө, дотоод аудитын жилийн төлөвлөгөө, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, эдгээр төлөвлөгөө хоорондын уялдааг хангасан.

2023 оны байдлаар Төрийн аудитын байгууллагад давхардсан тоогоор 1500 эрсдэл, давхардаагүй тоогоор 12 ангилалд 200 эрсдэл бүртгэгдсэн бөгөөд зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн эрсдэл бууруулах төлөвлөгөөнд тусгах “Дунд” үнэлгээтэй 56 эрсдэлийн жагсаалт, Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөнд тусгах “Өндөр” үнэлэгдсэн 44 эрсдэлийн жагсаалт гарсан байна.

2021 онд ТАБ-ын эрсдэлийг удирдах үйл явц “Үүсгэн байгуулах” 1 дүгээр түвшинд байсан. Энэ талаар Төрийн аудитын байгууллагын 2022 онд хийсэн Түншийн үнэлгээний тайланд “Дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээний газраас 2021, 2022 онд Үндэсний аудитын газрын үйл ажиллагаа, тогтолцоонд дүн шинжилгээ хийж, доголдлыг илрүүлэх, системийн төлөв байдлын түвшнийг тогтоох, үр дүнд тулгуурлан тодорхой шийдэл санал болгох зорилгоор системийн шинжилгээ хийжээ.

Дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээний газар нь 2023 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд ТАБ-ын эрсдэлийн үнэлгээний журам, үнэлгээний арга зүйн удирдамжийг боловсруулахаар төлөвлөжээ. Үүний дагуу 2023 онд ТАБ-ын эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоотой болох юм” гэж дурдсан байна. Түншийн үнэлгээний тайланд дурдсаны дагуу 2023 онд эрсдэлийг удирдах эрх зүйн орчныг бий болгож, эрсдэлийн үнэлгээний заавар, үнэлгээний арга зүйн удирдамжийг боловсруулснаар эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоотой болох, “Хөгжиж байгаа” түвшинд хүрэх суурь тавигдсан.

Үндэсний аудитын газрын үйл ажиллагаанд Австрали улсын Үндэсний аудитын газар болон Индонез Улсын Аудитын зөвлөл хамтран түншийн үнэлгээний тайланд: Дотоод аудит хяналт-шинжилгээ үнэлгээний Үндэсний аудитын газрын нэгжүүд болон орон нутаг дахь төрийн аудитын газруудад дотоод хяналтын хэрэгжилт, эрсдэлийн түвшнийг дүгнэсэн эрсдэлийн үнэлгээг хийсэн. Дотоод аудитаас зургаан аймгийн төрийн аудитын газар болон Үндэсний аудитын хоёр газарт эрсдэлийн үнэлгээг хийсэн байна.

Энэхүү эрсдэлийн үнэлгээний тайлангаар үнэлгээнд хамрагдсан Үндэсний аудитын газрын холбогдох нэгжүүд болон орон нутаг дахь төрийн аудитын газруудын дотоод хяналтын хэрэгжилт, хэрэгжилттэй холбоотой гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлсон эсэхийг үнэлсэн байна. Эдгээр тайланд дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг бууруулах зөвлөмжийг мөн өгсөн” талаар дурдсан байна.

## ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН** : Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ, мониторинг хийх заавар гарсан байна.

2023 онд дээрх судалгаануудад үндэслэн Төрийн аудитын байгууллагын эрсдэлийг удирдах үйл явцын эрх зүйн орчныг бий болгох ажлууд хийгдсэн. Үүнд: “Төрийн аудитын байгууллагын эрсдэлийн үнэлэх заавар”-ыг шинээр боловсруулж, үүнтэй уялдуулан “Төрийн аудитын байгууллагын дотоод аудитын журам-ыг шинэчлэн боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/98, А/97 тоот тушаалаар Улсын Ерөнхий аудитор тус тус батлуулсан.

Эрсдэлийн үнэлгээ хийх зааврын онцлог давуу тал нь: Эрсдэлийн удирдлагыг “Эрсдэлийг удирдах үйл явц” ба “Эрсдэлийн удирдлагын хүрээ” гэсэн хоёр хэмжээст нэгдмэл үйл явц гэж тодорхойлсон. Эрсдэлийг үр дүнтэй удирдахад эрсдэлийн орчин хүрээ чухал ач холбогдолтой гэж үзэн удирдлагын манлайлал ба дэмжих чиг үүргийг тусгаж, үр дүнд шинжилгээ хийж үнэлэх заалт тусгасан. 2024-2025 онуудад эрсдэлийг удирдах үйл явцыг “Тогтворжсон түвшин”-д хүргэх, эрсдэлийг удирдах соёлыг төлөвшүүлэх, эрсдэлийн программ ашиглалтад оруулах, мэдээллийн сан үүсгэх ажлууд хийхээр төлөвлөж байна.

**ЗОРИЛТ 1.6.4:** Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн үнэлгээ хийх, үнэлгээгээр гарсан эрсдэлийг сааруулах буюу хариу арга хэмжээг төлөвлөх

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** Төрийн аудитын байгууллагын дотоод засаглалд эрсдэлийн үнэлгээ хийж байгаагүй

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийсэн тайлан, түүний зөвлөмжийн хэрэгжилтийн хувь

#### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2021 онд байгууллагын төлөв байдал, түүний орчныг судлах ажлууд хийгдсэн. Үүнд: Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд бүхэлд нь тогтолцоо шинжилгээний арга ашиглан системийн шинжилгээ хийсэн. ТАБ-ын эрх зүй, зохион байгуулалт, бүтэц, стратеги, зорилго, үүрэг хариуцлага, гүйцэтгэл, үнэлгээ, эргэх холбоо, мэдээллийн урсгал зэрэг үйл ажиллагааг хамруулан, тогтолцооны төлөв байдал, түвшнийг тогтоосон.

2022 онд Төрийн аудитын байгууллагын эрсдэлийн суурь үнэлгээний ажлууд хийгдсэн. Үүнд: Нийт 60 асуулт бүхий нээлттэй асуулгаар эрсдэлийн бүртгэл хийсэн. 2022 онд давхардсан тоогоор 922 эрсдэл бүртгэгдэж, үүнийг бүлэгдэн 85 эрсдэлийн жагсаалт үүсгэсэн. Энэ бүртгэлд үндэслэн хамгийн өндөр үзүүлэлттэй эрсдэлийг нягталж, Төрийн аудитын газруудын дарга, аудитын менежер, ахлах аудитортай ярилцлага хийж, дахин 4 удаа нарийвчилсан судалгааны ажлууд хийгдсэн. Эндээс “Аудиторын ажлын ачаалал, түүнд нөлөөлөх хүчин зүйл”, “Аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйл”-ийн судалгаа хийгдэж, Төрийн аудитын байгууллагын онол практикийн бага хурлын ажлын хэсэгт хүргүүлж, хэлэлцүүлсэн.

2023 онд Үндэсний аудитын газарт ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн. Стандартыг нэвтрүүлэх Зөвлөх үйлчилгээ үзүүлэх багийн зүгээс чанарын менежментийн тогтолцооны хүрээнд нийт 58 үйл явц, үүнээс удирдлагын үйл явц-6, үндсэн үйл явц-35, дэмжих үйл явц-17 байхаар тодорхойлж, “ISO үйл явцын зураглал”-д шинжилгээ хийж, 110 эрсдэлийг хамруулан шинжлэн үзэхэд эдгээрийн ихэнх нь өмнө бүртгэгдэж байсан (давхардсан) эрсдэлд хамрагдаж байсан бөгөөд мэдээлэл баримтжуулахтай холбоотой эрсдэл шинээр тогтоогдсон байна.

### ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН :** Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ, мониторинг хийсэн байна.

Төрийн аудитын байгууллагын бүтцэд эрсдэлийн удирдлагын асуудлыг хариуцсан чиг үүрэг, бүтцийн нэгжийг байгуулсан. Тус нэгж нь Төрийн аудитын байгууллагын зарим нэгжийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ, мониторинг хийж тайлагнасан бөгөөд дотоод эрсдэлийг удирдах чиглэлээр тодорхой ажлыг төлөвлөн ажиллаж эхлээд байна.

**ЗОРИЛТ 1.6.5:** Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын ёс зүйг дээшлүүлэх, шударга байдлын тогтолцоог бий болгож төлөвшүүлэх

**СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**СУУРЬ ТҮВШИН :** Төрийн байгууллагад мөрдөх ёс зүйн дүрэмтэй, албан хаагчид нь ёс зүйн баталгаа гаргадаг

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Төрийн аудитын байгууллагын шударга байдлын үнэлгээ

**ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**


Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн байгуулагдав. Зөвхөн удирдах албан тушаалтнууд бус шат шатны төлөөллөөс бүрдсэн багийг бүрдүүлж, зөвлөлийн үйл ажиллагааг жил бүр төлөвлөн, үр дүнг тайлагнаж байна.



Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны АБЗ дугаар тушаалээр батлагдсан Төрийн аудитын байгууллагын ёс зүйн ажиллах журмын 1.4, 1.6, Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг сонгох техникийн ажлын хэсгийн тэмдэглэл, Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай:

Гишүүд	Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай
Я.Самбууням	-Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор;
Ц.Наранчимэг	-Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор;
Б.Бундхорол	-Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор;
С.Оюунгэрэл	-Чанарын баталгаажуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор;
Х.Баярмаа	-Аудитын гуравдугаар газрын аудитын менежер;
Б.Өлзий	-Чанарын баталгаажуулалтын газрын ахлах аудитор;
Б.Лхагвацэнд	-Аудитын дөрөвдүгээр газрын ахлах аудитор;
Ц.Бат-Өлзий	-Нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитын нэгдүгээр хэлтсийн дарга, аудитын менежер;
Х.Наранцарал	-Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер;



Төрийн аудитын байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэн үр дүн	Хариуцах албан хаагч	Дэмжлэг үзүүлэх газар
1	Ёс зүйн зөвлөлийн жилийн үйл ажиллагааны боловсруулалт батлах	01 дүгээр сарын 10-ны дотор	Төлөвлөгөөг баталсан байх	Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна	Зөвлөлийн дарга З.Төвөрбаатар	
2	Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цахим мэдээлэл, батлага нийт албан хаагчдад хүргэхэд тууштай	01 дүгээр сарын 25-ны дотор	Цахим мэдээллийг нийт албан хаагчдад хүргэсэн байх	Нийт албан хаагчид мэдээлэлээр хангагдсан байна	Ц.Бат-Өлзий Б.Өлзий	МТТ ХХАГ
3	Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор цахим сургалт зохион байгуулах	Эцэст хөгжсөж	Тайланг хуваарьна цахим сургалт зохион байгуулсан байх	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн зөрчил гарсаггүй байх нөхцөл бүрдсэн	Зөвлөлийн дарга	ХСГТ
4	Сонгох нийт, шалтгаалч эгцээрээ илүүдсэн албан хаагчид ёс зүйн холбоотой санал, хүсэлтийг хүлээн авч нэгтгэн дүгнэх	Жигдээ	Санал, хүсэлт хүлээн авч нөхцөл болгодог хангагдсан байх	Ёс зүйтэй холбоотой санал, хүсэлтийг хүлээн авч нэгтгэн дүгнэсэн байна	Б.Өлзий Б.Лхагвацэнд Ц.Бат-Өлзий	МТТ ЗУГ
5	Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй сургалтад хамруулах хамтсан сургалт хэлэлцүүлэх зохион байгуулах	Жигдээ	Тайланг хуваарьна цахим сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, хамруулсан байх	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн зөрчил гарсаггүй байх нөхцөл бүрдсэн	Ц.Наранчимэг Я.Самбууням Х.Наранцарал	ЗУГ ХХАГ

Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг шинэчилэн боловсруулж хэлэлцэн батлав.

**ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ**

**ХҮРЭХ ҮР ДҮН :** Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шударга байдлын журам батлагдсан байна.

Төрийн аудитын байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа төлөвшсөн бөгөөд нийт албан хаагчдад ёс зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, хэлэлцүүлгийг тасралтгүй зохион байгуулан соён гэгээрүүлэх ажлыг үр дүнтэй хийсний үр нийт албан хаагчдад ёс хариуцлагын зөрчил 2019-2023 онд илрээгүй байна.



**ЗОРИЛТ 1.6.6:** Төрийн аудитын байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээний бүтцийг бий болгож, тогтолцоог төлөвшүүлэх

### СУУРЬ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**СУУРЬ ТҮВШИН :** МУЕА-ын дэргэд дотоод аудитор үйл ажиллагаа явуулж, тайлагнадаг

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Төрийн аудитын байгууллагын дотоод засаглалыг хөгжүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмж, түүний хэрэгжилтийн хувь

#### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/02 дугаар тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын чиг үүрэг, 13 орон тоотой ажиллахаар баталсан. МУЕА-ын 2022 оны А/68 дугаар тушаалаар Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар болгон өөрчилж 12 хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар баталсан.

Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр дараах хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг жил төлөвлөн хэрэгжүүлж хэвшсэн байна. Тухайлбал;

- Төрийн аудитын байгууллагын 2021 оны үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ;
- Төрийн аудитын байгууллагын сургалт хөгжлийн стратегийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ;
- Харилцагч талуудын оролцооны стратегийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ;
- Төрийн аудитын байгууллагын болон Үндэсний аудитын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ;
- Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ;
- Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ;
- Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан удирдамжийн дагуу аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит ;
- Удирдлагын шуурхай хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

### ХҮРСЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ХҮРЭХ ҮР ДҮН :** Хяналт-шинжилгээ, үнэлгээний бүтцийг бий болгосон байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/02 дугаар тушаалын дагуу ХШҮДАГ нь хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, эрсдэлийн удирдлагын бүтцийг зохин байгуулж, чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

**СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

3.1. Төрийн аудитын байгууллага стратегийн хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

3.2. Стратегийн хэрэгжилтийг Үндэсний аудитын газар удирдан зохион байгуулах ба стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэлэлцүүлнэ.

	2019-2020		2021-2022	
	Биелэлт %	Үнэлгээ %	Биелэлт %	Үнэлгээ %
1.1.1	100.0	40.0	100	70
1.1.2	100.0	100.0	100	100
	100.0	70.0	100.0	85.0
1.2.1	70.0	80.0	85	70
1.2.2	80.0	80.0	100	100
1.2.3	80.0	80.0	100	100
1.2.4	100.0	100.0	100	100
1.2.5	100.0	100.0	100	100
1.2.6	100.0	100.0	100	100
	88.3	90.0	97.5	95.0
1.3.1	50.0	50.0	100	70
1.3.2	-	-	100	70
1.3.3	50.0	50.0	80	70
1.3.4	80.0	80.0	80	70
1.3.5	80.0	80.0	100	100
	52.0	52.0	92.0	76.0
1.4.1	60.0	50.0	65	30
1.4.2	50.0	50.0	73	70
1.4.3.1	90.0	100.0	100	70
1.4.3.2	-	-	100	70
1.4.4	70.0	80.0	85	70
1.4.5.1	80.0	80.0	95	70
1.4.5.2	80.0	80.0	85	70
1.4.6	80.0	80.0	100	100
1.4.7	80.0	80.0	85	70
1.4.8	90.0	100.0	80	70
1.4.9	100.0	100.0	100	100
	70.9	72.7	88.0	71.8

	2019-2020		2021-2022	
	Биелэлт %	Үнэлгээ %	Биелэлт %	Үнэлгээ %
1.5.1	80.0	80.0	100	100
1.5.2	80.0	80.0	70	30
1.5.3	70.0	80.0	65	30
1.5.4	100.0	100.0	100	100
1.5.5	100.0	100.0	100	100
1.5.6	100.0	100.0	95	70
1.5.7	90.0	100.0	100	100
	88.6	91.4	90.0	75.7
1.6.1	80.0	80.0	98	70
1.6.2	30.0	-	65	30
1.6.3	-	-	50	30
1.6.4	-	-	50	30
1.6.5	60.0	50.0	80	70
1.6.6	80.0	80.0	100	30
	41.7	35.0	73.8	43.3
	73.6	68.5	90.2	74.5

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2 жил тутамд Хяналт-шинжилгээ, үнэлгээний газраар үнэлгээ хийлгэж, өгсөн зөвлөмжийг тухай бүр хэрэгжүүлэн хэрэгжилтэй удаашралтай ажлуудыг эрчимжүүлэх чиглэлийг баримтлан ажиллалаа.



Үндэсний аудитын газар  
Байршил:: Засгийн газрын IY байр  
Цахим шуудан: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)  
Харилцах утас: 976-62-263230